

ДЭЛХИЙ ДАХИНЫ

ХҮНИЙ ЭРХИЙН

ТӨЛӨВ БАЙДАЛ

2024 ОНЫ 4 ДҮГЭЭР САР



ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



Эмнести Интернэшнл нь хүн бүрд эрхийг нь эдлүүлэхийн төлөө хүмүүсийн хүнлэг сэтгэлд тулгуурлан кампанит ажил өрнүүлдэг 10 сая хүнийг эгнээндээ нэгтгэсэн дэлхий даяарх хүний эрх хамгаалагчдын хөдөлгөөн юм.

Бид эрх баригчид олон улсын эрх зүй, хэм хэмжээг хүндэтгэдэг, хариуцлагаа хүлээдэг, амлалтдаа хүрдэг дэлхий ертөнцийг бий болгохын төлөө ажилладаг.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл суртал, эдийн засгийн ашиг сонирхол, шашин шүтлэгээс ангид бие даасан, хараат бус бөгөөд гишүүд дэмжигчдийнхээ хандив тусламжаар санхүүждэг. Хүмүүс эв санааны нэгдэлтэй, хүмүүнлэг энэрэнгүй байснаар илүү сайхан нийгмийг бий болгож, өөрчилж чадна гэдэгт бид итгэдэг.

© Эмнести Интернэшнл 2024

Энэ баримт бичгийн агуулга нь Creative Commons лицензтэй болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг вэб сайтаас үзнэ үү:

www.amnesty.org

Анхны хэвлэлт 2024 он

Эмнести Интернэшнл

Peter Benenson House, 1 Easton Street, London WC1X 0DW, UK

Индекс: POL 10/7200/2024

ISBN: 978-0-86210-509-9

Эх хэл: Англи

amnesty.org

amnesty.mn

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	2
ҮДИРТГАЛ	5
ДЭЛХИЙ ДАХИНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ	10
Зэвсэгт мөргөлдөөнд энгийн иргэдийг үл тоомсорлов	10
Арьс үндэс болон үндэс угсаагаар ялгаварлан гадуурхсан нь	12
Жендэрийн шударга ёсны эсрэг ухралт	14
Эдийн засгийн хямрал, уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар	16
Одоо хэрэглэгдэж байгаа болон шинээр нэвтэрч буй технологийн аюул	19
АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ	22
АМЕРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ	33
АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ТОЙМ	43
ЕВРОП, ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ	53
ОЙРХ ДОРНОД, ХОЙД АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ	66

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ASEAN –АСЕАН

Association of Southeast Asian Nations
Зүүн өмнөд Азийн орнуудын хамтын
нийгэмлэг

AU –АХ

African Union -Африкийн холбоо

BRICS summit

БРИКС-ийн дээд хэмжээний уулзалт

The annual conference of the BRICS
(Brazil, Russia, India, China and South
Africa) group of nations
БРИКС (Бразил, Орос, Энэтхэг, Хятад,
Өмнөд Африк)-ийн ээлжит бага хурал

CEDAW –ЭАБХУК

UN Convention on the Elimination of All
Forms of Discrimination against Women
НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх
хэлбэрийг устгах тухай конвенц

CEDAW Committee –ЭЭЯГУ Хороо

UN Committee on the Elimination of
Discrimination against Women
НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг
ялгаварлан гадуурхалтыг устгах хороо

CERD –АӨАБХУОУК

International Convention on the
Elimination of All Forms of Racial
Discrimination
Арьс өнгөөр алагчлах бүх хэлбэрийг
устгах тухай олон улсын конвенц

CERD Committee –АӨАҮУ хороо

UN Committee on the Elimination of
Racial Discrimination
НҮБ-ын Арьс өнгөөр алагчлах үзлийг
устгах хороо

CIA –ТТГ

US Central Intelligence Agency
АНУ-ын Тагнуулын төв газар

COP28 – COP28

The 28th Conference of the Parties
(COP) to the UN Framework Convention
on Climate Change
НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн
суурь конвенцийн Талуудын 28 дугаар
Бага хурал

ECOWAS –БАҮЭЗХН

Economic Community of West African
States
Баруун Африкийн улсуудын эдийн
засгийн хамтын нийгэмлэг

Escazú Agreement

Regional Agreement on Access to
Information, Public Participation and
Justice in Environmental Matters in Latin
America and the Caribbean
Латин Америк ба Карибын тэнгисийн
орнуудын хүрээлэн буй орчны
асуудлаарх мэдээллийн хүртээмж, олон
нийтийн оролцоо, шударга ёсны тухай
бүс нутгийн хэлэлцээр

EU – EX

European Union -Европын холбоо

European Committee for the Prevention of Torture

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Европын хороо

European Committee for the Prevention
of Torture and Inhuman or Degrading
Treatment or Punishment
Эрүүдэн шүүх, хүнлэг бусаар буюу нэр
төрийг доромжлон харьцах, шийтгэхээс
урьдчилан сэргийлэх Европын хороо

European Convention on Human Rights

Европын Хүний эрхийн конвенц

(European) Convention for the Protection
of Human Rights and Fundamental
Freedom

Хүний эрх, үндсэн эрх чөлөөг
хамгаалах Европын конвенц

GDP –ДНБ

Gross domestic product
Дотоодын нийт бүтээгдэхүүн

ICC –ОУЭШ

International Criminal Court
Олон улсын Эрүүгийн Шүүх

ICCPR –ИУТЭОУП

International Covenant on Civil and
Political Rights
Иргэний Болон Улс Төрийн Эрхийн
Тухай Олон Улсын Пакт

ICESCR –ЭЗНСЭОУП

International Covenant on Economic,
Social and Cultural Rights
Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн
Тухай Олон Улсын Пакт

ICRC –ОУУЗХ

International Committee of the Red Cross
Олон улсын Улаан Загалмайн Хороо

ILO –ОУХБ

International Labour Organization
Олон улсын Хөдөлмөрийн Байгууллага

**International Convention against
Enforced Disappearance**

**Хүчээр Алга Болгохын эсрэг Олон
Улсын Конвенц**

International Convention for the
Protection of All Persons from Enforced
Disappearance

Хүчээр Алга Болгохоос Бүх Хүнийг
Хамгаалах тухай Олон Улсын Конвенц

LGBTI –ЛГБТИ

Lesbian, gay, bisexual, transgender and
intersex

Лесбиян, гей, бисексуал, трансгендэр,
интерсекс

NATO –НАТО

North Atlantic Treaty Organization
Умард Атлантын Гэрээний Байгууллага

NDC

Nationally determined contribution
Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь
нэмэр

NGO –ТББ

Non-governmental organization
Төрийн бус байгууллага

OAS –АУБ

Organization of American States
Америкийн улсуудын байгууллага

ОСНА –ХЭЭГ

United Nations Office for the
Coordination of Humanitarian Affairs
Нэгдсэн Үндэстний Байгууллагын
Хүмүүнлэгийн Хэрэг Эрхлэх Газар

ОНЧНР –ХЭДКГ

Office of the United Nations High
Commissioner for Human Rights
НҮБ-ын Хүний Эрхийн Дээд
Комиссарын Газар

OSCE –ЕАБХАБ

Organization for Security and Co-
operation in Europe
Европын Аюулгүй Байдал, Хамтын
Ажиллагааны Байгууллага

UK –ИБ

United Kingdom
Их Британи /Их Британи Умард
Ирландын Нэгдсэн Вант Улс/

UN –НҮБ

United Nations
Нэгдсэн Үндэстний Байгууллага

UN Convention against Torture

**НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг
конвенц**

Convention against Torture and Other
Cruel, Inhuman or Degrading Treatment
or Punishment

Эрүүдэн Шүүх болон бусад Хэлбэрээр
Хэрцгий, Хүнлэг бусаар буюу Хүний
Нэр Төрийг Доромжлон Харьцаж,
Шийтгэхийн Эсрэг Конвенц

UN Refugee Convention

НҮБ-ын Дүрвэгсдийн тухай конвенц

Convention relating to the Status of
Refugees

Дүрвэгсдийн Эрх зүйн байдлын тухай
Конвенц

**UN Special Rapporteur on climate
change**

Уур амьсгалын өөрчлөлтийн

асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on the promotion
and protection of human rights in the
context of climate change

Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд
хүний эрхийг дэмжих, хамгаалах
асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on extrajudicial executions

НҮБ-ын хууль бусаар цаазаар авах ялын асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on extrajudicial, summary or arbitrary executions
НҮБ-ын хууль бусаар, дур мэдэн, олноор цаазаар авах асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on extreme poverty

НҮБ-ын нэн ядуурлын асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on extreme poverty and human rights
НҮБ-ын нэн ядуурал ба хүний эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on freedom of expression

НҮБ-ын Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх тусгай илтгэгч

UN Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression
НҮБ-ын үзэл санаа, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих, хамгаалах асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on racism

НҮБ-ын Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on contemporary forms of racism, racial discrimination, xenophobia and related intolerance
НҮБ-ын Ялгаварлан гадуурхах, арьс өнгөөр алагчлах, жигших, үл тэвчих орчин үеийн хэлбэрийн асуудлаарх Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on torture

НҮБ-ын эрүүдэн шүүхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч
UN Special Rapporteur on torture and other cruel, inhuman or degrading treatment or punishment
НҮБ-ын эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг асуудал Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on violence against women

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special rapporteur on violence against women, its causes and consequences
НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан, үр дагаврын асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UNESCO – ЮНЕСКО

United Nations Educational, Scientific and Cultural Organization
НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага

UNHCR, the UN refugee agency

ДДКГ, НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссар
Office of the United Nations High Commissioner for Refugees
НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал Эрхэлсэн Дээд Комиссарын Газар

UNICEF– ЮНИСЕФ

United Nations Children’s Fund
НҮБ-ын Хүүхдийн сан

UPR –ЭДХ

UN Universal Periodic Review
НҮБ-ын Ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг

USA –АНУ

United States of America
Америкийн нэгдсэн улс

WHO –ДЭМБ

World Health Organization
Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

УДИРТГАЛ

Өнөөгийн хүний эрхийн нөхцөл байдал намайг 1980-аад оны үед дэлгэцнээ гарсан “Ирээдүй рүү аялсан нь” шинжлэх ухааны уран зөгнөлт киног эшлэхэд хүргэнэ хэмээн төсөөлж ч байсангүй. Гэвч бид яг тэр кинонд гардаг шиг нөхцөл байдалд хэдийнэ иржээ. Дэлхийн мэдээлэл технологийн томоохон компаниуд болон зохицуулалтгүй үүсгэгч хиймэл оюун ухаан ирээдүй рүү асар хурдацтай урагшилж байхад 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан хүний эрхийн хэрэгжилт эрчимтэй муудаж байна.

ӨСӨН НЭМЭГДЭЖ БҮЙ ЗАХИРГААДАЛТ

2023 онд Ви-Дэм улс төрийн шинжлэх ухааны судалгааны төв ардчилсан нийгэмд (өргөн утгаар нь хууль тогтоох болон шүүх эрх мэдлийн байгууллага гүйцэтгэх эрх мэдлийг хязгаарладаг, иргэний эрх чөлөөг дээдэлдэг, эрх зүйт ёс бүхий улс гэж тодорхойлдог) амьдарч буй хүмүүсийн тоо 1985 оны түвшинд хүртэл буюу Берлиний хана нурахаас өмнөх, Нелсон Мандела шоронгоос суллагдахаас өмнөх, хүйтэн дайн дуусаж хүн төрөлхтний шинэ эрин үе эхлэнэ гэсэн итгэл найдвар бий болж байхаас өмнөх үе хүртэл буурсан болохыг тогтоожээ.

Гэвч дээрх шинэ эрин үе дэндүү богинохон байсан бөгөөд өмнөх сайхан зүйлс хэдийнэ үгүй болжээ. Энэ бүхэн үгүй болж байгааг харуулах нотолгоо 2023 онд улам бүр нэмэгдэв. Улс орнууд болон нийгэмд захиргаадах үйл явц, үзэл санаа улам бүр тархсаар байна. Захиргаадалтын бодлого нь дэлхийн бөмбөрцгийн хойноос урагшаа, зүүнээс баруун тийш үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг үгүй хийж, жендэрийн тэгш байдал, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг алдагдуулж байна.

Үзэн ядалтад үндэслэсэн, айдаст суурилсан олон нийтийг айлгах зорилготой “зохиол” нь иргэний орон зайд халдаж, гадуурхагдсан хувь хүн, бүлгүүдийг улам заналхийлж байгаагийн үр дагаврыг дүрвэгсэд, цагаачид, арьс өнгөөр ялгаварлан гадуурхагдсан бүлгүүд илүүтэй амсаж байна.

Эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдлыг үгүйсгэх байдал 2023 онд улам эрчимжиж, сүүлийн 20 жилийн ололт амжилтын ихэнх нь аюулд өртөв.

Афганистанд эмэгтэй, эсхүл охин байсных нь төлөө бодитоор буюу дэфакто ял шийтгэж байна. 2023 онд Талибанчууд эмэгтэйчүүдийг нийгмийн идэвхтэй амьдралд оролцуулахгүй байх зорилгоор олон арван албан ёсны тогтоол гаргасан. Үүний нэгэн адил Иран улсын эрх баригчид «Эмэгтэйчүүд, Амьдрал, Эрх чөлөө» уриа бүхий эсэргүүцлийн жагсаалыг харгис хэрцгий хүч хэрэглэн таслан зогсоож, эмэгтэйчүүдийг «вирус», «нийгмийн эмгэг», «эмх замбараагүй байдал» хэмээн үзэн ядсан үг хэллэг бүхий албан ёсны мэдэгдлүүд гаргасан.

АНУ-ын 15 мужид үр хөндөлтийг бүхэлд нь хориглосон, эсхүл хориг үйлчлэхгүй байх маш хязгаарлагдмал үндэслэлийг тодорхойлсон нь хар арьстнууд болон бусад арьс үндсээр ялгаварлан гадуурхагдсан хүмүүст илүү сөргөөр нөлөөлсөн. Польш улсад үр хөндөлтийн үйлчилгээ авахыг хуулиар хориглосны улмаас дор хаяж нэг эмэгтэй нас баржээ. Угандад ижил хүйстнүүдийн эсрэг хатуу хууль баталсан бол АНУ-ын нийгмийн

болон улс төрийн удирдагчид трансжендэр хүмүүсийн эсрэг яриа хэлэлцүүлэг, бодлого, зохицуулалтыг улам дэмжсээр байна.

2023 онд дэлхийн улс орнуудын орлого урьд байгаагүй хэмжээнд хүрсэн хэдий ч Дэлхийн Банк өнгөрөгч оныг “Тэгш бус байдлын жил” хэмээн дүгнэсэн. Их Британи, Унгар, Энэтхэг зэрэг харилцан адилгүй нөхцөл байдал бүхий улс орнуудад эдийн засаг, нийгмийн эрхийг хамгаалагчид зэрэг идэвхтнүүдийг өргөн хүрээнд онилов. Уур амьсгалын идэвхтнүүдийг чулуужсан түлшний үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг өргөжүүлж буй засгийн газруудыг шүүмжилснийх нь төлөө «террорист» хэмээн цоллов. Ойрх Дорнодод засгийн газруудын эдийн засгийн зохицуулалтыг шүүмжлэгчдийг, Ази Номхон далайн бүс нутагт үйлдвэрчний эвлэлүүдийг, Баруун Африкт авлигатай тэмцэж буй хүмүүсийн дууг хоолойг нухчин дарж, дур зоргоор цагдан хорьсон.

1948 ОНООС ӨМНӨХ ҮЕД БУЦАХ УУ?

Гэвч дээр зүйрлэсэн цаг хугацааны машин 2023 онд биднийг 1985 оноос ч өмнөх байдалд ухрааж 1948 онд эгнэгт хаасан хэмээн үзэж байсан зовлонгийн хаалга руу хөтөлж байна. 55 сая энгийн иргэнийг хөнөөж, 6 сая еврей болон бусад олон сая хүний амь насыг сүйтгэсэн дэлхийн дайны дараа хүн төрөлхтөн «Дахин хэзээ ч дайтахгүй» гэдгээ дэлхийн даяар зарлан тунхагласан.

Гэсэн хэдий ч 2023 онд «дахиж хэзээ ч болохгүй» хэмээн зарласан ёс суртахууны болон эрх зүйн сургажлуудыг хэдэн сая хэсэг болгон хуваалаа. 2023 оны 10 дугаар сарын 7-нд Хамас бүлэглэлийн үйлдсэн аймшигт гэмт хэрэг буюу Израйлын энгийн иргэд голдуу 1000 гаруй хүний амь нас үрэгдэж, олон мянган хүн шархдаж, 245 орчим хүн барьцаалагдсаны дараа Израйл улс Палестинд хийсэн хариу цохилт нь Палестинчуудыг хамтаар нь шийтгэсэн кампанит үйл явдал болсон. Энэ бол энгийн иргэд болон иргэний дэд бүтцийг зориудаар, ялгаваргүйгээр бөмбөгдөх, хүмүүнлэгийн тусламжийг зогсоох, зохион байгуулалттай өлсгөлөнд нэрвэгдүүлэх кампанит ажил юм.

Газын зурвасыг тасралтгүй бөмбөгдсөний улмаас 2023 оны эцэс гэхэд Палестин голдуу 21,600 энгийн иргэний амь нас үрэгдэж, нурангид дарагдан олон мянган хүн сураггүй болжээ. Газын иргэний дэд бүтцийн ихэнх хэсэг сүйдэж, 1.9 сая орчим Палестинчууд дотооддоо дүрвэж, хоол хүнс, ус, орон байр, ариун цэврийн байгууламж, эмнэлгийн тусламж авах боломжгүй болжээ.

Өнөөдөр Газын зурваст Палестин хүн амьдарна гэдэг 750,000 гаруй Палестинчуудыг дүрвэхэд хүргэсэн 1948 оны «Накба» буюу «сүйрэл»-ээс хамаагүй илүү харгис хэрцгий, хор хөнөөлтэй нүүр тулгарахад хүргэж байна.

Дэлхий даяарх сая сая хүмүүсийн хувьд Газа дахь мөргөлдөөн нь Дэлхийн 2 дугаар дайны дараах тогтолцооны олон тооны төлөвлөлтийн ёс суртахууны алдаа болон түгээмэл байх туйлын амлалт, дахин дайтахгүй байх хүн төрөлхтний амлалтад хүрч чадаагүйг илтгэн харуулж байна. НҮБ-ын дүрэм, Женевийн конвенц, Төрлөөр устгахын эсрэг конвенц болон олон улсын хүний эрхийн хууль тогтоомжид бэхжүүлсэн зарчмуудыг бүдүүлгээр зөрчиж, үнэгүйдүүлж байна. Энэ нь Израйлын эрх баригчдын үйлдлээс тодорхой харагдаж байна. Гэвч Израйл энэ бүхнийг ганцаараа хийсэнгүй. Европын зарим удирдагчид, Европын Холбооны манлайллын нэгэн адил АНУ тэргүүлэх үүрэг гүйцэтгэсээр байна. Израйл руу зэвсэг илгээсээр байгаа, Израйлын удаан үргэлжилж буй зөрчилдөөнийг шүүмжлэн буруутгаж чадахгүй байгаа, мөн гал зогсоох уриалгыг няцаасан этгээдүүд ч мөн үүнд хамааралтай.

Тэдний энэ үйлдэл нь Эмнести Интернэшнл олон жилийн турш

буруушааж ирсэн давхар стандартын жишээ юм. Гэсэн хэдий ч тэргүүлэх гүрнүүд 1948 оны дүрэмд суурилсан дэг журмыг бүхэлд нь эрсдэлд оруулахад бэлэн байгаагаа харуулж, нийтлэг хүмүүнлэг, түгээмэл байдлын үндэслэгч зарчмуудыг устгаж, улмаар хамгийн муу зүйлээс урьдчилан сэргийлэх даян дэлхийн боломжийг үгүй хийж байна.

Энэ бүхэн нь Орос улс НҮБ-ын дүрмийг зөрчиж, олон улсын хууль дээдлэх ёсыг үл хүндэтгэн Украин улс руу бүрэн довтолгоо хийсний араас өрнөж байна. Оросын түрэмгийлэл нь энгийн иргэдийн эсрэг санаатай халдлага үйлдэх, олон мянган хүний амь насыг хөнөөх, Украины үр тарианы агуулах, экспортлох байгууламж зэрэг иргэний дэд бүтцийг өргөн хэмжээгээр сүйтгэх зэргээр илэрсээр байна.

НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн өөр нэг байнгын гишүүн болох Хятад улс ч Мьянмарын арми болон хууль бус агаарын довтолгооноос хамгаалахын тулд баривчлах, эрүүдэн шүүх, түүнчлэн олон улсын хууль тогтоомжийг зөрчин Уйгар үндэстний эсрэг хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг үйлдсээр байна.

БИДНИЙ ХҮСЭЭГҮЙ ИРЭЭДҮЙ

2023 онд ChatGPT (ChatGPT-4) болон бусад үүсгэгч хиймэл оюун ухааны хэрэгслүүдийг төсөөлж байснаас хамаагүй эрт ашиглалтад оруулснаар бид ирээдүй рүү улам хурдтай урагшилж байна. Хэрэв 2023 онд өрнөсөн технологитой холбоотой зөрчил энэ байдлаараа цаашид өрнөөл бидний ирээдүйн төлөв байдлыг төсөөлөхөд бэрх болно.

Технологи нь хүний эрхийг өргөн хүрээнд үгүй хийж, арьс үндсээр ялгаварлан гадуурхах бодлогыг үргэлжлүүлэн улам бүр гааруулж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж, ташаа мэдээлэл түгээх боломжийг олгож байна. Мэдээлэл, технологийн томоохон компаниуд Этиоп, Израйл, Палестины эзлэгдсэн нутаг дэвсгэр, Мьянмар, Судан зэрэг зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд байдалд ч гэсэн өөрийн үйл ажиллагааны хор хөнөөлийг үл тоомсорлож байна. Палестин болон еврейчүүдийн эсрэг цахим орчны өдөөн турхиралт, бусад хор хөнөөлтэй контентууд түгшүүрийн хэмжээнд хүртлээ өссөн бол Европ болон АНУ-д мөн мусульман шашны эсрэг болон еврейчүүдийг үзэн ядах гэмт хэрэг мэдэгдэхүйц нэмэгдсэн байна.

2023 онд улс орнууд олон нийтийн жагсаал цуглаан, спортын арга хэмжээнүүд, цагаачид, дүрвэгсэд гэх мэт гадуурхагдсан хүмүүстэй холбоотой цагдаагийн үйл ажиллагааны зорилгоор нүүр царай таних технологид улам бүр шилжиж байна. Шилжилт хөдөлгөөний засаглал болон хилийн хяналт шалгалтын үйл ажиллагаа нь технологи, мэдээллийн дүн шинжилгээ хийх программ хангамж, биометр, алгоритмын шийдвэр гаргах систем зэрэг хүчирхийллийн технологиос илүү хамааралтай болж байна.

Хүний эрхийг зөрчиж байгаа талаарх олон жилийн нотолгоог үл харгалзан тагнах программ зохицуулалтгүй хэвээр байв. 2023 онд Армен, Доминикан, Энэтхэг, Серби зэрэг орны сэтгүүлчид болон иргэний нийгмийн идэвхтнүүдийн эсрэг Пегасус(Pegasus) тагнах программыг ашигласан болохыг, ЕХ-д суурилсан тагнах программыг дэлхийн улс орнуудад худалдаалж байгааг Эмнести Интернэшнл ил болгосон. Үүний мөрөөр 2023 оны арваннэгдүгээр сард Европын Парламентаас тагнах программ хангамжийн салбарын хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээ авахгүй байгааг шүүмжилсэн тогтоол гаргасан.

Гэвч технологийн хууль бус этгээдүүд болон тэдний зүй бус технологиуд нь дижитал Зэрлэг Баруунд чөлөөтэй байгаа нь хүний эрхийн ийм төрлийн зөрчил 2024 онд буюу улс орнуудын сонгуулийн жилээр даамжрах төлөвтэй байна. Энэ бол бидний өмнө ирээд буй ирээдүйн

талаарх урьдчилсан шинж тэмдэг юм.

ДАЯН ДЭЛХИЙН ЭВ НЭГДЭЛ

2023 онд хүний эрхийн ухралтаас ангид байж чадсангүй. Эсрэгээрээ дэлхийн өнцөг булан бүрд байгаа хүмүүс энэхүү ухралтыг эсэргүүцэн урьд өмнө хэзээ ч байгаагүй хэмжээнд даян дэлхийн эв нэгдлийг харууллаа.

Олон сая энгийн иргэдийн амь насыг хохироосон Израил-ХАМАС-ын мөргөлдөөнд барьцаалагдсан хүмүүсийг суллахыг уриалж, гал зогсоохыг шаардсан олон зуун эсэргүүцлийн жагсаал дэлхий даяар өрнөлөө.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, НҮБ-ын салбар байгууллагуудын дарга нар болон хүмүүнлэгийн байгууллагууд Израйлын өмнөд хэсэг, Газын зурваст үйлдэгдсэн дайны гэмт хэргийг буруушааж, олон улсын хуулийг хүндэтгэхийг Израйлаас шаардсан урьд өмнө байгаагүй алхам хийсэн.

2023 оны сүүлээр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн гал зогсоох тогтоолуудыг олонхын саналаар баталсан бол Өмнөд Африк улс Газын зурвас дахь Израйлын үйл ажиллагааг 1948 оны Төрлөөр устгахын эсрэг конвенцыг зөрчсөн гэж үзэн Олон улсын шүүхийн өмнө өргөдөл гаргаж, дэлхийн хоёрдугаар дайны дараах олон улсын зохицуулалтад суурилсан тогтолцоонд төвлөрүүлэхийг шаардав.

2023 онд татвараас зугтах, зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх, орлого багатай орнуудад нөөцийг дайчлах зорилгоор дэлхийн шударга татварын дэглэмийг бий болгох хөдөлгөөний эрч улам бүр нэмэгдэв. Арваннэгдүгээр сард дэлхийн чинээлэг улс орнуудын эсрэг саналыг үл харгалзан НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2025 оны зургадугаар сар гэхэд НҮБ-ын татварын конвенцын төслийг боловсруулах олон улсын хороог байгуулах тухай Африкийн бүлгээс гаргасан тогтоолыг баталлаа.

2023 онд дэлхийг 1985 болон 1948 оноос өмнөх нөхцөл байдал рүү ухрааж буй хүчийг эсэргүүцэн, шүүмжилсэн, түүнчлэн хүсээгүй ирээдүй рүү биднийг түлхэж буй хүчний эсрэг хуран цугласан олон тооны хүмүүс байлаа. Сөрөг буруу бүхний эсрэг сөрөн зогссон тэд ч мөн адил 2023 оны хүний эрхийн нөхцөл байдлыг тодорхойллоо.

2048 онд, эсхүл бүр 3048 онд ч дипломатууд болон идэвхтнүүд өнгөрсөн он жилүүдийг эргэн хараад дэлхий даяар өөрсдийн чадах бүхнээ хийсэн олон сайн хүмүүс байсныг олж харна гэж найдаж байна. Нийтлэг хүн төрөлхтний төлөө сөрөн зогсож, үгээ хэлцгээе.

**Олон улсын Эмнести Интернэшнлийн Ерөнхий нарийн бичгийн дарга
Агнес Калламард.**

ДЭЛХИЙ ДАХИНЫ

ХҮНИЙ ЭРХИЙН

ТӨЛӨВ БАЙДАЛ

**ДЭЛХИЙ ДАХИНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ,
БҮС НУТГИЙН ТОЙМ**



ДЭЛХИЙ ДАХИНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ

2023 онд хүний эрхийн зөрчил өргөн хүрээнд тархсан хэвээр байв. Улам бүр нэмэгдсээр байгаа зэвсэгт мөргөлдөөний үеэр улс орнууд болон зэвсэгт бүлэглэлүүд хууль бус халдлага, аллага үйлдсээр байна. Дэлхийн улс орнуудын эрх баригчид үзэл бодлоо илэрхийлэх, тайван хуран цуглах эрх чөлөөг дарангуйлах, жагсагчдын эсрэг хууль бус хүч хэрэглэх, хүний эрх хамгаалагчид, улс төрийн сөрөг хүчнийхэн болон бусад идэвхтнүүдийг дур зоргоор баривчлах, цагдан хорих, зарим тохиолдолд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бус харьцах зэргээр эсэргүүцэгчдийг нухчин дарж байна. Олон улс орнууд эдийн засгийн шударга бус байдал, уур амьсгалын хямралыг үл тоон, иргэдийнхээ хоол хүнс, эрүүл мэнд, боловсрол, эрүүл орчинд амьдрах эрхийг хангах чиг үүргээ хэрэгжүүлж чадсангүй. Улс орны засгийн газрууд дүрвэгсэд болон цагаачидтай зүй бус, арьс үндсээр алагчлах байдлаар хандсаар байна. Суурь, бугшмал хэлбэрийн ялгаварлан гадуурхалт нь эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүс, уугуул иргэд, арьс үндэс, эсхүл шашин шүтлэгийн байдлаасаа хамааран гадуурхагдсан хүмүүсийг хүчирхийлэлд өртөх, эдийн засаг, нийгмийн эрх нь зөрчигдөх эрсдэлд хүргэж байна. Эдгээр зөрчлийн заримд нь үндэстэн дамнасан корпорацууд хувь нэмэр оруулсан. Эдгээр чиг хандлагыг бүс нутгийн түвшинд авч үзэн энэхүү тоймыг боловсруулав.

Дэлхийн дахины энэ дүн шинжилгээ нь дэлхийн түвшинд сөрөг үр дагавар бүхий дараах дөрвөн асуудалд голчлон төвлөрсөн. Үүнд зэвсэгт мөргөлдөөнд энгийн иргэдийг үл тоомсорлох; жендэрийн шударга ёсны эсрэг гарч буй ухралт; эдийн засгийн хямрал, уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчны доройтлын нийгмийн эмзэг бүлэгт илүүтэй сөргөөр нөлөөлж буй байдал; шинэ болон одоо байгаа технологи, түүний дотор үүсгэгч хиймэл оюун ухааны аюул заналхийлэл багтжээ. Эдгээр нь Эмнести Интернэшнлийн хувьд 2024 он болон цаашид чухалчлан авч үзэх дэлхий дахины хүний эрхийн томоохон сорилтуудыг төлөөлнө. Улс орнууд эдгээр асуудлыг шийдвэрлэх тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж, цаашид мөргөлдөөн, хямрал үүсэх, гүнзгийрэхээс урьдчилан сэргийлэх шаардлагатай.

ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНД ЭНГИЙН ИРГЭДИЙГ ҮЛ ТООМСОРЛОВ

Зэвсэгт мөргөлдөөний үед улс орнууд болон зэвсэгт бүлэглэлүүд энгийн иргэдийг үл хайхарч, үнэ цэнгүй мэт хандаж байгаа бөгөөд эдгээр нь зарим тохиолдолд арьс үндэс, үндэс угсаагаар ялгаварлах үзлээс үүдэлтэй байна. Өнөөгийн олон улсын тогтолцоо нь ерөнхийдөө тэдгээрийг хамгаалахад шуурхай, үр дүнтэй байж чадахгүй байгаа бөгөөд зарим тохиолдолд арьс үндсээр ялгаварлан гадуурхсан ялгамжтай хэм хэмжээ, хүчирхэг улс орнуудын хоорондын өрсөлдөөнөөс үүдэн ажиллах чадваргүй болж байна.

ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН ЗӨРЧИЛ

Дайны эрх зүй гэгдэх олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг зөрчих, үл тоомсорлох нь энгийн иргэдэд ноцтой үр дагавар учруулж байна. Олон удаагийн мөргөлдөөний үеэр зэвсэгт хүчнүүд хүн ам ихээр суурьшсан хэсэгт алсын зайн газрын болон агаарын довтолгоондоо өргөн талбайг хамрах зэвсэг хэрэглэж байна. Энэ нь олон тооны иргэдийг хоморголон хохироож, орон байр, дэд бүтцийг ихээр сүйтгэхэд хүргэсэн.

Мөргөлдөөнд оролцогч зарим тал олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэх нь сонголт мэт үйлдэл хийсэн. Украины эсрэг Оросын түрэмгийллийг дайны гэмт хэрэг хэмээн тэмдэглэж байна. Оросын цэргүүд хүн ам суурьшсан газар болон иргэний эрчим хүч, үр тарианы экспортын дэд бүтэц рүү халдаж, дайны олзлогсдыг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бусаар харьцсаны зэрэгцээ Каховка даланг зориудаар нураах зэргээр байгаль орчныг асар ихээр бохирдуулж байна. Мьянмарын зэвсэгт хүчин болон холбогдох цэргийнхэн энгийн иргэдийг бай болгож, эсхүл тэднийг ялгахгүйгээр халдлага үйлдсэний улмаас 2023 онд 1000 гаруй энгийн иргэний амь үрэгдсэн. Гэвч Орос болон Мьянмарын засгийн газар эдгээр зөрчлийг мөрдөн шалгах нь бүү хэл, ноцтой зөрчлийн талаарх мэдээлэлд тодорхой хариу бараг өгсөнгүй. Эдгээр улсууд нь Хятад улсаас санхүүгийн болон цэргийн дэмжлэг авч байна.

Судан улсад дайтагч хоёр тал болох Суданы зэвсэгт хүчин болон Шуурхай дэмжих бүлгийнхэн олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг үл хайхардаг нь энгийн иргэдийг хөнөөж, гэмтээсэн зорилтод халдлага болон хүн ам шахуу суурьшсан хэсэгт тэсрэх бөмбөг хэрэглэж байгаагаас тодорхой харагдана. 2023 оны 4 дүгээр сард өрнөсөн тулалдаанаас хойш оны эцэс хүртэл 12,000 хүн амь насаа алдаж, 5,8 сая хүн дотооддоо дүрвэж, 1,4 сая хүн эх орноосоо дүрвэн гарчээ.

Израйлын эрх баригчид Газын зурваст хийсэн халдлагаа олон улсын хүмүүнлэгийн эрх зүйд нийцсэн гэж үзүүлэхээр онцгой чармайв. Гэвч үнэн хэрэгтээ тэд олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн үндсэн хэм хэмжээг үл тоомсорлов. Энгийн иргэдэд асар их хохирол учруулж, иргэний барилга, байгууламжуудыг их хэмжээгээр эвдлэн сүйтгэсэн нь ялгамжтай байх, тухайн нөхцөл байдалд тохирсон байх зарчимд нийцэхгүй. Газын Эрүүл мэндийн сайдын мэдээлснээр 2023 оны эцсийн байдлаар Израйлын тасралтгүй бөмбөгдөлт, газрын довтолгооны улмаас 21,600 Палестин иргэд нас барсны гуравны нэг нь хүүхэд байв. Израйлын цэргийн хүчин хүн ам ихтэй дүрвэгсдийн хуаран, орон сууцны барилгуудыг бөмбөгдөж, олон удаагийн үйлдлээр энгийн иргэдийг гэр бүлээр нь үгүй хийж, эмнэлэг, сургууль, талх нарийн боовны газар болон бусад чухал дэд бүтэц, байгууламжуудыг сүйтгэсэн нь дайны гэмт хэрэг үйлдэж байгаагийн нотолгоо юм. Тэд Газын хойд хэсгийг нүүлгэн шилжүүлэх шийдвэрээ үр дүнтэй сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэмээн тодорхойлсон хэдий ч бодит байдалд 1.9 сая орчим Палестинчуудыг (Газын нийт 2,3 сая хүн амын 83 хувь) гэр орноос нь хүчээр нүүлгэн шилжүүлж, Газыг хууль бусаар бүслэх ажиллагааны нэг хэсэг болгон хүмүүнлэгийн тусламжийг санаатайгаар тасалдуулахад хүргэсэн. Дээрх болон бусад хүчин зүйлүүд, тухайлбал, Израйлын Засгийн газрын зарим албан тушаалтнуудын Палестинчуудыг арьс үндсээр алагчилсан, хүнлэг бус үгээр дайрах болсон нь төрлөөр устгах гэмт хэргийн шинжтэй байна.

Түүнчлэн Хамас болон Палестины бусад зэвсэгт бүлэглэл Израйлын бөмбөгдөлт, хуурай замын довтолгооны өмнө 2023 оны 10 дугаар сарын 7-нд хийсэн халдлагыг Израйлын Газын зурвас болон Баруун эрэг дэх удаан хугацааны цэргийн эзлэн түрэмгийллийн эсрэг хийсэн тэмцэл хэмээн зөвтгөн тайлбарласан. Гэвч Израйл дахь олон зуун энгийн иргэдийг санаатайгаар хөнөөж, хүн барьцаалсан, энгийн иргэдийг ялгахгүйгээр Израйл руу пуужингаар харвасан зэрэг бусад үйлдэл нь олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн, дайны гэмт хэрэгт тооцогдоно.

Газад энгийн номхон иргэдийн цусыг урсгаж, аймшигт хөнөөл, зовлон зүдгүүр үүсгэж байгааг үл харгалзан АНУ болон Европын улс орнууд Израйлыг илэрхий дэмжиж байна. Зарим улс орнууд, ялангуяа АНУ нь хүний эрхийн аймшигт зөрчил үйлдэхэд хэрэглэгдэж байгаа зэвсэг хэрэгслээр Израйл улсыг үргэлжлүүлэн хангасаар байна. Дээрх улс орнууд Орос болон Хамас бүлэглэлийн дайны гэмт хэргийн эсрэг үндэслэл бүхий арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа нэрийдлээр хүмүүнлэгийн хуулийг хүндэтгэх, энгийн иргэдийг хамгаалахад өргөн хүрээний давхар стандарт тогтоож байна. Өмнөд Африк Израйл улсыг 1948 оны төрлөөр устгах тухай Газын конвенцийг зөрчсөн хэмээн тус улсын эсрэг Олон улсын шүүхэд хандсан.

2023 онд Афганистан, Буркина Фасо, Камерун, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс (ТАБНУ), Бүгд Найрамдах Ардчилсан Конго улс (БНАКУ), Этиоп, Ливи, Мали, Нигер, Нигери, Сомали, Өмнөд судан, Сири, Йемен зэрэг улсад гарсан зэвсэгт мөргөлдөөний үеэр засгийн газрын цэргийн хүчин болон зэвсэгт бүлэглэлүүд мөн л олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг үл хүндэтгэв. Ялгаварлан гадуурхалт, хууль бус халдлага, дайны гэмт хэргийн үр дагаврыг энгийн иргэд амсаж байна.

Жендэрт суурилсан хүчирхийлэл нь дээрх зарим зөрчлийн үндсэн шинж байсаар ирсэн. Эритрей улсын Батлан хамгаалахынхан хамгийн багадаа 15 эмэгтэйг хүчээр хулгайлж, Этиопын Тиграй бүс дэх цэргийн хуаранд 3 сар орчим байлгаж, олон удаа бэлгийн хүчирхийлэл үйлджээ. БНАКУ-д 2023 оны эхний улиралд зөвхөн Норд-Киву бүсэд бэлгийн хүчирхийллийн 38,000 орчим тохиолдолд бүртгэгджээ.

Засгийн газрууд цэргийн ажиллагаа, түүний энгийн иргэдэд үзүүлж байгаа нөлөөллийг шүүмжилсэн дуу хоолойг нухчин дарж байна. 2023 онд Орос улс дахь дайны үеийн цензур шинэ түвшинд хүрлээ. Мөргөлдөөний үед болон мөргөлдөөний дараа ажиллаж буй хүний эрх хамгаалагчид, хэвлэл мэдээлэл, улс төрийн идэвхтнүүд халдлагад өртсөөр байна. Хүний эрх хамгаалагч эмэгтэйчүүд тодорхой сорилт бэрхшээлтэй тулгарч байна.¹

АРЬС ҮНДЭС БОЛОН ҮНДЭС УГСААГААР ЯЛГАВАРЛАН ГАДУУРХСАН НЬ

Арьс үндэсний үзэл нь дээрх зарим зөрчилдөөн, түүнд үзүүлэх хариу арга хэмжээний үндэс байсаар байна.

Израйл болон Палестины эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх зөрчилдөөний суурь нь арьс үндсээр хэт ялгаварлан гадуурхах үзэл буюу Палестинчуудын эсрэг Израйлын апартейдын тогтолцоонд үндэслэгддэг. Израйл улс газар нутгийг хэсэгчлэн хуваах, ялгаварлан тусгаарлах, хараа хяналтад байлгах, газар болон хөрөнгийг хураах, эдийн засаг, нийгмийн эрхийг үгүйсгэх зэргээр дарангуйлал ноёрхлоо тогтоож байна. Этиоп, Мьянмар, Судан зэрэг улс орнуудын зэвсэгт мөргөлдөөний онцлог нь үндэс угсаатны ялгаатай үзлээс үүдэлтэй.

Арьс үндсээр ялгаварлан гадуурхах нь эдгээр мөргөлдөөний хариу арга хэмжээнд ч тод илэрч байна. Ялгаварлан гадуурхсан ялгамжтай хэм хэмжээ АНУ болон Европын олон улс орнуудын Израйл болон Палестины эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх мөргөлдөөний талаарх яриа хэлэлцүүлэг, бодлогод илэрхий байхын зэрэгцээ, үр дагаварт ч мөн илэрч байна. Палестинчуудтай эв санааны нэгдэлтэй байгаагаа илэрхийлсэн жагсаал, цуглаанд нилээдгүй засгийн газар хууль бус хязгаарлалт тавьж байна. Австри, Франц, Герман, Унгар, Польш, Швейцар улсын засгийн газар олон нийтийн хэв журам, үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулна гэсэн хэт тодорхой бус үндэслэлийг удирдлага болгон, зарим тохиолдолд арьс үндсээр ялгаварлан гадуурхах хэвшмэл үзэлд үндэслэн 2023 онд дээрх төрлийн жагсаал, цуглааныг урьдчилсан журмаар хориглосон. АНУ, Баруун Европ болон бусад орны хэвлэл мэдээлэл, улс төрчид Палестинчуудыг хүнлэг бусаар илэрхийлэх, арьс үндэсний үзлийг улам бүр дэлгэрүүлэх, Мусульманчуудыг террорист үйлдэлтэй холбосон үг хэллэгийг улам бүр ашиглах болов.

Үүнтэй холбоотойгоор Европ болон АНУ-д еврей, эсхүл Мусульман шашинтуудын эсрэг үзэн ядах гэмт хэрэг нэмэгджээ. Түүнчлэн цахим орчинд Палестин болон Еврейчүүдийн эсрэг өдөөн хатгасан, үзэн ядах агуулга бүхий сэтгэгдэл, илэрхийллүүд өргөн хүрээнд огцом нэмэгдсэн. Палестинчууд болон тэдгээрийн эрхийг хамгаалсан агуулга бүхий нийтлэлүүдийг ялгаварлан гадуурхсан агуулгатай байж болзошгүй гэсэн үндэслэлээр нийгмийн цахим орчны олон төрлийн платформууд хязгаарлажээ.²

Үүний зэрэгцээ 2023 оны 10 дугаар сард Этиопын талаар гаргасан судалгаагаар

Мета өөрийн Фэйсбүүк платформ дээрх өдөөн хатгалгыг таслан зогсоож чадаагүй нь Тиграан иргэдийг хөнөөх, хүний эрхийн бусад ноцтой зөрчил үйлдэхэд хүргэсэн болохыг харуулсан.³

Арьс үндсээр ялгаварлах үзэл мөргөлдөөн болон бусад хямралаас дайжиж байгаа хүмүүстэй харьцах явцад илэрхий ажиглагдсаар байна. Европын Холбоо, Европын бусад улсууд болон АНУ-аас хэрэгжүүлж буй цагаачлалыг хумих, гадагшлуулах бодлого нь мөргөлдөөн болон бусад хямралаас дайжсан хүмүүсийг аюул, эрсдэл рүү түлхэж байна. Энэ нь аюулгүй байдлыг эрэлхийлж буй Украинчуудтай зэрэгээр харьцдаг хандлагаас эрс ялгаатай байна. Дани, Финлянд, Швед улс 2023 оны 5 дугаар сард Афганистан охид, эмэгтэйчүүдийн дүрвэгсдийн статусыг хүлээн зөвшөөрч эрх олгосон нь эерэг үзүүлэлт юм. Гэвч ерөнхийдөө Европын улс орнууд Афганистан болон зөрчилдөөн, хүний эрхийн ноцтой зөрчлөөс дайжсан хүмүүсийг хамгаалах хангалттай, албан ёсны арга хэмжээгээр хангаж чадсангүй.

ОЛОН УЛСЫН ТОГТОЛЦОО

Олон талт байгууллагууд олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг даган биелүүлэх талаар зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талуудад шахалт үзүүлэх сонирхолгүй, эсхүл ийм боломж байсангүй. Нөөцийн хязгаарлагдмал байдал нь нөлөөлөх хүчин зүйл байж болох хэдий ч эдгээр олон талт байгууллагуудын оролцогчид зориг гарган өөрийн зарчмуудыг тууштай хэрэгжүүлж чадсангүй. Дээрх байгууллагын гишүүд увайгүй, хувиа хичээсэн тоглогчийн төрхийг харууллаа.

НҮБ-ын Аюулгүйн зөвлөл томоохон мөргөлдөөнийг үр дүнтэй шийдвэрлэх арга хэмжээ авч чадахгүй байна. Аюулгүйн зөвлөлөөс Газа дахь гал зогсоох арга хэмжээг хэрэгжүүлэхэд АНУ саад хийн өөрийн хориг тавих эрхээ удаа дараа ашигласан.⁴ Энэхүү тодорхой бус байдал нь нийтлэг үндэслэлээр ашиглагдах асуудлыг улам бүр өргөжүүлсээр байна. 2023 оны 7 дугаар сард Сири рүү хүмүүнлэгийн тусламж хүргэх хил дамнансан механизмыг дахин зөвшөөрч баталгаажуулж чадсангүй. Хүүхэд болон зэвсэгт мөргөлдөөний талаарх ажлын хэсэг Афганистан, Мьянмар, Сомали, Сири зэрэг улс дахь хүүхдийн эрхийн ноцтой зөрчлийн талаар нэг жил, зарим тохиолдолд хоёр болон түүнээс олон жил ярилцсан ч нэгдсэн зөвшилцөлд хүрч чадсангүй.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл зэвсэгт мөргөлдөөний үр дагаврыг шийдвэрлэх талаар өөр хоорондоо зөрчилдөөнтэй бүртгэл мэдээлэлтэй байсаар байна. 2023 онд Хүний эрхийн зөвлөлөөс Суданд хүний эрхийн мониторингийн механизм байгуулж, Орос дахь хүний эрхийн тайланг өргөжүүлсэн. Гэвч чухал ач холбогдолтой бүрэн эрхийг сунгаж чадсангүй. Тухайлбал, 600,000 орчим хүний амь насыг авч одсон зэвсэгт мөргөлдөөн цаашид улам харгислал дагуулах өндөр эрсдэлтэй хэмээн анхааруулсан Этиоп дахь Хүний эрхийн шинжээчдийн Олон улсын Хорооны анхааруулгыг үл харгалзан уг Хорооны бүрэн эрхийг сунгасангүй. Түүнчлэн Ливи дэх хүний эрхийн томоохон зөрчилд хариуцлага хүлээдэггүй байдал үргэлжилсээр байгаа талаарх дүгнэлтийг үл харгалзан тус улс дахь Баримт Цуглуулах хорооны бүрэн эрхийг дуусгавар болгов. Зарим улс орнууд дээрх чухал бүрэн эрхийг сунгах талаар идэвхтэй эсэргүүцсэн бол өмнө нь уг механизмыг байгуулахыг дэмжсэн улс орнууд тодорхой эсэргүүцэлтэй тулгарснаар уг асуудлыг орхиход хүрэв.

Автомат удирдлагатай зэвсгийн системийн зохицуулалтгүй байдлаас үүдсэн ноцтой аюул заналхийллийг шийдвэрлэх талаарх НҮБ-ын оролдлого хангалтгүй байгаагаас хүний амь нас, үхэл амьдралын асуудлын талаар шийдвэр гаргах боломжийг хиймэл оюун ухаанд суурилсан алгоритмд үлдээх ноцтой аюул дагуулж байна. НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2023 оны 12 дугаар сард уг асуудлыг шуурхай шийдвэрлэх шаардлагатай байгааг онцолж өргөн хүрээнд дэмжлэг авсан тогтоолыг баталсан. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга болон Олон Улсын Улаан Загалмайн Хорооноос улс орнуудад хандан 2026 он гэхэд автомат удирдлагатай зэвсгийн системийн талаар олон улсын гэрээ байгуулахыг уриалав.

Зэвсэгт мөргөлдөөний үеэр үйлдэгдсэн гэмт үйлдэлд олон улсын эрх зүйн дагуу хариуцлага хүлээлгэх байдал тодорхой бус хэвээр бөгөөд Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Прокурорын Газар өөрийн хяналтад хамаарах нөхцөл байдалд ялгамжтай хэм хэмжээ тогтоож, сонголттой хандах нь нэмэгдсээр байна. Прокурорын Газраас Кени, Уганда дахь мөрдөн шалгах ажиллагаагаа хааж, Нигерт явуулахаар зарласан мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлж чадсангүй. Гэхдээ, Эмнести Интернэшнлээс баримтжуулсан олон улсын эрх зүйн дагуу гэмт хэрэгт тооцогдох хэд хэдэн нөхцөл байдалд Олон улсын Эрүүгийн Шүүхийн мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилсээр байна. ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин болон Хүүхдийн эрхийн Комиссар Мария Львова-Белова нарыг дайны гэмт хэрэг үйлдсэн үндэслэлээр Олон Улсын Эрүүгийн Шүүхээс баривчлах шийдвэр гаргасан бөгөөд Өмнөд Африкийн дээд шүүхийн баталгаажуулснаар Олон улсын эрүүгийн шүүхийн гишүүн бүхий л улс орнууд тэднийг баривчилж, хүлээлгэн өгөх үүрэгтэй. Олон улсын эрүүгийн шүүхийн прокурор Палестин дахь нөхцөл байдлын талаар явуулж байгаа мөрдөн шалгах ажиллагаа нь аравдугаар сарын 7-ны өдөр болон түүний дараа Израйл болон Палестины эзлэгдсэн нутаг дэвсгэрт явагдсан үйлдлийг хамрах болно гэсэн мэдэгдлийг хожим нь хийсэн.

Түүнчлэн 2023 оны 5 дугаар сард баталсан Төрлөөр устгах гэмт хэрэг, Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, Дайны гэмт хэрэг болон бусад Олон улсын гэмт хэрэгт мөрдөн шалгах, яллах асуудлаарх олон улсын хамтын ажиллагааны талаарх Любляна-Гаагийн конвенц (эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх конвенц) нь үндэсний шүүхээр дамжуулан шударга ёсыг тогтоох боломжийг олон улсын гэмт хэргийн хохирогчдод нээн өгч байгаа юм.⁵

НҮБ-ын гишүүн улс орнууд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийг шинэчлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд ингэснээр байнгын гишүүн улс орнууд өөрийн хориг тавих бүрэн эрхээ хяналтгүйгээр хэрэгжүүлэх боломжгүй болно. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг аливаа татгалзалгүйгээр гарын үсэг зурж, соёрхон батлах шаардлагатай. Улс орнууд арьс үндэсний үзэл, үндэс угсаагаар ялгаварлан гадуурхах зэрэг зөрчил, мөргөлдөөний суурь шалтгааныг шийдвэрлэж, зэвсэгт мөргөлдөөнд олон улсын хүмүүнлэгийн эрх зүй хүндэтгэх, ялангуяа энгийн иргэдийг хамгаалах баталгааг хангах шаардлагатай. Түүнчлэн НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, тусгай процедурын тогтолцоо, мөрдөн шалгах, тайлагнах болон олон улсын эрх зүй дэх эрүүгийн эргэйн нотлох баримтыг хадгалдаг байгууллагууд зэрэг урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий НҮБ-ын байгууллагуудыг бэхжүүлэх шаардлагатай.

ЖЕНДЭРИЙН ШУДАРГА ЁСНЫ ЭСРЭГ УХРАЛТ

Зарим улс орнуудад ахиц гарч байгаа хэдий ч охид, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийн эрхийн эсрэг чиглэсэн ухралт эрчимжсээр байна. Хэд хэдэн улсын засгийн газар бэлгийн болон нөхөн үржихүйн эрх, ЛГБТИ хүмүүсийн эрхийг дордуулж, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэж чадсангүй.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ, БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ

Сүүлийн жилүүдэд хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүд болон иргэний нийгмийн байгууллагууд эмэгтэйчүүдийн эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэх чиглэлд зарим ахиц дэвшил гаргасан. Гэвч энэхүү ололт амжилтыг дордуулсаар байна. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага жендэрийн ялгаа зааг улам бүр нэмэгдсээр байгааг анхааруулсан.

Зарим улсын засгийн газар охид, эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг улам бүр бэхжүүлсээр байна. Афганистаны эрх баригчид охид, эмэгтэйчүүдийг бага сургуулиас бусад газар боловсрол эзэмших, НҮБ-ын төлөөлөгчийн газар, ТББ

болон ихэнх төрийн байгууллагад ажиллахыг хориглосон. Ираны эрх баригчид охид, эмэгтэйчүүдийг гивлүүр зүүхийг шаардахаа улам бүр чангатгаж байна. Дээрх улсад иргэд эрхээ хэрэгжүүлсэн, эсхүл шаардсанахаа төлөө төрийн харгис хэрцгий шийтгэлтэй нүүр тулсаар байна. 2023 онд Францын эрх баригчид мусульман шашинт охид, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхаж, сургууль болон спортын арга хэмжээнд шашны хувцас өмссөн гэх үндэслэлээр тавих хязгаарлалтаа улам бүр нэмэгдүүлжээ.

2023 онд зарим улс оронд бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн чиглэлээр ахиц гарсан. Гондурас улсын засгийн газар үр хөндөлтийг хориглосон хэвээр байгаа хэдий ч жирэмслэлтээс хамгаалах эмийг хэрэглэх, худалдахад тавьсан хоригийг 14 жилийн дараа цуцлав. Мексик улсын Дээд шүүхээс үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцох нь Үндсэн хуулийг зөрчсөн хэмээн зарлалаа. Финланд, Испани зэрэг улсад үр хөндөлт хийлгэхийг зөвшөөрсөн байна.

Гэвч зарим улсын засгийн газар бэлгийн болон нөхөн үржихүйн эрх, үүний дотор үр хөндүүлэх боломжийг хориглосоор байна. АНУ-ын 15 мужид үр хөндөлтийг бүрэн хориглосон, эсхүл хориглолт үйлчлэхгүй байх нөхцөлийг маш хязгаарлагдмал хүрээнд тодорхойлсны үр дагаврыг хар арьстнууд болон бусад арьс үндсээр ялгаварлагдан гадуурхагдсан хүмүүс илүү ихээр амссаар байна. Польш улсад 2023 онд хамгийн багадаа нэг эмэгтэй үр хөндүүлэх үйлчилгээ авч чадаагүйн улмаас нас баржээ. 2022 онд АНУ-ын Дээд шүүхээс үр хөндөлтийн эрхийн талаарх Холбооны хамгаалалтыг хүчингүй болгосны дараа Фэйсбүүк, Инстаграм, ТикТок зэрэг нийгмийн платформууд нөхөн үржихүйн эрхийн чухал мэдээлэлд хязгаарлалт тогтоосон. Үр хөндөлтийн эрхийг хамгаалж байгаа хүмүүс, тэр дундаа идэвхтнүүд, эрүүл мэндийн ажилтнуудыг гутаан доромжилж, бие махбодид нь халдаж, хэл амаар доромжилж, айлган сүрдүүлж, заналхийлж, мөн шударга бусаар ял тулган, баривчилж, мөрдөн шалгах зэргээр эрүүгийн хэрэгт шийтгэжээ.⁶

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

Эмэгтэйчүүдийн эрх хамгаалагчдын тэмцэл сүүлийн жилүүдэд охид, эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг бий болгох чиглэлд зарим ахиц гаргасан. Гэвч охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл аюултай түвшинд хүрлээ.

Япон, Хойд Македон, Швейцар, Узбекистан зэрэг улсад жендэрт суурилсан хүчирхийлэл, ялангуяа бэлгийн болон нөхөн үржихүйн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн хамгаалалтыг улам бүр бэхжүүлсэн. Гэвч дэлхийн улс орнуудын эрх баригчид нийгэмд бугшмал болсон жендэрт суурилсан хүчирхийлэл болон хүчирхийлэл үйлдэгчид ял шийтгэл хүлээдэггүй байдал, хохирогчдын урт хугацааны хэрэгцээ шаардлагыг анхаардаггүй зэрэг асуудлыг тогтолцоогоор нь шийдвэрлэж чадсангүй. 2023 онд Мексикт өдөрт дунджаар 9 эмэгтэй хүчирхийллийн улмаас амь насаа алджээ. Алжир, Тунис зэрэг улсад эмэгтэйчүүд “нэр төрийн аллага”-ын хохирогч болсоор байна. 2023 онд Нигерт албадан гэрлэлтээс зугтаж амь насаа алдсан 16 настай охины үхэл, Сьерра-Леонд нас барсан 2 настай охины үхэл нь хор хөнөөлтэй уламжлалын үр дагаврыг харуулж байна.

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

Цөөн тооны улсад ЛГБТИ хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлд багахан ахиц гарсан хэдий ч бусад олон улс оронд ЛГБТИ хүмүүсийн эрхэд халдах нь эрчимжсээр байна.

2023 онд хэд хэдэн улсад хууль тогтоомж, бодлогын эерэг өөрчлөлт гарсан. Латви улсын эрх баригчид ижил хүйстнүүдийн хамтын амьдралыг хүлээн зөвшөөрсөн. Тайваны эрх баригчид гадаад улсын ижил хүйстнүүдийн гэрлэх эрхийг хүлээн зөвшөөрөв. Намиб улсын Дээд шүүхээс Намиб улсын иргэнтэй гадаад улсад гэрлэсэн ижил хүйстэн эхнэр, нөхрийн гэрлэлтийг үндэслэн тус улсад цагаачлах эрх

олгож болно хэмээн шийдвэрлэсэн. Финланд, Герман, Испани улсын эрх баригчид хүйсийн хувьд өөрийгөө тодорхойлох эрхэд зарим ахиц гаргасан.

Гэвч дэлхийн 62 улсад ижил хүйстнүүдийн бэлгийн харьцааг эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцдогийн ихэнх нь колоницлолоос үүдэлтэй.⁷ 2023 онд ЛГБТИ хүмүүсийн эрхийг үгүйсгэх хууль эрх зүйн санаачилга, төслийн шинэ хэлбэрийн давллагаа үүслээ. Уганда улсад “ижил хүйстний хүндрүүлэх нөхцөлтэй бэлгийн харьцаа”-нд цаазаар авах ял шийтгэхээр хуульчилсан бол Гана улсын хууль тогтоох байгууллага “гейчүүдийн эсрэг” хуулийн төслийг баталлаа. Орос улс трансфоби буюу трансжэндэр хүмүүсээс айх, тэдгээрийг үзэн ядах, үл ойлгож ялгаварлах шинэ хуулийг баталсан бол Болгар улс трансжэндэр хүмүүсийн хүйсийг хүлээн зөвшөөрөх хуулийг хүчингүй болгов. Шотландын Жендэрийг хүлээн зөвшөөрөх шинэчилсэн хуулийн төслийг Их Британи гацаав. Энэтхэг улсын Дээд шүүх ижил хүйстний гэрлэлтийг хуулиар хүлээн зөвшөөрөхөөс татгалзав.

Ихэнх бүс нутагт ЛГБТИ хүмүүсийг баривчлан, эрүүгийн ял оногдуулж, ЛГБТИ хүмүүсийг хамгаалдаг байгууллагуудыг хязгаарласаар байна. 2023 онд Бурунди, Египет, Ливи, Тунис зэрэг улсад ижил хүйстнүүдийг зөвшилцөн бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг үйлдсэн үндэслэлээр, Нигер улсад гейн хурим, үдэшлэг зохион байгуулсан үндэслэлээр олон хүнийг баривчилж, зарим хүнд хорих шийтгэл ногдуулжээ. Хятад улсад ЛГБТИ хүмүүсийн эсрэг засгийн газраас хэрэгжүүлж буй кампанит ажлын хүрээнд нэр хүнд бүхий ЛГБТИ байгууллагыг хүчээр татан буулгав. Орос улс “олон улсын ЛГБТ хөдөлгөөн”-ийг “хэт даврагчид” хэмээн цоллож ЛГБТИ хүмүүсийн эрхийн чиглэлээрх олон нийтийн үйл ажиллагааг хориглов.

Ихэнх бүс нутагт ЛГБТИ хүмүүсийн эсрэг хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэгдсээр байгаа бөгөөд ял шийтгэл хүлээлгэхгүй байдал хэвээр байна. Ижил хүйстний гэрлэлтийг хууль бус хэмээн үздэг Гватемал улсад хамгийн багадаа 34 хүн бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаанаасаа болж амь насаа алджээ. Ливан улсын эрх баригчид ЛГБТИ хүмүүсийн эсрэг хүчирхийллийг улам бүр өдөөж байгаа бол Ирак улсын эрх баригчид “ижил хүйстэн” гэх нэр томьёог “бэлгийн гажуудал” хэмээн нэрлэхийг хэвлэл мэдээллийн байгууллагад үүрэг болгожээ.

Бүх улсын засгийн газар эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалт, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хэрэгжүүлэхийн тулд жендэрийн шударга ёсны төлөөх хөдөлгөөнд дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. Засгийн газрууд жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хүчирхийллийн хохирогчдын урт хугацааны хэрэгцээг хангах хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжинд авч үзэх шаардлагатай. Мөн ЛГБТИ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхсан хууль, бодлогыг хүчингүй болгохыг дэмжих шаардлагатай.

ЭДИЙН ЗАСГИЙН ХЯМРАЛ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР ДАГАВАР

Эдийн засгийн хямрал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол нь нийгэм, эдийн засгийн эмзэг бүлэгт илүү ихээр нөлөөлж байна. Эдгээр бүлгийн эрхийн чиглэлээр кампанит ажил явуулдаг хүний эрх хамгаалагчид, шүүмжлэгчид өргөн хүрээтэй халдлагын бай болсоор байна.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЭРХ

Мөргөлдөөн, уур амьсгалын өөрчлөлт, Ковид-19 цар тахлын дараах нийлмэл шинжтэй үр дагавар нь эдийн засгийн олон төрлийн хямралыг улам бүр өдөөж байна. 4.1 тэрбум хүн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс бусад ямар нэгэн нийгмийн хамгааллын механизмд хамрагдаагүй нь хоол хүнс, түлшний аюулгүй байдлыг өндөр түвшинд алдагдуулах зэргээр хүний эрхэд ноцтой нөлөөлж байна.

Түүнчлэн 2023 онд дунд хугацаандаа хүрсэн Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын хэрэгжилтэд ноцтойгоор нөлөөлж байна. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2023 оны 4 дүгээр сард гаргасан тайланд дурдсанаар дата мэдээлэл бүхий 140 орчим зорилтын ердөө 12 хувь нь хэрэгжжээ. Энэ чиг хандлагаараа цаашид үргэлжилбэл, зорилтыг бүрэн хэрэгжүүлсэн ч 2030 он хүртэл 575 сая хүн нэн ядуу түвшинд аж төрөх болно.

Эдийн засгийн хямрал нь өрийн хямралд нэрвэгдсэн улс орнуудын үндэсний өрийн хэмжээг улам бүр гүнзгийрүүлж байна. Дэлхийн Банкны 2023 оны 12 дугаар сарын тайланд дурдсанаар дэлхийн бага орлоготой улс орнуудын 60 орчим хувь нь өрийн дарамтад нэрвэгдсэн, эсхүл нэрвэгдэх өндөр эрсдэлтэй байна. Эдгээр улсын ихэнх нь хүний эрхийг хэрэгжүүлэхэд чухал шаардлагатай мөнгийг зээлийн эргэн төлөлтөд зарцуулж байна. Египет, Этиоп, Гана, Кени, Пакистан, Шри Ланка, Тунис, Украин, Замби зэрэг улсууд өрийн ноцтой хямралд өртжээ.

НҮБ-ын Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллагын мэдээлснээр дэлхийн хүнсний үнэ 2022 оны оргил үетэй харьцуулахад бага зэрэг буурсан хэдий ч 2022 оны 2 дугаар сард Орос улс Украин улсад бүрэн хэмжээний довтолгоо хийхээс өмнөх үетэй харьцуулахад өндөр хэвээр байгаа бөгөөд зах зээл дэх үнэ үргэлжлэн өссөөр байна. 2023 онд хэд хэдэн газарт хийсэн судалгаанаас үзэхэд Сьерра-Леон улсын хүн амын 78 хувь нь хүнсний хомсдолд, Өмнөд Суданы хүн амын 46 хувь нь хүнсний аюулгүй байдал өндөр хэмжээнд алдагдсан нөхцөлд аж төрж байгаа бол Сомали улсад 5 сая хүн хүнсний хямралд өртсөн тооцоо гарчээ. Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллагын мэдээлснээр 12 дугаар сарын дунд үеийн байдлаар Газа дахь хүн амын 93 хувь нь өлсгөлөнд нэрвэгдэн өвчнөөр нас барах эрсдэл нь нэмэгдэж байгаа бөгөөд үүнд жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд илүүтэй өртөх эрсдэлтэй байна.

Зарим улс орнууд эдийн засаг, нийгмийн эрхийг хэрэгжүүлэхийн тулд дэлхийн татвар болон эдийн засгийн засаглалын хэлбэрийг өөрчлөх зарим алхмыг хийлээ. Үүний нэг хэсэг болгон орлого багатай улс орнууд өөрийн нөөцийг дайчлахад дэмжлэг үзүүлэх шударга татварын даян дэлхийн тогтолцоог бий болгох чиглэлд зарим ахиц гарсан. НҮБ-ын Ерөнхий Ассамблей олон улсын татварын хамтын ажиллагааны үр дүнтэй, хүртээмжтэй байдлын тухай НҮБ-ын суурь конвенцын талаарх хэлэлцээрийн хоёр үе шаттай үйл явцыг уриалсан тогтоол баталсан. Үүнийг Нигер улс санал болгосон бөгөөд Европын Холбооны улс орнууд, Япон, Их Британи, АНУ зэрэг өндөр орлоготой бусад улс орнууд эсэргүүцсэн ч олонхын дэмжлэг авсан.⁸

ЭРҮҮЛ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй цаг агаарын эрс тэрс үзэгдэл, удаан хугацааны хямралууд нь орлогын түвшнөөс үл хамааран бүх улс оронд нөлөөлж байгаа ч бага орлоготой улс орнуудад илүү хүндээр нөлөөлж байна. Засгийн газрууд болон бизнесийн оролцогчид байгаль орчны ноцтой доройтлоос урьдчилан сэргийлж, зохистойгоор шийдвэрлэж чадсангүй.

Засгийн газрууд, ялангуяа түүхэн болон өндөр ялгаруулалт бүхий улс орнууд нийтлэг бөгөөд ялгавартай хариуцлага хүлээх эрх зүйн зарчмын дагуу өндөр үүрэг, хариуцлага хүлэсэн улс орнууд чулуужсан түлшийг болон уур амьсгалын өөрчлөлтөд хүргэж буй бусад хүчин зүйлийг хэрэглээнээс гаргах чиглэлд маш бага хүчин чармайлт гаргалаа. Ихэнх нь төсвийн санхүүжилтээр чулуужсан түлшний дэд бүтцийг үргэлжлүүлэн өргөжүүлсээр байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн COP28 чуулганы Ерөнхийлөгчийн тэргүүлсэн Арабын Нэгдсэн Эмират улсын төрийн өмчит Абу Даби үндэсний газрын тосны компани өөрийн чулуужсан нүүрсний үйлдвэрлэлээ эрчимтэй нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаагаа мэдэгдсэнээс үүдэн COP28 чуулга уулзалтыг зохион байгуулагч улсаар Арабын Нэгдсэн Эмират улсыг сонгосон талаар маргаан гарсан. Эрчим хүчний зориулалтаар чулуужсан түлшнээс аажмаар шилжих талаарх COP28-ийн тохиролцоо

нь СОР-ийн шийдвэрт чулуужсан түлшний талаар дурдсан анхны тохиолдол юм. Гэвч энэхүү хэлэлцээр нь хангалтгүй бөгөөд чулуужсан түлшний үйлдвэрлэгчдэд өөрсдийн бизнесийг ердийн журмаар үргэлжлүүлэх боломжийг бүрдүүлсэн цоорхойг хэвээр үлдээв.⁹ Түүнчлэн, цаг агаарын гамшигт үзэгдэл болон дэлхийн дулаарлаас үүдэн хохирол амсаж байгаа бага орлоготой улс орнуудын иргэдэд туслах зорилгоор СОР28-ийн чуулганаар шийдвэрлэсэн Гарз, хохирлын санд төвлөрүүлэх 700 сая америк доллар нь уг зорилгыг хэрэгжүүлэхэд хангалтгүй юм.¹⁰

Кипр болон Ирланд улсын шүүх, Европын хүний эрхийн шүүх зэрэг үндэсний болон бүс нутгийн хэд хэдэн шүүхээс уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтлыг шийдвэрлэх талаар засгийн газрууд хангалттай арга хэмжээ аваагүй гэсэн зарга маргааныг иргэд болон иргэдийн бүлэг гаргах эрхийг хүлээн зөвшөөрсөн нь томоохон эерэг өөрчлөлт юм. Эдгээр хэргүүд нь засгийн газар болон чулуужсан түлшний компаниудад тодорхой хор хөнөөлийнх нь төлөө хариуцлага хүлээлгэж, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ирээдүйн зарга маргааны үндэс суурийг бүрдүүлнэ. Түүнчлэн, 2023 оны 3 дугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблей Вануату болон Номхон далайн бусад арлын улс орнуудын гаргасан Олон улсын шүүхээс уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой улс орнуудын үүрэг, хариуцлагын талаар дүгнэлт гаргахыг хүссэн саналыг дэмжсэн юм.¹¹

НИЙГМИЙН ЭМЗЭГ БҮЛГИЙНХЭД ИЛҮҮТЭЙ СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БҮЙ НЬ

Уугуул иргэд, олон төрлийн ялгаварлан гадуурхалтад өртөж буй хүмүүс зэрэг арьс үндсээр ялгаварлагдсан бүлгүүд эдийн засгийн хямрал, уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчны доройтлоос үүдсэн хүний эрхийн хохиролд илүү ихээр өртөж байна.

Ийнхүү үр дагавар, хор хохирлыг харилцан адилгүй амсаж байгаа нь одоо болон өнгөрсөн үеийн бүтцийн болон шууд ялгаварлан гадуурхалтын хуримтлагдсан үр дагавар зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс үүдэлтэй. Үүний уршгаар дэлхийн улс орнууд дахь ялгаварлагдсан гадуурхагдсан эмзэг бүлгийнхэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, ундны ус, хангалттай хоол хүнс, эрчим хүч зэрэг бусад наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүйд хүрч байна.

2023 оны 5 дугаар сард Мьянмарыг дайран өнгөрсөн Моча хар салхины улмаас амь үрэгдэгсдийн тоо Рохинжа үндэстнүүдийн дунд өндөр байгаа нь тэднийг 2012 онд албадан нүүлгэн шилжүүлсний улмаас амьдралын нөхцөл нь дордсонтой холбоотой байв. Пакистанд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн хэт халалтын улмаас албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид илүү хохирол амссан. Америк, Ази тивийн өргөн хүрээний томоохон олборлолтын төслөөс үүдсэн байгаль орчны доройтлын нөлөөлөлд уугуул хүмүүс болон бусад ялгаварлагдсан бүлгүүд илүү ихээр өртөж байна.

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИД

Эдийн засгийн хямрал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтлын нөлөөлөлд ноцтой өртсөн хүмүүсийн эрхийн төлөө ажилладаг хүний эрх хамгаалагчид засгийн газар болон засгийн газрын бус оролцогчдын халдлагын бай болсон хэвээр байна.

Египетээс эхлээд Өмнөд Солонгос зэрэг олон улсад эдийн засгийн хямралд өртсөн ажилчдын эрхийг хамгаалах, эдийн засгийн хямралын эсрэг авч хэрэгжүүлж байгаа засгийн газрын арга хэмжээг шүүмжилсэн үйлдвэрчний эвлэлийнхэн бай болсоор байна. Баруун болон Төв Африкт авлигатай тэмцдэг хүний эрх хамгаалагчид заналхийлэл, баривчилгаанд өртөж, зарим нь амь насаа алдаж байна.¹²

Тэд бол өргөн хүрээний хэлмэгдүүлэлт, шийтгэл, айлган сүрдүүлэлтэд өртсөн, амь насаа алдсан олон тооны хүний эрх хамгаалагчдын нэгээхэн хэсэг юм. 2023 онд

Гондурас улс дахь Гуапинол бүлгийн гурван иргэн алагджээ. Тэд амьжиргааны гол эх үүсвэр болсон гол усаа хамгаалж уул уурхайн компаний эсрэг тэмцдэг байжээ. Бангладеш, Хятад, Куба, Унгар, Энэтхэг, Иордан, Пакистан, Папуа Шинэ Гвиней, Сингапур, Их Британи зэрэг бусад улсад 2023 онд хэрэгжиж эхэлсэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарласан шинэ хууль тогтоомж нь хүний эрх хамгаалагчдад сөргөөр нөлөөлж байна.

Уугуул хүмүүс, уур амьсгалын өөрчлөлтийн шударга ёсны төлөө тэмцэгчид, байгаль орчны хүний эрх хамгаалагчдыг иргэний үл захирагдахуйн тайван үйл ажиллагаанд оролцох үед нь олноор нь баривчилж, шийтгэж байна. Тэднийг бусад идэвхтнүүдийн нэгэн адил эсэргүүцлийн жагсаалд оролцсоных нь төлөө шийтгэж, зайлшгүй шаардлага үүсээгүй байхад хүч, албадлагыг хэтрүүлэн хэрэглэжээ. Жагсаалд оролцогчдын эсрэг кинетик үйлчлэлт сум болон бусад төрлийн пуужин хэрэглэсэн нь дэлхий дахинд олон мянган хүн гэмтэх, тахир дутуу болох, амь насаа алдахад хүргэж байна.¹³ Цагдаагийн албыг цэрэгжүүлж байгаа нь дээрх эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна. Хүний амь насанд аюул багатай зэвсэг, хэрэгсэл үйлдвэрлэгч томоохон бизнесүүд тэдгээр хэрэгслийг хууль бусаар ашигладаг хэмээн үздэг аюулгүй байдлын хүчнийхэнд хариуцлагагүй байдлаар нийлүүлсээр байна.¹⁴ Иймээс хууль сахиулах хэрэгслийн худалдааны хяналтын талаарх хууль зүйн хүчин төгөлдөр олон улсын гэрээг байгуулах асуудлыг хурдасгах нь чухал юм. 2023 онд НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссар, НҮБ-ын тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч, НҮБ-ын эрүүдэн шүүхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчид Эрүүдэн шүүхээс ангид худалдааны хэлэлцээрийг дэмжиж байгаагаа илэрхийлсэн.

Засгийн газар болон олон улсын санхүүгийн байгууллагууд өрийн дарамтаас үүдэн хүний эрхийн үүргээ хэрэгжүүлж чадахгүй байгаа улс орнуудын өрийг тэглэх зэргээр өрийг бууруулах арга хэмжээг авах шаардлагатай. Мөн бүх нийтийн нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийж, орлого багатай улс орнуудыг дэмжих Нийгмийн Халамжийн Дэлхийн Сан байгуулж, даян дэлхийн нийгмийн хамгааллын тогтолцоог бий болгоход хамтран ажиллах ёстой.¹⁵ Засгийн газрууд НҮБ-ын татварын конвенц батлах санаачилгад хамтран ажиллах шаардлагатай. Түүнчлэн эрчим хүчний өргөн хүрээний шилжилтийн нэг хэсэг болсон чулуужсан түлшийг бүрэн хэмжээнд, яаралтай, тэгш байдлаар хэрэглээнээс гаргах амлалт өгөх нь зүйтэй. Тэд НҮБ-ын Эрүүдэн шүүхээс ангид худалдааны хэлэлцээрийг байгуулах чиглэлд ажиллаж, хүний эрх хамгаалагчдын хамгаалалтыг баталгаажуулах шаардлагатай.

ОДОО ХЭРЭГЛЭГДЭЖ БАЙГАА БОЛОН ШИНЭЭР НЭВТЭРЧ БҮЙ ТЕХНОЛОГИЙН АЮУЛ

Үүсгэгч хиймэл оюун ухааны хэрэгслүүд бий болж байгаа талаарх сүүлийн саруудад гарсан хэвлэлийн мэдээнд тэдгээр технологи болон одоо ашиглаж байгаа технологийн хүний эрх, ялангуяа нийгмийн хамгийн ихээр ялгаварлан гадуурхагдсан бүлгийн эрхэд ноцтой аюул заналхийлэл учруулж болохыг онцолж байна. Улс орнууд тагнуулын программ хангамжийн дэлхийн худалдаа болон Big Tech зэрэг томоохон технологийн компаниудын ажиглалтад суурилсан бизнесийн загварчлалыг хязгаарлах хангалттай арга хэмжээг авч чадсангүй.

ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ЭРСДЭЛҮҮД

Бичвэрийг үүсгэж, нэгтгэх чадвартай ChatGPT-4 технологийг 2023 онд гаргасан нь үүсгэгч хиймэл оюун ухаан хүмүүсийн амьдрал, төрийн үйлчилгээг авах хүртээмж болон интернэт платформ ашиглах туршлагыг хэрхэн өөрчлөх асуудал анхаарал татаж байна. Аливаа шинэ технологийн нэгэн адил хиймэл оюун ухаан боломжуудыг бий болгодог хэдий ч зохистой, үр дүнтэй зохицуулалтгүй нөхцөлд нийгмийн халамж хүртэх, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, хувийн нууцлал, цахим аюулгүй байдал зэрэг хүний эрхийн салбар дахь эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна. Арьс үндсээр алагчлах зэрэг бусад тэгш бус байдлыг бэхжүүлж, тандалт болон цахим орчинд үзэн ядах агуулгыг гааруулж байгаа нь эдгээр эрсдэлийн нэгээхэн хэсэг юм.¹⁶

Бусад технологи дундаас одоо байгаа хиймэл оюун ухааны систем нь тэгш бус байдлыг улам бүр бэхжүүлж, төрийн үйлчилгээг авах, аюулгүй байдал, цагдаагийн үйл ажиллагаа, цагаачлал зэрэг салбарт ялгаварлагдан гадуурхагдсан нийгмийн бүлэгт улам бүр хүндээр нөлөөлж байна.¹⁷ Серби улсад Дэлхийн банкнаас санхүүжүүлсэн хагас автомат нийгмийн хамгааллын шинэ систем олон мянган хүний нийгмийн чухал шаардлагатай тусламж хүртэх боломжийг алдагдуулсан. Үүний үр дагавар цыган болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст илүү хүндээр тусч байна. Израйл улс Палестины эзлэгдсэн нутаг дэвсгэрт царай таних технологийг ашиглаж байгаа нь чөлөөтэй зорчих эрх чөлөөг хязгаарлаж апартейд тогтолцоог хадгалахад улам бүр дэмжлэг болж байна. Нью-Йоркийн цагдаагийн газар тус хотод гарсан Хар арьстнуудын амьд явах эрхийн талаарх эсэргүүцлийн жагсаалын үеэр царай таних, тандах технологийг хэрхэн ашигласан талаарх мэдээлэл 2023 онд нийтэд ил болсон бөгөөд үүнийг хориглох талаар Нью-Йорк хотын зөвлөлд шаардлагууд иржээ. Түүнчлэн, шинэ технологид хөрөнгө оруулагч томоохон фирмүүд ихэвчлэн хүний эрхийг хүндэтгэх үүрэг хариуцлагаа хэрэгжүүлж чадахгүй байна.¹⁸

ТАГНАХ ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ДЭЛХИЙН ХУДАЛДАА

Улс орнууд тагнах программ хангамжийн дэлхийн худалдааг хязгаарлаж чадахгүй байна. 2023 онд Эмнести Интернэшнлийн хийсэн судалгаа нь Арменийн Доминикан, Энэтхэг, Сербийн сэтгүүлчид болон иргэний нийгмийн эсрэг Pegasus тагнуулын программ ашиглаж байсныг илрүүлэхэд тусалсан. Европын Мөрдөн шалгах хамтын ажиллагааны байгууллага болон Эмнести Интернэшнлээс хамтран Predator Files-т хийсэн үндсэн мөрдөн шалгах ажиллагааны үр дүн нь “Европын Холбооны зохицуулалт”-тай тагнах программыг дэлхий даяар улс орнууд хэрхэн чөлөөтэй худалдаалж байгаа нь ил болсон.¹⁹ Энэ талаарх мэдээлэл ил болсны дараа Европын Парламентаас тагнах программ хангамжийн үйлдвэрлэлийн зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ хангалтгүй байгааг шүүмжилж 2023 оны 11 дүгээр сард тогтоол баталсан. Ийнхүү зарим бодлого боловсруулагчид энэ чиглэлд арга хэмжээ авч байгаа эхлэл ажиглагдаж байна. Тухайлбал, 2023 оны 3 дугаар сард 11 улс тагнах программ хангамж нь хүний эрхэд аюул заналхийлэл үзүүлж байгааг хүлээн зөвшөөрсөн мэдэгдлийг гаргасан.

ТЕХНОЛОГИЙН ТОМООХОН КОМПАНИУДЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ

Технологийн томоохон компаниудын ажиглалтын технологид үндэслэгдсэн бизнес загварын хор аюул нь зөвхөн зэвсэгт мөргөлдөөн төдийгүй хүүхэд, залуучуудын эрхийг зөрчиж байгаа нь 2023 онд дахин ил болсон. TikTok-ийн контент санал болгох систем, өргөн хүрээний мэдээлэл цуглуулах ажиллагаа нь залуу хэрэглэгчдийн сэтгэцийн эрүүл мэндийг улам дордуулж, амиа хорлох, сэтгэл зүйн хямралд орох эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.²⁰ X (хуучнаар Twitter) платформд ЛГБТИ хүмүүсийн эсрэг өдөөн турхиралт аюултай хэмжээнд хүртлээ нэмэгдлээ.²¹

Улс төрийн буруу, ташаа мэдээллийн тархалт улам бүр нэмэгдэж байгаа нь 2024 онд болох олон тооны сонгуульд эрсдэл учруулахаар байна. Дэлхийн олон улсад

дарангуялагч улс төрийн хүчнүүд сонгуульд ялахын тулд цөөнх рүү дайрах, нийгмийг өөр хооронд нь хагаралдуулахын тулд нийгмийн сүлжээг зэвсэг болгон ашиглаж байна. Энэ нь оролцоо болон ашиг орлогыг ямагт чухалчилдаг Бийг Тех (Big Tech)-ийн нийгмийн сүлжээний алгоритмууд болон бизнес загварчлалыг дэмжиж, улам бүр хүчирхэгжүүлж байна. Үүсгэгч хиймэл оюун ухаан бий болж байгаа нь эрсдэлүүдийг улам нэмэгдүүллээ.

Нэг талаас зарим зохицуулагчид, нөгөө талаас хохирсон иргэд зөрчигдсөн эрхээ сэргээлгэхийн тулд цаашид хүчирхийлэл гарахаас урьдчилан сэргийлэх хүчин чармайлт гаргаж байна. 2023 оны 7 дугаар сард Европын Холбооны шүүхээс Фэйсбүүк(Facebook) болон Инстаграм(Instagram)-ийг эзэмшигч META (Meta) компаний ажиглалт-тандалтад суурилсан бизнесийн загварчлалын эсрэг томоохон шийдвэр гаргасан. Үүний дараахан Норвегийн эрх баригчид Мета компанийг тус улс дахь хэрэглэгчдийн байршлын тооцоолол болон цахим үйл ажиллагаанд үндэслэн хувь хүн рүү чиглэсэн зар сурталчилгаа явуулахыг зогсоохыг үүрэг болгосон шийдвэр гаргасан.

Европын Холбооны иргэний нийгмийн байгууллагууд дэлхийн хэмжээнд анх удаа Бийг Тех (Big Tech) -ийн үйл ажиллагааг цогц байдлаар зохицуулсан, хүний эрхийг хүндэтгэх амлалт бүхий 2022 онд батлагдсан Дижитал үйлчилгээний тухай хуулийг иж бүрэн байдлаар хэрэгжүүлэхэд төвлөрч байна. Гэвч хиймэл оюун ухааны эрсдэлийг шийдвэрлэх боломжгүй хэвээр байна. Европын Холбоо 2023 онд Хиймэл оюун ухааны тухай Европын Холбооны хуулийг батлах талаар зөвшилцөлд хүрсэн хэдий ч уг хуулийн эцэслэгдсэн төслийн бичвэрийн хор уршгаас урьдчилан сэргийлэх зохицуулалт хангалтгүй төдийгүй цагдаа, цагаачлалын албаны тандалтын үйл ажиллагааг өргөжүүлж, хууль ёсны болгоход хувь нэмэр оруулахаар байна.

Засгийн газрууд өргөн хүрээний хүчирхэг тагнах программыг нэн даруй хориглох ёстой. Түүнчлэн хиймэл оюун ухаан бүхий технологиос үүдэлтэй эрсдэл, хор уршгийг арилгахын тулд цогц хууль тогтоомж, зохицуулалтыг бий болгох ёстой. Засгийн газрууд ажиглалт-тандалтад суурилсан бизнесийн загварчлалын хор хөнөөлийг арилгах замаар Бийг Тех (Big Tech)-ийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох шаардлагатай.

-
1. "Challenges faced by women human rights defenders working in conflict, post-conflict or crisis-affected settings", 5 June
 2. "Global: Social media companies must step up crisis response on Israel-Palestine as online hate and censorship proliferate", 27 October
 3. "Ethiopia: Meta's failures contributed to abuses against Tigrayan community during conflict in northern Ethiopia", 31 October
 4. "Israel/OPT: US veto of ceasefire resolution displays callous disregard for civilian suffering in face of staggering death toll", 8 December
 5. "International Justice Day: Harnessing the Rome Statute and strengthening the system of international justice", 17 July
 6. *An Unstoppable Movement: A Global Call to Recognize and Protect Those Who Defend the Right to Abortion*, 24 November
 7. "Colonialism and sexual orientation and gender identity: Submission to the Independent Expert on protection against violence and discrimination based on sexual orientation and gender identity", 15 June
 8. "Global: Vote in favour of international cooperation on tax helps advance human rights", 22 November
 9. "Global: COP28 agreement to move away from fossil fuels sets precedent but falls short of safeguarding human rights", 13 December
 10. "Global: Initial pledges at COP28 to finance the Loss & Damage Fund fall far short of what is needed", 30 November
 11. "Global: UN backs Pacific Island states by asking the International Court to advance climate justice", 29 March
 12. Anti-Corruption Fight in Peril: Crackdown on Anti-Corruption Human Rights Defenders in West and Central Africa, 11 July
 13. 'My Eye Exploded': The Global Abuse of Kinetic Impact Projectiles, 14 March
 14. "The repression trade", 11 October

15. Rising Prices, Growing Protests: The Case for Universal Social Protection, 10 May; Actions Speak Louder than Words: The World Bank Must Promote Universal Social Protection, 10 October
16. "Global: Companies must act now to ensure responsible development of artificial intelligence", 14 June
17. *Digitally Divided: Technology, Inequality, and Human Rights*, 2 October
18. *Silicon Shadows: Venture Capital, Human Rights, and the Lack of Due Diligence*, 13 December
19. *The Predator Files: Caught in the Net*, 9 October
20. 'I feel exposed': Caught in TikTok's surveillance web, 7 November; Driven into Darkness: How TikTok's 'For You' Feed Encourages Self-Harm and Suicidal Ideation, 7 November
21. "Hateful and abusive speech towards LGBTQ+ community surging on Twitter surging under Elon Musk", 9 February

АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Суданд дахин өрнөсөн хүчирхийлэл нь бүс нутгийн хэмжээнд зэвсэгт мөргөлдөөнд өртсөн энгийн иргэдэд асар их зовлон зүдгүүр учруулж байгаа төдийгүй мөргөлдөөнд оролцогч талууд олон улсын хүмүүнлэгийн хуулийг үл тоомсорлож байгааг харуулж байна. Олон тооны энгийн иргэд хохирсон, тэр дундаа энгийн иргэд рүү чиглэсэн, эсхүл тэднийг ялгахгүйгээр үйлдсэн өргөн хүрээний халдлагын талаарх сэтгэл цочирдом мэдээлэл удаа дараалан гарсаар байна.

Засгийн газрыг шүүмжлэх нь Африкийн улс орнуудад аюултай хэвээр байв. Засгийн газрын хэрээс хэтэрсэн үйл ажиллагаа, алдаа дутагдал, авлигын үйлдлийг шүүмжлэгчид, ялангуяа сэтгүүлчид, хүний эрхийг хамгаалагчид, идэвхтнүүд, сөрөг хүчний удирдагчид, гишүүдийг эсрэг харгис хэрцгий ажиллагаа өргөн хүрээнд явагдсаар байна. Эсватини улсад хүний эрхийн нэр хүнд бүхий хамгаалагч Тулани Масеко, Камерун улсад сэтгүүлч Мартинез Зого нарын амь насыг хөнөөсөн бол Руандагийн эрэн сурвалжлах сэтгүүлч Жон Уильям Нтвали сэжигтэй нөхцөлд нас барсан нь хүний эрхийн хөдөлгөөний хувьд хар бараан мөч байлаа.

Инфляц, авлига, уур амьсгалын өөрчлөлт, мөргөлдөөн зэрэг нийлмэл хүчин зүйлүүд нь амьдрахад маш хүндрэлтэй нөхцөлд хүргэж байна. Олон сая хүн эдийн засаг, нийгмийн үндсэн эрхээ эдлэх боломжгүй байв. Хүнсний үнэ өссөн нь зарим улс оронд илүү хүндээр нөлөөлж, хүнсний аюулгүй байдал ноцтой түвшинд хүрсэн.

Тасралтгүй өрнөсөн зэвсэгт мөргөлдөөн, цаг агаарын эрс тэс үзэгдлүүд олон сая хүнийг орон гэрээ орхин дүрвэхэд хүргэсэн боловч зарим улсын эрх баригчид дүрвэгсэд болон орогнол хүсэгчдийг хамгаалах үүргээ биелүүлсэнгүй.

Охид, эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл газар авсан хэвээр байгаа бол ижил хүйстнүүдийн эсрэг дайралт, ЛГБТИ хүмүүсийн эрхийг үгүйсгэх явдал бүс нутгийн түвшинд улам бүр даамжирлаа.

Африкийн улс орнуудын засгийн газар хүний эрхийн зөрчилд ял шийтгэл хүлээдэггүй байдлыг өөрчлөх шаардлагыг үл тоомсорлосон хэвээр байгаа бөгөөд энэ нь хүний эрхийн зөрчил, хүчирхийлэл, хууль дээдлэх ёсыг үл тоомсорлох явдлыг улам бүр өдөөж байна. Бүс нутгийн олон улс шударга ёс, хариуцлагын талаарх санаачилгыг үл тоомсорлож, хүний эрхийн олон улсын хяналтад илт саад учруулсаар байна.

ХУУЛЬ БҮС ХАЛДЛАГА, АЛЛАГА

Зэвсэгт мөргөлдөөн Буркина Фасо, Камерун, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс (ТАБНУ), Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс (БНАКУ), Мали, Нигери, Сомали, Судан болон бусад улс орны энгийн иргэдэд асар хортой нөлөөлсөөр байна. Үндэс угсаатны ялгаатай байдалд үндэслэсэн халдлага болон энгийн иргэдийг зориудаар онилоогүй халдлагын үед агаарын дайралт, пуужин, миномет болон бусад өргөн хүрээнд хохирол учруулах тэсрэх зэвсэг гэх зэрэг энгийн иргэдийг ялгах боломжгүй халдлага, довтолгооны үр дагаврыг энгийн иргэд амссаар байна. Эдгээр халдлагын зарим нь дайны гэмт хэрэг байсан.

Судан улсад тус улсын Зэвсэгт хүчин (SAF) болон Шуурхай дэмжлэг үзүүлэх

хүчин (RSF) хоорондын тулалдааны улмаас 12,000 гаруй хүн амь үрэгджээ. Нийслэл Хартум хот, ялангуяа Баруун Дарфур зэрэг хэд хэдэн хэсэг рүү чиглэсэн дайралтын үеэр тус улсын зэвсэгт хүчин болон шуурхай дэмжлэг үзүүлэх хүчний хүн ам ихээр суурьшсан хороолол руу хөөргөсөн тэсрэх бөмбөгний улмаас энгийн иргэд амь үрэгдэж, шархадсан.

Буркина Фасо улсад 2 дугаар сард Исламын Ансарул зэвсэгт бүлэглэлийн гишүүд Партиага хотод 60 гаруй энгийн иргэнийг, зургаан сарын дараа Нохоа хотод дахин 22 хүний амь насыг хөнөөсөн. Засгийн газрын цэргүүд энгийн иргэд рүү халджээ. Эх Орноо Хамгаалах Сайн Дурынхныг дагалдан ирсэн цэргүүд Карма тосгонд 147 энгийн иргэнийг хөнөөжээ. БНАКУ-д зэвсэгт бүлэглэлүүд хамгийн багадаа 4000 хүний амь насыг хөнөөж, олон мянган хүнийг шархдуулсан. Тус улсын Норд-Киву бүсэд Холбоотны Ардчилсан хүчний зэвсэгт бүлэглэл 23 хүний амийг хөнөөжээ. Итури бүсэд Конгогийн Хөгжлийн Нэгдэл зэвсэгт бүлэглэл нэг шөнийн дотор 46 хүнийг буудаж хөнөөсний тал нь хүүхэд байв. Мали улсын Сахел дахь Исламын Улс бүлэглэлийнхэн Гао бүсийн Гайна, Бойна тосгонд хийсэн халдлагын улмаас 17 хүн амь үрэгджээ. Хоёр сарын дараа Бандиagara бүсийн Бодио, Яроу тосгонд Ислам болон Лалыг Дэмжих бүлгийн гишүүд халдлага үйлдэж, 37 энгийн иргэний амь насыг хохироожээ.

Нигерийн агаарын цэргийн довтолгооны улмаас Нигер мужид 21 энгийн иргэн амиа алдсан бол Сомалийн аюулгүй байдлын хүчнийхний Лас Анод хот руу үйлдсэн халдлагын улмаас аюулгүй байдлын хүчин болон зэвсэгт дайчдын хооронд шинэ мөргөлдөөн гарч, 36 энгийн иргэн амиа алдсан.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд энгийн иргэд болон иргэний дэд бүтцийн байгууламж руу чиглэсэн, тэдний ялгахгүйгээр халдлага үйлдэх явдлыг эцэс болгох замаар энгийн иргэдийн эрхийг хамгаалах шаардлагатай.

ЗӨРЧИЛДӨӨНТЭЙ ХОЛБООТОЙ БЭЛГИЙН БОЛОН ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

Зөрчилдөөнтэй холбоотой бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл, тухайлбал хүчин, бүлэглэн хүчиндэх, хулгайлах, бэлгийн боолчлол өргөн тархсан хэвээр байгаа бөгөөд амьд үлдсэн олон хохирогчид нэн шаардлагатай эмнэлгийн болон сэтгэц-нийгмийн тусламж авах боломжгүй байв. Эритрейн Батлан Хамгаалахын цэргүүд Этиопын Тиграй дахь цэргийн хуаранд хамгийн багадаа 15 эмэгтэйг гурван сар орчим олзлон, удаа дараа хүчирхийлсэн байна. Буркина Фасо улсад Ансарул Исламын гишүүд Сахел мужийн Лики тосгоны ойролцоо 66 охид, эмэгтэйчүүд, дөнгөж төрсөн нярайг хулгайлсан. Тэднийг дөрөв хоногийн дараа Тугури дахь шалган нэвтрүүлэх цэгээс сулласан байна. “Боко Харем”-ын дайчид Нигерийн Борно мужийн Мафа нутгийн захиргааны бүсээс 40 гаруй эмэгтэйг хулгайлжээ.

НҮБ Төв Африкийн Бүгд Найрамдах улсад (ТАБНУ) хүчингийн хэргийн нотлох баримт цуглуулж, Танзанийн 11 энхийг сахиулагчийг буруутгаж байгаагаа зарлав. БНАКУ-ын зөвхөн Норд-Киву бүсэд 2023 оны эхний улирлын байдлаар бэлгийн хүчирхийллийн 38,000 гаруй тохиолдол бүртгэгджээ. Мали улсад НҮБ мөн хугацаанд мөргөлдөөнтэй холбоотой охид, эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн 51 тохиолдол бүртгэгдсэн. Суданд олон тооны охид, эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийлэлд өртсөн бөгөөд тэр дундаа Шуурхай Дэмжих Хүчин болон холбоотнуудын дайсагнагч талуудын гишүүд хүчингийн хэрэг үйлдэх нь олширчээ. Шуурхай Дэмжих Хүчний гишүүд 24 охид, эмэгтэйчүүдийг хулгайлж, бэлгийн боолчлолын нөхцөлд Няла дахь зочид буудалд олон хоног байлгасан байна.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийллийн үйлдлийг хориглох тухай тодорхой, ойлгомжтой тушаал шийдвэрийг гишүүд, цэргийн хүчнийхэндээ өгөх; засгийн газрууд ийм хүчирхийлэлд өртсөн хүмүүсийг эмнэлгийн болон сэтгэц-нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд бүрэн хамруулах баталгааг хангах шаардлагатай.

ЭСЭРГҮҮЦЭЛ, ШҮҮМЖЛЭЛИЙГ НУХЧИН ДАРЖ БАЙГАА НЬ

ТАЙВАН ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ

Бүс нутаг даяар иргэд амьжиргааны үнийн өсөлт, муу засаглал, хүний эрхийн зөрчил зэрэг тоо томшгүй олон асуудалд санаа зовниж байгаагаа илэрхийлэн гудамж, талбайд жагсжээ. Ихэнх тохиолдолд аюулгүй байдлын хүчнийхэн хүч албадлага хэтрүүлэн хэрэглэн эсэргүүцлийн жагсаал, цуглааныг тараажээ. Ангол, Этиоп, Кени, Мали, Мозамбик, Сенегал, Сомали зэрэг улсад олон тооны жагсагчид болон жагсаалыг хөндлөнгөөс ажиглаж байсан иргэд амь үрэгдэж, шархаджээ. Кени улсад л гэхэд гуравдугаар сараас долдугаар сарын хооронд болсон эсэргүүцлийн жагсаалын үеэр цагдаа нарын гарт хамгийн багадаа 57 хүн амь эрсэджээ. Өнгөрсөн зургадугаар сард Сенегал улсын нийслэл Дакар, Зигунчор хотод болсон хүчирхийллийн жагсаалыг тараахын тулд цагдаа болон энгийн хувцастай зэвсэгт этгээдүүд галласны улмаас наад зах нь 29 хүн амиа алджээ.

Чад, Гвинеи, Сенегал, Сьерра-Леонд зэрэг улсад жагсаал цуглаан хийхийг үрэгдчилэн хоригложээ. Эдгээр хориг нь ихэвчлэн иргэний нийгэм, сөрөг хүчний нам, удирдагчдын зохион байгуулсан жагсаал, цуглаан руу чиглэджээ. Чад улсад сөрөг хүчний намуудын зохион байгуулсан хоёр жагсаалыг улс төрийн нам хууль ёсоор байгуулагдаагүй, жагсаал зохион байгуулах зөвшөөрөл олгох болзлыг хангаагүй гэсэн үндэслэлээр Олон нийтийн аюулгүй байдлын яамнаас хоригложээ. Гвинеи улсад 2022 оны 5 дугаар сараас хойш улс төрийн бүх төрлийн цугларалтыг хориглосон хориг хэвээр байгаа ч төрийн тэргүүнийг дэмжсэн хэд хэдэн цугларалтыг үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байна.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд улам заналхийлсээр байсан. Засгийн газрын бодлого, үйлдэл, эс үйлдэхүйн эсрэг үг хэлэх, эсхүл засгийн газарт хохиролтой мэдээллийг олон нийтэд түгээх нь баривчлах, дур зоргоороо цагдан хорих, амь насаа алдах эрсдэлд хүргэж байна. Эсватини дахь хүний эрхийн хамгаалагч Тулани Масеко гэртээ алагджээ. Засгийн газартай ойр ажилладаг хүмүүсийн авлигын талаар мэдээлэл хийсэн сэтгүүлч Мартинез Зогогийн зэрэмдэглэсэн цогцсыг түүнийг хулгайлагдсанаас хойш тав хоногийн дараа Камеруны Яунде хотын захаас олжээ. Хүний эрхийн асуудлаар эрэн сурвалжлах сэтгүүлч Жон Уильямс Нтвали аюулгүй байдлынхаа талаар санаа зовниж байгаагаа өөр нэгэн сэтгүүлчид хэлсний дараагийн өдөр нь Руанда улсад сэжигтэй нөхцөл байдалд нас баржээ.

Өмнөд Суданы ерөнхийлөгч шээж буй бичлэг олон нийтийн сүлжээгээр тархсантай холбогдуулан долоон сэтгүүлчийг нийслэл Жуба дахь Үндэсний аюулгүй байдлын албаны цагдан хорих газарт дур мэдэн саатуулжээ. Тэднийг 10 долоо хоног хүртэл хугацаагаар цагдан хорьсон бөгөөд эцэст нь ямар нэг шийдвэргүйгээр суллажээ. Тэдний нэг нь эрүү шүүлт болон бусад зүй бус харьцаанд өртсөн байж болзошгүй.

Сомали улсын шүүхээс «Засгийн газрын шийдвэрийг биелүүлээгүй» үндэслэлээр Сомалийн сэтгүүлчдийн нэгдсэн нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга, сэтгүүлч Абдалле Ахмед Муминд хоёр сар хорих ял оноосон. Түүнийг хоёр сар гаруй хугацаанд цагдан хоригдсоны дараа сулласан боловч долоо хоногийн дараа дахин баривчилж улмаар дахин нэг сар цагдан хорьжээ. Танзани улсад 6 дугаар сараас 12 дугаар сарын хооронд хамгийн багадаа 12 хүнийг Танзани/АНЭУ-ын боомтын гэрээг шүүмжилсэн хэргээр баривчилж, хэд хоногийн дараа ямар нэг болзолгүйгээр суллажээ.

Шүүмжлэгчдийг шүүхээр дарамтлах явдал түгээмэл байсаар байна. Бурунди улсад сэтгүүлч Флориан Ирангабие “үндэсний нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулсан” хэргээр 10 жилийн хорих ялаар шийтгүүлэв. Тэрээр шүүхийн шийдвэрийг давж заалдсан хэдий ч радио нэвтрүүлэгт өгсөн тайлбарт үндэслэн түүнд ногдуулсан ялыг давж заалдах шатны шүүхээс хэвээр үлдээжээ. Бенин улсад онлайн радио станцын мэдээний захирал Виржил Ахуансыг «худал мэдээлэл тараасан» хэрэгт буруутган 12 сар хорих ял оноосон. Тэрээр 2022 онд цагдаа нар бусдыг шүүхээс гадуур цаазалсан гэж буруутгасан гэрчийн мэдүүлэг бүхий мэдээллийг олон нийтэд түгээсэн юм. Самира Ибрахимыг Алжир улс Нигерийн цэргийн дэглэмийг хүлээн зөвшөөрөөгүй хэмээн фэйсбүүк хуудсаараа дамжуулан мэдээлснийх нь төлөө Нигер улсын шүүхээс «нийтийн хэв журмыг алдагдуулах ... мэдээлэл ... бий болгосон» хэрэгт буруутган шийтгэжээ.

Төв Африкийн Бүгд Найрамдах Улс /ТАБНУ/, Чад, Мали, Танзани, Того зэрэг улс хэд хэдэн сэтгүүлч, хүний эрх хамгаалагч, идэвхтнүүдийг тус улсыг орхин явахыг шаарджээ. Того улсад засгийн газрын хоёр гишүүнийг авлигын хэрэгт буруутгасан нийтлэл хэвлэгдсэний дараа L'Alternative сонины Фердинанд Айите, Исидор Ковоноу нарт гурван жилийн хорих ял болон их хэмжээний торгуулийн шийтгэл ногдуулжээ. Тэд ял шийтгэл хүлээхээс зайлсхийхийн тулд эх орноосоо дүрвэжээ. ТАБНУ-д Үндэсний ассамблей дахь авлигын талаар бичсэн сэтгүүлчийг үл мэдэгдэх эх сурвалжаас заналхийлсний дараа тэрээр эх орноосоо дүрвэжээ. Мали улсад хүний эрх хамгаалагч Амината Дикког НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд хийсэн мэдээлэлдээ зэвсэгт хүчний үйлдсэн хүчирхийллийг буруушаасных нь төлөө түүнийг эх орноосоо урвасан, улсын нэр төрд халдсан гэх үндэслэлээр хууль сахиулах цэргийн хүчин түүнээс байцаалт авахаар дууджээ.

Бенин, Буркина Фасо, Чад, Нигер, Того болон бусад улсын эрх баригчид хэвлэл мэдээллийн байгууллагууд, сонин, мэдээллийн вэбсайтуудын үйл ажиллагааг түр зогсоожээ. Нийгэм, улс төрийн үймээнтэй байгаа Этиоп, Гвиней, Мавритани, Сенегал зэрэг улсын эрх баригчид интернэтийн хандалтыг түдгэлзүүлж, тасалдуулсан байна. Нигерийн Үндэсний өргөн нэвтрүүлгийн хороо 2023 оны бүх нийтийн сонгуулийг сурвалжилсан 25 хэвлэл мэдээллийн байгууллагыг өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг зөрчсөн гэх үндэслэлээр торгууль ногдуулжээ. Бусад улсын эрх баригчид, тухайлбал Бенин улсад Gazette du Golfe хэвлэлийг тодорхойгүй хугацаагаар түдгэлзүүлсэн байна. Буркина Фасо улсад гадаадын хоёр сурвалжлагчийг тус улсаас хөөсөн бол Нигерт L'Invinement сониныг татвар төлөөгүй гэх үндэслэлээр үйл ажиллагааг нь зогсоожээ.

ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд үндэслэлгүйгээр ноцтой хязгаарлалт тогтоох нь нэмэгдэв. Сөрөг хүчнийхнийг онилж, тэдний зохион байгуулах, үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулах боломжийг нь улам бүр боомилсоор байна. Бурунди улсын эрх баригчид гол сөрөг хүчин болох Эрх чөлөөний төлөөх үндэсний конгрессын бараг бүх үйл ажиллагааг түр зогсоов. Долдугаар сард Нигер улсад өрнөсөн төрийн эргэлтийн дараа цэргийнхэн улс төрийн намуудын бүх төрлийн үйл ажиллагааг тодорхойгүй хугацаагаар зогсоожээ. Уганда улсад Үндэсний Нэгдсэн Хөдөлгөөн

намын сонгуулийн сурталчилгааны цугларалт,бусад үйл ажиллагааг түр зогсоожээ. Танзани улсын ерөнхийлөгч 2016 онд улс төрийн намуудын жагсаал цуглаан болон улс төрийн бусад үйл ажиллагаа явуулахыг хориглосон хоригийг цуцалсан нь эерэг алхам болсныг тэмдэглэж байна.

Эрх баригчид хүний эрх, тэр дундаа эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлахад чиглэсэн хуулиудыг улам бүр хүчирхэгжүүлсээр байна. ТББ-уудын үзэж байгаагаар Ангол улсад эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлаж, гүйцэтгэх засаглалд үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцох хэт их эрх мэдлийг олгосон Төрийн бус байгууллагын тухай хуулийн төслийг парламент баталжээ.

ДҮР МЭДЭН БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ, ЭРҮҮДЭН ШҮҮХ, БУСАД ЗҮЙ БУСААР ХАРЬЦАХ

Дур мэдэн баривчлах, цагдан хорих явдал өргөн хүрээнд явагдсан хэвээр байна. Аюулгүй байдлын хүчнийхэн эсэргүүцлийн жагсаал, цуглааныг тараах, онц байдал зарлах үед иргэдийг олноор нь баривчлах, цагдан хорьжээ. Өнгөрсөн наймдугаар сард Этиоп улсын Амхара бүсэд өрнөсөн цэргийн хүчин болон Фаногийн зэвсэгт хүчний хоорондын зэвсэгт мөргөлдөөний дараа тус улсын засгийн газар улс даяар зургаан сарын хугацаатай онц байдал тогтоосон нь өмгөөлөгч авах, шүүхэд хандах эрхээ хэрэгжүүлэх боломжгүй олон зуун хүнийг цагдан хорих урьдач нөхцөлийг бүрдүүлэв. Сенегал улсад 1000 гаруй хүнийг эсэргүүцлийн жагсаалд оролцсон, эсхүл сөрөг хүчний улс төрийн намтай холбоотой гэх үндэслэлээр баривчилж, цагдан хорьжээ.

Ботсвана, Бурунди, Нигер, Зимбабве зэрэг улсад олны танил улс төрчдийг баривчилж, дур мэдэн цагдан хорьжээ. Ботсванад улс төрийн сөрөг хүчин болох Ботсвана Эх орончдын Фронт намын хэд хэдэн удирдагч, хоёр сэтгүүлчийг баривчилж, үндэслэлгүйгээр хоёр хоног цагдан хорьжээ. Нигер улсад өрнөсөн төрийн эргэлтийн дараа ерөнхийлөгч Базоум гэр бүлийн хамт ерөнхийлөгчийн ордонд цагдан хорьжээ. Засгийн газрын гишүүн асан болон эрх баригч намын хэд хэдэн албан тушаалтныг үндэслэлгүйгээр цагдан хорьжээ. Зимбабве улсын сөрөг хүчний «Зимбабве Шинэтгэл» намын дарга Жейкоб Нгаривхумыг 48 сарын хугацаагаар хорих ялаар шийтгэснийг найман сарын дараа давж заалдах шатны шүүхээр цагаатгасан. Тэрээр 2020 оны долдугаар сард авлигын эсрэг жагсаалыг удирдаж, зохион байгуулсан хэргээр баривчлагдаж байжээ.

Түүнчлэн БНАКУ, Экваторын Гвиней, Мали болон бусад улсад дур мэдэн баривчилж, цагдан хорьсон тухай мэдээлэл бүртгэгдсэн.

Цагдан хорих ангид эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах явдал сэтгэл түгшээсн хэвээр байна. Экваторын Гвиней, Лесото, Мавритани, Нигери зэрэг улсын цагдаагийн урьдчилан хорих газарт саатуулагдсан иргэд гаднын нөлөөтэй нас барсан байж болзошгүй хэд хэдэн тохиолдол бүртгэгджээ. Мавритан улсад хүний эрхийн хамгаалагч Суви Оулд Жибрил Оулд Чейн цагдаагийн газарт байцаагдаж байгаад нас баржээ. Албан ёсны задлан шинжилгээгээр түүнийг боомилсны улмаас нас барсан гэж дүгнэсэн нь зүрхний шигдээсээр нас барсан гэсэн эрх баригчдын мэдэгдэлтэй зөрчилдөж байна. Комиссар болон холбогдох цагдаагийн ажилтнуудыг баривчлах шийдвэрийг Улсын яллагч гаргасан. Нигер улсад Фаиз Абдуллахи байцаалтын үеэр эрүүдэн шүүгдсэний улмаас Кадуна хотын цагдаагийн газарт нас баржээ. Нигер улсын Адамава мужид цагдаа нар байцаалтын үеэр эрүүдэн шүүлтийн улмаас 17 настай оюутан охин эмнэлэгт нас баржээ.

ШҮҮХЭЭС ГАДУУР ЦААЗААР АВАХ, ХҮЧЭЭР АЛГА БОЛОХ

Хэд хэдэн улсад шүүхээс гадуур цаазаар авах болон хууль бус аллага, хүчээр алга болгох үйлдлийг хэлмэгдүүлэлтийн хэрэгсэл болгон ашигласаар байна. Буркина Фасо улсад олон нийтийн зүтгэлтнүүдийг хулгайлах, баривчлах, хүчээр алга тохиолдол гарсаар байна. Тухайлбал, малчдын эрх ашгийг төлөөлдөг байгууллагын үндэсний ерөнхийлөгч энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болжээ. Бурундид улс төрийн өрсөлдөгчдийг хүчээр алга болгох хэрэг гарсан бөгөөд уг гэмт үйлдэлд Үндэсний тагнуулын алба болон эрх баригч намын залуучуудын жигүүр болох Имбонеракюрын гишүүдийг буруутгаж байна. Эритрей улсад 2001 онд ерөнхийлөгчийн эсрэг олон нийтийн өмнө үг хэлж байсан 15 томоохон улстөрчөөс бүрдсэн G15 бүлгийн 11 гишүүний хувь заяа, хаана байгаа нь тодорхойгүй хэвээр байв. Мөн G-15 бүлэгтэй холбоотой хэмээн буруутгагдаж буй 16 сэтгүүлчийн хувь заяа тодорхойгүй байв.

Засгийн газрууд сэтгүүлч, хүний эрх хамгаалагчид, идэвхтэн, сөрөг хүчний гишүүд, удирдагчдыг хүчирхийлэх, айлган сүрдүүлэх явдлыг зогсоож, хууль бусаар баривчлагдсан хүнийг нэн даруй, болзолгүйгээр суллах, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хүндэтгэх, тэр дундаа хэвлэл мэдээллийн хэрэгслийг бие даан ажиллах нөхцөлийг олгох ёстой.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЭРХ

ХҮНСНИЙ ЭРХ

Африкийн олон улс орнууд хүнсний үнийн өндөр инфляцад хамгийн ихээр нэрвэгдсэн орнуудын тоонд багтжээ. Баталгаагүй хоол хүнс хэрэглэж байгаа хүмүүсийн тоо шийдвэрлэх боломжгүй хэмжээнд хүрсэн. Дэлхийн хүнсний хөтөлбөрийн тооцоолсноор хоёрдугаар сарын байдлаар Сьерра Леон улсын хүн амын 78 хувь нь хүнсний хомсдолд орсон бол өрхийн 20 хувь нь хүнсний ноцтой хомсдолд оржээ. 12 дугаар сард НҮБ-ын Хүмүүнлэгийн асуудал зохицуулах газраас Өмнөд Суданы нийт хүн амын 46 хувь буюу 5.83 сая хүн хүнсний аюулгүй байдлын ноцтой асуудалтай тулгарсныг мэдэгдэв. Намиби улсад хүнсний аюулгүй байдлын асуудал эрс нэмэгдэж, нийт хүн амын 22 хувьд нөлөөлжээ.

Уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын эрс тэс үзэгдлүүд хүнсний хямралыг улам хурцатгав. Мадагаскарт 1, 2 дугаар сард болсон хоёр хар салхины улмаас ургац сүйдэж хүнсний аюулгүй байдлын асуудал нэмэгдэж бөгөөд гамшигт өртсөн бүс нутагт хүмүүнлэгийн тусламж хүргэхэд бэрхшээл тулгарав. Сомали улсад 5 сая орчим хүн хүнсний хямралд өртсөн бөгөөд ган гачгийн улмаас экспортынхоо 90 хүртэлх хувийг хангадаг хөдөө аж ахуйн салбар уналтад оров.

Зэвсэгт мөргөлдөөн нь нөхцөл байдлыг улам хурцатгав. Буркина Фасо улсад зэвсэгт бүлэглэлүүд хамгийн багадаа 46 хот, хотыг бүсэлж, шаардлагатай хангамжийн хүртээмжийг тасалдуулж, оршин суугчдын тариалангийн талбай руу нэвтрэх боломжийг хааж, усан сангийн байгууламжийг эвдлэн сүйтгэжээ. Этиопын Тиграй бүсэд үзүүлсэн хүнсний тусламжийг засгийн газрын агентлагууд болон цэргийнхэн өөр тийш нь шилжүүлсэн гэх нотлох баримтыг үндэслэн Олон улсын тусламжийн агентлагууд хүнсний тусламжийг зургаан сарын турш зогсоов. Энэ нь хүнсний хомсдолд аль хэдийнээ нэрвэгдсэн 4 сая гаруй хүнд нөлөөлж, олон зуун хүн нас баржээ.

Засгийн газрууд инфляцтай тэмцэх, дотоодын зах зээлийн хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Тухайлбал, Сьерра-Леон улс хөдөө аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэх, хүнсний бүтээгдэхүүнээр өөрийгөө хангах хөтөлбөр баталсан, Кот-д’Ивуар будаа, элсэн чихрийн экспортоо зогсоосон. Гэвч олон улсын авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ хангалтгүй байв. 9 дүгээр

сарын байдлаар Чад улсын хүнсний аюулгүй байдалд олон улсын санхүүжилт 96.9 сая ам.доллар байсан нь шаардлагатай хэмжээнээс 128.1 сая ам.доллараар дутуу байна. Өмнөд Суданд НҮБ-ын хүмүүнлэгийн төслийн санхүүжилт хангалтгүй байгаагийн улмаас зөвхөн хүнсний аюулгүй байдлын хамгийн өндөр түвшинд байгаа хүмүүст хүнсний яаралтай тусламжийг үзүүлж байна.

СҮРЧ БОЛОВСРОХ ЭРХ

Мөргөлдөөнд нэрвэгдсэн орнууд, ялангуяа Буркина Фасо, Камерун, БНАКУ, Нигер зэрэг улсад сурч боловсрох эрхийг үгүйсгэж, ноцтойгоор хязгаарлажээ. Буркина Фасо улсад 10 дугаар сарын байдлаар 6,549 сургууль хаагдсан бөгөөд жилийн хугацаанд ердөө 539 орчим сургууль дахин ажиллажээ. Энэ нь нэг сая гаруй хүүхдэд нөлөөлжээ. 1-7 дугаар сарын хооронд Камерун улсын баруун хойд болон баруун өмнөд бүс нутагт хүүхдүүд, багш нарыг хулгайлах гэх зэрэг боловсролын байгууллагуудын эсрэг 13 хүчирхийллийн хэрэг бүртгэгдэж, дор хаяж 2,245 сургуулийг хаажээ. БНАКУ-д мөргөлдөөнд хамгийн их нэрвэгдсэн зүүн нутгийн хоёр мужид 750,000 орчим хүүхдийн боловсрол эзэмшиж чадахгүй байна. Мянга мянган сургууль халдлагад өртөж, аюулгүй байдлын улмаас үйл ажиллагаагаа зогсоож, сургуулийн ихэнх байрыг дүрвэгсдийн хоргодох байр болгон ашигласан.

Зарим эерэг үр дүн ажиглагдаж байна. Тухайлбал, Замби улс бага сургуулийн насны хүүхдүүдэд зориулсан үнэ төлбөргүй боловсролын хөтөлбөрийг 1 дүгээр сард эхлүүлсэн бөгөөд дээрх хөтөлбөрийн хүрээнд 4500 багш шинээр ажилд авчээ. Танзани улсад хамран сургах, бичиг үсэгт тайлагдсан байдал ерөнхийдөө нэмэгдэж, хүүхдүүдийн сургуульд ороход тулгарч буй саад бэрхшээл багассан байна. Хэдийгээр 2022 онд жирэмсэн охид, өсвөр насны ээжүүдийн сургуульд суралцахыг хориглосон шийдвэрийг цуцалсан хэдий ч хамрагдалтын хувь хэмжээ бага байгаа хэвээр байна.

ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛУУЛАХ ЭРХ

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж улс орнуудад хүнд хэвээр байна. 2021-2022 оны хооронд Бавку хотод эмнэлгийн үйлчилгээ авч чадаагүйн улмаас 27 жирэмсэн эмэгтэй нас барсан талаар Гана улсын Эрүүл мэндийн албанаас хоёрдугаар сард мэдээлсэн. Өмнөд Африкт 3 дугаар сард өрнөсөн цалинтай холбоотой ажил хаялтын улмаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж алдагдаж дөрвөн хүн нас барсан хэмээн Эрүүл мэндийн сайд мэдэгдэв. Үүний зэрэгцээ Конго, Өмнөд Судан болон бусад газарт шигеллээ, холер, тайвойд болон бусад тахал өвчин бүртгэгдсэн.

АЛБАДАН НҮҮЛГЭЛТ

Засгийн газрууд бүтээн байгуулалтын төсөл нэрийдлээр албадан нүүлгэх ажиллагаа явуулсаар байна. Бенин улсын Котону болон Оуида хотуудын хооронд далайн эрэг дагуух аялал жуулчлалын төслүүдтэй холбогдуулан албадан нүүлгэлтэд өртсөн олон мянган хүмүүс зохистой нөхөн олговор авч чадахгүй талаар гомдол гаргав. БНАГУ эрчим хүчний шилжилтийн ашигт малтмалын дэлхийн эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор Луалаба бүсэд кобальт, зэсийн уурхайнуудыг өргөжүүлсэн нь олон мянган хүнийг орон гэр, тариалангийн талбайнаас нь албадан нүүлгэхэд хүргэсэн.

Зүүн Африкийн Түүхий Нефтийн Хоолой төслийн байгууламж барихад шаардлагатай газрын асуудлыг шийдвэрлэхийн тулд Уганда улсын Хойма дүүрэгт аюулгүй байдлын хүчнийхэн 500 орчим гэр бүлийг газар нутгаас нь албадан нүүлгэн шилжүүлэхдээ хүчирхийлэл үйлдэв. Танзани улсын Нгоронгоро хамгаалалтын газарт ээрлэг ан амьтдын хамгаалалттай бүс байгуулах нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг

хэрэгжүүлэх явцад өвөг дээдсийнхээ газар нутгийг орхихоос татгалзсан хамгийн багадаа 67 Маасай уугуул иргэдийг баривчлав. Уг баривчилгаанд гол төлөв Эндүлэн тосгоны уугуул иргэд өртжээ.

Засгийн газрууд нийгэм, эдийн засгийн хүндрэлийг шийдвэрлэх арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлж, хүн амынхаа эдийн засаг, нийгмийн эрхийг хангах наад захын үндсэн үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг бүрдүүлэх ёстой.

ДОТООДОО ШИЛЖИН СУУРЬШИГЧИД, ДҮРВЭГСЭД, ЦАГААЧДЫН ЭРХ

БНАКУ-д 7 сая орчим хүн дотооддоо дүрвэсэн гэсэн тооцоо гарсан нь Африкийн бүс нутагт хамгийн өндөр тоо юм. Тус улс Африкийн бусад улсаас зэвсэгт мөргөлдөөн, хавчлагад өртсөн 500,000 дүрвэгчийг хүлээн авчээ. 1-8 дугаар сарын хооронд БНАКУ-аас 45,000 орчим хүн Африкийн 1.6 сая гаруй дүрвэгчийг хүлээн авсан Уганда зэрэг хөрш улс руу дүрвэжээ.

Суданд дөрөвдүгээр сараас хойш 5.8 сая гаруй хүн дотооддоо дүрвэсэн нь 2023 онд дэлхийн хамгийн том нүүлгэн шилжүүлэлтийн хямралыг бий болгосон. Тэдний 4.5 сая гаруй нь зэвсэгт мөргөлдөөн эхэлсэн 4 дүгээр сараас 10 дугаар сар хүртэл дүрвэсэн бол ойролцоогоор 1.4 сая орчим Судан болон бусад үндэстнүүд хөрш улс орнууд руу дүрвэжээ. Гэвч зарим улс Суданы орогнол хүсэгчдийг нэвтрүүлэхийг хориглосон. Египетийн эрх баригчид Суданы бүх иргэдээс Судан дахь Египетийн консулын газраас олгосон нэвтрэх виз авахыг шаардсан бөгөөд 16-аас 50 насны хөвгүүд болон эрэгтэйчүүдэд нэвтрэх аюулгүй байдлын нэмэлт шаардлагыг шинээр тогтоожээ.

Нигер улсын хилийн суурин болох Ассамака тосгонд 1-4 дүгээр сарын хооронд Алжирын эрх баригчдын албадан гаргасан 9000 орчим дүрвэгч, цагаач иржээ. Малавид цагдаа нар хэдэн зуун дүрвэгчдийг нийслэл дэх гэр, бизнесээс нь баривчилж, Дзалека дүрвэгсдийн хуаранд шилжүүлжээ.

Засгийн газар дүрвэгсэд, орогнол хүсэгч, цагаачдыг хамгаалах үүргээ биелүүлж, орогнол хүсэх, буцаан шилжүүлэхгүй байх эрхийг хүндэтгэх ёстой.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

Эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх уламжлал нь ямар аймшигтай үр дагавартай болохыг Сьерра-Леонд нас барсан хоёр настай охины тохиолдол харуулсан. Энэ бүс нутагт хүүхдүүдийг эрт, хүчээр гэрлүүлэх практик байсаар байна. Замби улсад 20-24 насны эмэгтэйчүүдийн бараг 29 хувь нь 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн байжээ. Албадан гэрлэлтээс зугтан амиа алдсан 16 настай Назира охины хэрэг Нигер улсад эрт гэрлэлтийн хор хөнөөлийн асуудлыг олны анхааралд хүргэв.

Охид, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжид хэд хэдэн эерэг өөрчлөлт гарсан. Тухайлбал, БНАКУ жендэрт суурилсан айлган сүрдүүлэх, гутаан доромжлохыг гэмт хэрэгт тооцсон хууль батлагдсан бол Сьерра-Леонд төрийн буюу нийтийн албан тушаалын 30 хувьд эмэгтэйчүүдийг ажиллуулах шинэ хуулийг батлав. Өмнөд Африкт жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих байгууллагыг байгуулах хуулийн төслийг олон нийтийн хэлэлцүүлэгт шилжүүлсэн.

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

Зарим улсад ижил хүйстнүүдийн эсрэг хууль тогтоомж гаргалаа. Уганда улсад «хүндрүүлсэн нөхцөлтэй ижил хүйстний харилцаа»-ны гэмт хэрэгт цаазаар авах ял оноох шинэ хууль батлагдсаны дараа ЛГБТИ хүмүүсийн эсрэг хүчирхийлэл ихэссэн тухай мэдээллүүд гарсан. Кени улсын парламентын гишүүн ижил хүйстнүүдийн харилцан тохиролцсон бэлгийн харьцааг гэмт хэрэгт тооцох хуулийн төслийг өргөн барив. Гана улсын парламент ижил хүйстнүүдийн эсрэг хуулийн төслийг баталлаа. Эсватини улсын засгийн газар ЛГБТИ байгууллагыг бүртгэхээс татгалзсан маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг илэрхий зөрчив.

ЛГБТИ хүмүүсийг баривчлах, цагдан хорих явдал түгээмэл байсаар байна. Бурунди улсад 2 дугаар сард Гитега хотод эдийн засгийн оролцоо семинарын үеэр 24 хүнийг баривчилжээ. Хожим нь 2 хүнийг нэмээд тэдэнд “ижил хүйстэн” болон “садар самууныг өдөөн турхирсан” хэргээр эрүүгийн хэрэг үүсгэжээ. Наймдугаар сард тэдний долоо нь гэм буруутайд тооцогдсон бол цагаатгагдсан хүмүүсийн ес нь тэр даруйдаа суллагдаагүй ба нэг нь хоригдож байх хугацаандаа нас баржээ. Нигерийн Дельта мужид ижил хүйстнүүдийн хурим зохион байгуулсан үндэслэлээр 69 хүнд эрүүгийн хэрэг үүсгэсэн бол Гомбе мужид «гей» төрсөн өдрийн үдэшлэг зохион байгуулсан хэргээр 59 эрэгтэй, 17 эмэгтэйг баривчилжээ.

Ботсвана, Камерун, Этиоп, Кени, Малави, Танзани зэрэг улсад ижил хүйстнүүдийн эсрэг үзэн ядах үг хэллэг ихэссэн. Ботсвана, Малави улсад шашны бүлгүүд болон засгийн газрын албан тушаалтнуудын дэмжлэгтэйгээр олон зуун жагсагчид ижил хүйстнүүдийн зөвшилцөлд үндэслэсэн бэлгийн харьцааг гэмт хэрэгт тооцохгүй байгааг эсэргүүцэн жагсчээ. Камеруны эрх баригчид “ижил хүйстнүүдийг сурталчилсан нэвтрүүлэг” цацсан тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн үйл ажиллагааг зогсооно хэмээн сүрдүүлэв. Этиоп улсад олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, шашны удирдагчид болон нэр хүнд бүхий уран бүтээлчид ЛГБТИ хүмүүсийн эсрэг цахим болон цахим бус орчинд кампанит ажлыг эхлүүлсэн. Танзани улсын боловсролын сайд ЛГБТИ контент агуулсан номыг сургуульд ашиглахыг хоригложээ.

Намибийн дээд шүүхээс тус улсын иргэнтэй Намиб улсаас гадуур гэрлэсэн ижил хүйстэн эхнэр, нөхрийн гэрлэлт нь цагаачлалын статусаа тогтмолжуулах үндэслэл байж болохоор шийдвэрлэсэн бол Кенийн дээд шүүх ЛГБТИ хүмүүсийн эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг баталгаажуулсан.

АЛБИНИЗМТЭЙ ХҮМҮҮС

Малави улсад хүн хулгайлахыг завдсан, бие махбодод халдаж, булшийг гутаан доромжилсон зэрэг альбинизмтай хүмүүсийн эсрэг гэмт хэрэг нэмэгдэж байна. Ангол улсад Альбинизмтэй хүмүүсийн хүний эрхийг хамгаалах, дэмжих үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

Засгийн газрууд охид, эмэгтэйчүүдийн эсрэг жендэрийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийн бүх хэлбэртэй нэн даруй тэмцэж, үндсэн шалтгааныг арилгаж, хортой үр дагавар бүхий үйлдлийг хязгаарлах хүчин чармайлтаа нэмэгдүүлэх шаардлагатай. Засгийн газрууд хууль тогтоомжоор дамжуулан ЛГБТИ хүмүүсийн эрхийг хамгаалах, хүчирхийллийн талаарх мэдээллийг үр дүнтэй шалгаж, гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдийн үйлдлийг шүүхээр шалган тогтоох шаардлагатай.

ЭРҮҮЛ ОРЧИН АМЬДРАХ ЭРХ

Хэд хэдэн улс цаг агаарын гамшигт үзэгдэлд нэрвэгдсэн бөгөөд тэдгээрийн эрчим, давтамж нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой байж магадгүй юм. Гэвч бүс нутгийн засгийн газрууд гэнэтийн болон гэнэтийн бус цаг агаарын үзэгдлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний бэлтгэл хангалтгүй байв. Хоёр, гуравдугаар сард “Фредди” хар салхины улмаас Малави улсад 679 хүн, Мозамбикийн 453 хүн амь насаа алдаж, олон сая хүнд хохирсон. БНАКУ, Руанда зэрэг хэд хэдэн улсад үерийн улмаас олон хүн амиа алдсан. Есдүгээр сард Африкийн уур амьсгалын асуудлаарх анхны дээд хэмжээний уулзалтыг Найроби хотод зохион байгуулж, НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын оролцогч талуудын бага хурлын (COP28) хэлэлцээрийн өмнө Африкийн бүс нутгийн баримтлах байр суурийг тодорхойлсон.

Засгийн газрууд уур амьсгалын хямралын эрсдэл, нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлж, цаг агаарын эрс тэс үзэгдэлд бэлэн байдлаа бэхжүүлэх, түүний дотор нөлөөллийг бууруулах, дасан зохицох үр дүнтэй бодлого хэрэгжүүлэхийн тулд хөгжингүй орнуудаас олон улсын тусламж, уур амьсгалын санхүүжилт авах, нийгэм, эдийн засгийн гадуурхагдсан хүмүүст учирсан хохирол алдагдлыг нөхөн сэргээх зэрэг арга хэмжээг авах шаардлагатай.

ҮНЭНИЙГ МЭДЭХ ЭРХ, ШУДАРГА ЁС, ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ

Этиопын засгийн газрын шударга ёс, хариуцлагын санаачилгыг няцаах гэсэн увайгүй кампанит ажлын дараа Африкийн Хүний болон Ард түмний эрхийн Комисс Тигрэй бүс дэх хүний эрхийн нөхцөл байдлыг мөрдөн шалгах комиссын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосон бөгөөд бүс нутгийн нөхцөл байдлын талаар ямар нэгэн тайлан, мэдээлэл гаргасангүй. Засгийн газар мөн Этиопын асуудлаарх НҮБ-ын Хүний эрхийн шинжээчдийн олон улсын комиссыг (ICHREE) онилсны улмаас НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн гишүүн улс орнууд Этиопийн хүний эрхийн шинжээчдийн бүрэн эрхийг дахин сунгах тогтоол гаргаж чадаагүй юм. Түүнчлэн, Бурунди улс НҮБ-ын Хүний эрхийн хорооны хуралдаанд 2015 оны төрийн эргэлт хийх оролдлогод оролцсон хэмээн хилс хэргээр ял сонссон хүний эрхийн хамгаалагчийг байлцуулахыг эсэргүүцэж хяналтын хуралдааныг орхиж гарсан бол Танзани улс Маасайн уугуул иргэдийг хүч хэрэглэн албадан нүүлгэн шилжүүлсэн тухай мэдээллийг шалгахад Нгоронгоро хотод очсон ЮНЕСКО-гийн баримт судлах төлөөлөгчдийг оролцуулахаас татгалзав.

Олон улсын хууль тогтоомжид заасан гэмт хэрэг, хүний эрхийн бусад ноцтой зөрчил, хүчирхийллийн хохирогчдын хамгаалах шударга ёсыг тогтоох, хариуцлага хүлээлгэх механизмыг бий болгохын тулд хэд хэдэн улс үнэнийг мэдэх эрх болон эвлэрлийн журмыг бий болгосон, эсхүл ийнхүү болгох санаачилгыг гаргасан. Бүгд Найрамдах Конго улсын засгийн газар Үндэсний шилжилтийн үеийн шударга ёсны бодлогын төслийг баталсан бол Этиоп улсын засгийн газар энэ төрлийн бодлогыг батлах талаар зөвлөлдөж эхэлсэн.

Өмнөд Суданы Сайд нарын зөвлөлөөс “Үнэнийг мэдэх, эвлэрэх, нөхөн сэргээх комисс” болон “Нөхөн төлбөр, хохирол барагдуулах газрыг байгуулах тухай” хоёр хуулийн төслийг баталлаа. Уг асуудлыг парламентаар хэлэлцэхээр төлөвлөөгүй байсан. Гэвч Өмнөд Суданд холимог хэлбэрийн шүүх байгуулахыг хориглосоор байна. Гамби улсын эрх баригчид Яхья Жамме ерөнхийлөгч байх үед хүний эрхийг ноцтой зөрчсөн гэмт хэрэгтнүүдийг яллах холимог хэлбэрийн шүүх байгуулахаар зөвшилцөлд хүрч байсан.

Олон улсын эрх зүйг зөрчсөн гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй хэд хэдэн этгээдийг баривчилсан. ТАБНУ улсын Эрүүгийн хэргийн тусгай шүүх дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутгагдаж буй дөрвөн хүнийг баривчилсан тухай зарлалаа. Төрлөөр устгах гэмт хэргийн хоёр сэжигтнийг хариуцлагад татах арга хэмжээ авсан. Руанда руу шилжүүлэхийг зөвшөөрсөн шинэ баривчлах тушаалын дагуу Фульгенс Кайишемаг дахин баривчилсан бол Теонесте Ниёнгираг Малавиас Руанда руу албадан гаргажээ.

Засгийн газрууд олон улсын хууль тогтоомжийн дагуу гэмт хэрэг болон хүний эрхийн бусад ноцтой зөрчил, хүчирхийллийн хэргийг шуурхай, нарийн нягт, хараат бус, шударга, үр дүнтэй, ил тод мөрдөн шалгах замаар ял шийтгэл завшихын эсрэг хүчин чармайлтаа нэмэгдүүлж, гэмт хэрэг үйлдсэн сэжигтнүүдийг шүүхэд шилжүүлж, хохирогчдын зөрчигдсөн эрхээ үр дүнтэй сэргээх хүртээмжийг баталгаажуулах шаардлагатай.

АМЕРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Америкийн бүс нутаг даяар иргэний орон зай хумигдаж байгаа нь сүүлийн хэдэн арван жилд хүний эрхийн чиглэлээр гарсан ахиц дэвшилээс чангааж байна. Хүний эрх хамгаалагчид, ялангуяа уур амьсгалын шударга ёсны төлөө тэмцэгчид, газар нутаг, байгаль орчноо хамгаалахын төлөө тэмцэгчид, сэтгүүлчид хүчирхийлэл, гэмт хэрэг, халдлага, аллагад өртсөөр байгаа ба тус бүс нутаг нь дээр дурдсан идэвхтнүүдэд хамгийн аюултай газрын нэг хэвээр үлдэв. Бүс нутгийн ихэнх улсад хүний эрх хамгаалагчдыг хамгаалах хүчирхэг тогтолцоо дутмаг байв. Аюулгүй байдлын албаныхан тайван жагсагчдын эсрэг хууль бүс хүч хэрэглэв. Эрх баригчид хүний амьд явах эрх, эрх чөлөө, шударгаар шүүлгэх эрх, бие махбодын халдашгүй байх эрхийг зөрчиж, дур зоргоор саатуулах явдал өргөн тархсан. Бүс нутгийн хэмжээнд жендэрт суурилсан хүчирхийлэл газар авсан бөгөөд уг гэмт хэрэгт ял завших болон ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй охид, эмэгтэйчүүд, бусад бүлгүүдийг эрх баригчид хамгаалж чадсангүй. Аюулгүй үр хөндөлтийн хүртээмжийг өргөжүүлэх чиглэлээр сүүлийн жилүүдэд гарсан ахиц дэвшил бүс нутгийн хэмжээнд, цаашлаад үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцдоггүй улс орнуудад ч мэдэгдэхүйц ухарлаа. ЛГБТИ хүмүүс өргөн хүрээний хавчлагад өртсөөр байсан бөгөөд тэдний эрхийг хуулийн дагуу хүлээн зөвшөөрөхөд саад бэрхшээлтэй тулгарлаа. Уугуул хүмүүс хүний эрхийн хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтад илүү ихээр өртсөөр байна. Хэд хэдэн улсад ялангуяа, томоохон төслүүдтэй холбоотойгоор уугуул хүмүүсийн чөлөөт, урьдчилан, мэдээлэлтэй зөвшөөрөл авах эрхийг үгүйсгэлээ. Америк тивийг хамарсан эдийн засаг, хүмүүнлэг, улс төрийн хямрал нь аюулгүй байдлын төлөө эх орноо орхин явах хүмүүсийн тоог эрс нэмэгдүүлэхэд хүргэв. Хэд хэдэн улсын эрх баригчид дүрвэгсэд болон цагаачдын эрхийг хүндэтгэж, хамгаалж чадсангүй. Улс орнууд өсөн нэмэгдэж буй дүрвэгсэд, цагаачдын тоог хянахын тулд цэргийн хүчийг улам бүр ашиглаж байна. Олон улсын эрх зүйд заасан гэмт хэрэг, хүний эрхийн зөрчилд ял шийтгэл ногдуулахгүй байдал түгээмэл хэвээр байгаа бөгөөд улс орнууд олон улсын хяналтаас зайлсхийсээр байна. Бразил, Канад, АНУ дэлхийн хүлэмжийн хийн ялгаруулалтад хамгийн их хувь нэмэр оруулсан орнуудын тоонд багтсан. Бүс нутагт чулуужсан түлшний олборлолт, чулуужсан түлшний үйлдвэрлэлийг өргөжүүлэх нь дэлхийн уур амьсгалын эсрэг зорилтуудад заналхийлж байна. Засгийн газрууд түүхий нүүрсний хэрэглээ, үйлдвэрлэлийг ойрын хугацаанд багасгах үүрэг амлалтаа биелүүлсэнгүй.

Засгийн газрууд нүүрс, нефт зэрэг чулуужсан түлшний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжиж байгаа үйлдлээ нэн даруй шууд зогсоохоор амалсан боловч түүнийгээ шударгаар биелүүлэхгүй байна.

Гэхдээ зарим ахиц гарсан. Америкийн бүс нутаг даяар хүний эрхийг хамгаалагчид болон хүний эрхийг хамгаалахын төлөө дуугарч буй хүмүүст илүү шударга, илүү тэгш нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн бүтцийн өөрчлөлтийг бий болгохын тулд улам бүр нэмэгдсээр байгаа саад бэрхшээлийн эсрэг тэмцсээр байна.

ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ, ТАЙВАН ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ

Америкийн бүс нутаг даяар иргэний орон зай түгшүүрийн хэмжээнд хүртэл хумигдсаар байв. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд заналхийлсээр ирсэн Сальвадор, Никарагуа, Венесуэл зэрэг улсын засгийн газрууд шүүмжлэгчдийг дуугүй болгохын тулд иргэний нийгмийн бүлгүүдийн эсрэг хууль эрх зүйн болон институцийн нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. 2022 оны 8 дугаар сараас 2023 оны есдүгээр сарын хооронд Никарагуа улсад 2000 гаруй төрийн бус байгууллагын эрх зүйн байдлыг цуцалснаар энэ тоо 2018 оноос хойш нийт 3394-д хүрчээ. Наймдугаар сард Никарагуа дахь Төв Америкийн их сургуулийг “терроризмын төв” гэж буруутган хаасны зэрэгцээ Улаан загалмайн нийгэмлэг гэх зэрэг байгууллагуудын өмч хөрөнгийг хураажээ. Куба улсад тавдугаар сард батлагдсан шинэ хуулиар нийтийн хэв журам, ёс суртахуунд харш гэж үзсэн мэдээлэл нийтэлсэн хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэхгүй байхыг харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад даалгах эрхийг засгийн газарт олгосон.

Эль Сальвадор улсад 2022 оны 3 дугаар сараас эхлэн тогтоосон онц байдлын үеэр тус улсын нөхцөл байдал улам хүндэрсээр байсан тул 2023 онд эсэргүүцлийн жагсаал, цуглаан нэмэгдэв. Эрх баригчид иргэдийн дургүйцлээ илэрхийлэх боломжийг улам бүр хязгаарлан гутаан доромжлох, заналхийлэх, өргөн хүрээний тандалт хийх зэргээр эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал, цуглаан хийх эрхийг зөрчив.

Аргентин, Боливи, Куба, Сальвадор, Гаити, Парагвай, Перу, Пуэрто-Рико, Венесуэл зэрэг улсад эрх баригчид олон нийтийн эсэргүүцлийн жагсаал, цуглааныг нухчин дарах хариу арга хэмжээ авсан. Болив улсын Омбудсмений газар 1 дгээр сард Санта Крузын амбан захирагчийг баривчилсны дараа болсон жагсаалын эсрэг цагдаа нар хүч хэтрүүлэн хэрэглэсэн хэд хэдэн тохиолдлыг мэдээлсэн.

Аргентин, Канад, Куба, Мексик, Пуэрто-Рико, АНУ-ын засгийн газрууд тайван жагсагчдын эсрэг эрүүгийн хэрэг үүсгэсэн. Чили улс хүч хэрэглэхэд хүлээлгэх хуулийн хариуцлагыг сулруулсан хуулийг баталсан. АНУ-ын 16 мужид жагсаал цуглаан хийх эрхийг хязгаарласан хуулийн төсөл өргөн барьсан. Хойд Каролина муж нь дамжуулах хоолойн ойролцоо явагдсан жагсаал, цуглаан болон үймээн самууны зөрчилд хүлээлгэх шийтгэлийг нэмэгдүүлсэн.

Америкийн бүс нутаг сэтгүүлчдэд аюултай газар хэвээр байна. Аргентин, Колумб, Куба, Доминикан, Эль Сальвадор, Мексик, Парагвай, Венесуэлд хэвлэл мэдээллийн ажилтнууд заналхийлэл, дарамт, аллага, хууль бус тандалтад өртсөөр байна. Бүгд Найрамдах Доминикан улсад авлига, ял шийтгэл завшдаг талаар мэдээлдэг нэр хүнд бүхий сэтгүүлч Нуриа Пиера нь 2020, 2021 онд НСО(NSO) группийн Пегасус (Pegasus) тагнах программын халдлагад өртсөн болохыг нотлох баримт харуулж байна. Уг тагнах программ нь төхөөрөмжид хязгаарлалтгүй нэвтрэх боломжийг олгодог бөгөөд тус улсын эрх баригчид дээрх тандалтад оролцоо байхгүй гэдгээ мэдэгдэв. Арктик 19 байгууллагын мэдээлснээр Мексикт хамгийн багадаа таван сэтгүүлч ажил үүргээ гүйцэтгэж яваад амиа алджээ.

Улс орнууд үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөнд саад учруулж буй хууль болон практикийг хүчингүй болгох ёстой. Тэд иргэдийн санал бодлоо илэрхийлэх эрхийг үр дүнтэй хамгаалах, сэтгүүлчдийн хөдөлмөрийг хамгаалах нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай.

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИД

Америкийн бүс нутаг хүний эрх хамгаалагчдын хувьд дэлхийн хамгийн аюултай бүс нутгийн нэг хэвээр байна. Болив, Бразил, Канад, Колумби, Эквадор, Эль Сальвадор, Гондурас, Мексик зэрэг улсад газар нутаг, байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажилладаг хамгаалагчдын эсрэг эрсдэл улам бүр нэмэгдсээр байна. Хар арьстан, уугуул болон эмэгтэй хүний эрх хамгаалагчид онцгой эрсдэлтэй хэвээр байна. Бразил, Канад, Колумби, Куба, Эквадор, Эль Сальвадор, Гватемала, Гаити, Гондурас, Мексик, Никарагуа, Перу, Венесуэл зэрэг улс орнуудад хүний эрхийн төлөө тэмцэгчдийг үндсэн, хууль ёсны ажлаа хийхийг нь зогсоохын тулд засгийн газар болон төрийн бус оролцогчид дарамтлах, гутаан доромжлох, эрүүгийн ял шийтгэх, алах зэрэг олон төрлийн арга хэрэгслийг ашигласан. Бразилд сүүлийн дөрвөн жилийн хугацаанд сар бүр дунджаар гурван хамгаалагч амиа алдсан хэмээн Жастика Глобал байгууллага мэдээлэв. Глобал Витнессийн мэдээллээр Гондурас улс нэг хүнд ногдох хүний эрхийн хамгаалагчдын үхлийн тоогоор дэлхийд тэргүүлж байна. Долдугаар сард Гондурасын Гуапинол нийгэмлэгийн нэгэн гишүүнийг өдрийн цагаар буудаж хороосон бөгөөд түүний гэр бүлийн хоёр гишүүнийг түүнийг алахаас зургаан сарын өмнө хөнөөжээ. Тэд амьжиргааны гол эх үүсвэр болсон голыг нь сүйтгэж байгаа уул уурхайн компанийг эсэргүүцэн кампанит ажил явуулдаг байжээ. 2023 оны эцсийн байдлаар дээрх хүн амины хэрэгт ял шийтгэл оногдуулсангүй.

Хэдийгээр Америкийн бүс нутгийн ихэнх улс орнууд хүний эрх хамгаалагчдыг хамгаалах хүчтэй тогтолцоогүй байсан хэдий ч Колумби улсад зарим эерэг алхам хийгдлээ. Колумбын Дотоод хэргийн яам газар нутаг, нутаг дэвсгэрээ хамгаалж буй хүмүүст чиглэсэн анхан шатны байгууллага, олон нийтийн хүний эрхийг хамгаалагчдын хамтын хамгаалалтын хөтөлбөрийг бэхжүүлж байгаагаа зарлав.

Улс орнууд хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үр дүнтэй хөтөлбөр боловсруулах, эсхүл одоо байгаа хөтөлбөрүүдийг сайжруулах, түүнчлэн идэвхтнүүдэд халдсан хэрэгт сэжиглэгдэж буй хүмүүсийг шүүхэд шилжүүлэх зэргээр хүний эрх хамгаалагчид үйл ажиллагаагаа аюулгүй явуулах боломжийг хангах ёстой.

ДУР ЗОРГООР ЦАГДАН ХОРИХ, ШУДАРГА БУСААР ШҮҮХ

Бүс нутагт дур зоргоороо баривчлах явдал өргөн тархсан хэвээр байна. Эрх баригчид Куба, Сальвадор, Никарагуа, Венесуэл зэрэг улс хүмүүсийн эрх чөлөө, шударга шүүхээр шүүлгэх болон бие махбод халдашгүй байх эрхийг зөрчсөөр байна. АНУ-д ялгаварлан гадуурхалтад үндэслэгдсэн цагдан хорих ажиллагаа олноор явагдаж байна.

Эл Сальвадор улсад 2022 оны гуравдугаар сард онц байдал тогтоосноос хойш 73,000 гаруй хүний дур зоргоор цагдан хорьсон тохиолдол бүртгэгджээ. Цагдан хоригдсон хүмүүсийн ихэнх нь “хууль бусаар эвлэлдэн нэгдсэн” буюу бүлэглэлийн үйл ажиллагаа, гишүүнчлэлтэй холбоотой гэмт хэрэгт буруутгагдаж байна. Эдгээр цагдан хорих ажиллагаа нь хуулиар тогтоосон шударга процессыг зөрчиж, шүүхийн шийдвэргүйгээр явагдсан бөгөөд цагдан хорих ажиллагааг хэрэгжүүлж байгаа шүүгчийн хувийн мэдээллийг нууцалжээ.

Сальвадор, Мексик, Никарагуа, Венесуэл зэрэг улсад цагдан хоригдсон хүмүүсийг ихэвчлэн эрүүдэн шүүж, зүй бусаар харьцаж, зарим тохиолдолд хүчээр алга болгожээ. Венесуэлд 2014-2023 оны хооронд 15,700 хүнийг дур зоргоор баривчилж, 280 орчим хүнийг улс төрийн шалтгаанаар цагдан хорьсон хэвээр байна хэмээн иргэний нийгмийн байгууллагууд мэдээлэв. Оюутан идэвхтэн, хөгжимчин Жон

Альваресыг наймдугаар сарын 30-нд цагдан хорьсон бөгөөд түүнийг 24 цагаас дээш ганцаарчлан хорьжээ. Түүнийг цагдан хорьж байх хугацаанд цагдаагийн албаныхны хийсэн бичлэгт дүрс нь авагдсан үйлдвэрчний эвлэлийн дарга, сэтгүүлчийг буруутгасан мэдүүлэг өгөхийг албадан эрүүдэн шүүжээ.

Боливи, Куба, Эль-Сальвадор, Никарагуа, АНУ, Венесуэл зэрэг хэд хэдэн улс шударгаар шүүлгэх эрхийг хүндэтгэх үүргээ биелүүлсэнгүй. Кубын Гуантанамо дахь АНУ-ын тэнгисийн цэргийн баазын хорих ангид лалын шашинт 30 эрэгтэйг дур зоргоор, тодорхойгүй хугацаагаар хорьсон нь олон улсын хууль тогтоомжийг зөрчиж байна. АНУ-ын Дээд шүүх 2008 онд хууль бусаар хоригдож байгаа эсэхийг тогтоолгохоор шүүхэд хандах эрхтэй гэсэн шийдвэрийг гаргасан ч эдгээр хүмүүсийн асуудлыг хэлэлцэхээс татгалзсан хэвээр байна.

Эрх баригчид шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаажуулж, шүүхийн тогтолцоог буруугаар ашиглахгүй байх ёстой. Улс орнууд дур зоргоор баривчлсан хүмүүсийн хохирлыг барагдуулах эрхийг хэрэгжүүлэх шаардлагатай.

ХҮЧ, АЛБАДЛАГЫГ ХЭТРҮҮЛЭХ, ШААРДЛАГАГҮЙ ҮЕД ХЭРЭГЛЭХ

Хууль сахиулах байгууллагууд хүч, албадлагыг хэтрүүлэн, эсхүл шаардлагагүй үед хэрэглэх, ялангуяа үхэлд хүргэх хүч хэрэглэх явдал Аргентин, Бразил, Канад, Куба, Доминикан, Гондурас, Мексик, Перу, Пуэрто-Рико, АНУ зэрэг улсад өргөн тархжээ. Эдгээр хүч албадлагыг ихэнх тохиолдолд арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзэлд үндэслэн хэрэгжүүлжээ. Бразил улсад цагдаа нарын хүчирхийллийг бууруулах арга хэмжээ, тэр дундаа биеийн камер ашиглах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байгаа хэдий ч тус улсын Бахиа, Рио-де-Жанейро, Сан Пауло мужуудад 7-9 дугаар сарын хооронд цагдаа нарын гарт хамгийн багадаа 394 хүн амь насаа алджээ. Харин АНУ-д 2023 онд 1153 хүн цагдаа нарын гарт амиа алдсан хэмээн хэвлэл мэдээллийн эх сурвалж мэдээлэв. Перу улсад орон даяар өрнөсөн эсэргүүцлийн жагсаалын үеэр хариу арга хэмжээ авч, үхлийн аюултай хүч хэрэглэж, үхлийн аюул багатай хүчийг хэтрүүлэн хэрэглэж, ялангуяа уугуул иргэдийг онилсон арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг баримталжээ. Хоёр сар хүрэхгүй хугацаанд жагсаалын үеэр 49 энгийн иргэн, нэг цагдаа амиа алдаж, олон зуун хүн шархадсан байна. Эдгээрийн 20 хэргийг шүүхээс гадуур цаазалсан хэмээн үзэж байна.

Чили, Колумб улсад цагдаагийн байгууллагын шинэчлэл холимог хэлбэрийн үр дүнд хүрсэн. Колумбын эрх баригчид цагдаагийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааг өөрчлөх санаачилгын хүрээнд эсэргүүцлийн жагсаалын үеэр хүч хэрэглэх тухай шинэ гарын авлагыг боловсруулжээ. Цагдаагийн цогц шинэчлэл хийх ажил хүлээгдсээр байна.

Онц байдал тогтоосон Эль Сальвадор, Гондурас зэрэг хэд хэдэн улсад аюулгүй байдлын цэрэгжилт үргэлжилсээр байна. Эквадор, Мексик улсууд олон нийтийн аюулгүй байдлыг хангахад зэвсэгт хүчнийг ашиглахыг зөвшөөрөхийн тулд хууль эрх зүйн зохицуулалтыг өргөжүүлж байна.

Эрх баригчид хууль сахиулах ажиллагааг олон улсын хүний эрхийн хууль, стандарт, тэр дундаа хүч хэрэглэх талаарх хэм хэмжээ зэрэгт нийцүүлэх ёстой. Тэд хүний эрхийг зөрчсөн гэж сэжиглэгдэж байгаа хүмүүсийг шүүхэд шилжүүлэх шаардлагатай.

ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

Бүс нутгийн хэмжээнд жендэрт суурилсан хүчирхийлэл, тэр дундаа жендэрт үндэслэн эмэгтэйчүүдийн амь насыг хохироох явдал түгээмэл хэвээр байгаа бөгөөд эдгээр гэмт хэрэгт ял шийтгэл хүлээдэггүй асуудлыг эрх баригчид тодорхой системтэйгээр шийдвэрлэж чадсангүй. Мексик улсын Үндэсний олон нийтийн аюулгүй байдлын системийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газрын мэдээлснээр тус улсад өдөрт дунджаар есөн эмэгтэй бусдын гарт амь насаа алддаг бөгөөд ихэнх хэргийг үр дүнтэй шийдвэрлэж чаддаггүй. Канад улсад сураггүй алга болсон, эсхүл бусдын гарт амь насаа алдсан уугуул охид, эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэн бөгөөд хоолой барих барилгын талбайн ойролцоо уугуул охид, эмэгтэйчүүд, лесбиян, гей, бисексуал, транс хүмүүсийн болон 2SLGBTQIA+ бүлгийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн түвшин өндөр байгааг НҮБ мэдээлэв.

2020 онд үр хөндөлтийг хуулиар хүлээн зөвшөөрсөн Аргентин улс, 2022 онд үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцох явдлыг хүчингүй болгосон Колумби улсыг эс тооцвол бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хүртээмж бүс нутгийн хэмжээнд туйлын хүнд хэвээр байв. Сальвадорд үр хөндөлтийг бүхэлд нь хориглосон хэвээр байгаа бөгөөд хамгийн багадаа 21 эмэгтэйг эхчүүдэд яаралтай тусламж үзүүлсэн хэрэгт буруутгажээ. Чили улсад үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцох явдлыг бүхэлд хүчингүй болгох, үр хөндөлтийн аюулгүй үйлчилгээг тэгш, саадгүй хүртэх эрх зүйн орчныг бүрдүүлэх үйл явцад ахиц гарсангүй. Бразилд үр хөндөлт нь эрүүгийн гэмт хэрэг хэвээр байна. Тус улсын Эрүүл мэндийн яамны мэдээлснээр долдугаар сар хүртэл нийт 19 эмэгтэй үр хөндөлтийн улмаас нас баржээ. Есдүгээр сард жирэмсний эхний 12 долоо хоногт үр хөндөлтийг гэмт хэрэг гэж үзэхгүй байх нэхэмжлэлийг Холбооны Дээд шүүх хүлээн авсан хэдий ч уг гомдолд санал авах ажиллагааг түр түдгэлзүүлсэн.

Зарим улсад үр хөндөлтийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжтэй байдлыг хязгаарлах явдал улам түгээмэл болсон. 2022 онд АНУ-ын Дээд шүүхээс үр хөндөлтийн эрхийг хамгаалах холбооны хамгаалалтыг зогсоосон шийдвэр гаргасны дараа 15 мужид үр хөндөлтийг бүхэлд нь хориглох, эсхүл хориглолт үйлчлэхгүй байх нөхцөлийг маш хязгаарлагдмал байдлаар хуульчилсан. Дээрх арга хэмжээний үр дагавар хар арьстнууд болон бусад арьс үндсээр ялгаварлан гадуурхсан хүмүүст илүү сөргөөр нөлөөлж байна.

Гэхдээ зарим ахиц дэвшил гарлаа. Гондурас улсад үр хөндөлтийг хориглосон хэвээр байгаа хэдий ч засгийн газар яаралтай жирэмслэлтээс хамгаалах бэлдмэл хэрэглэх, борлуулахыг хориглосон 14 жилийн хоригийг хүчингүй болгосон. Мексик улсын Дээд шүүх үр хөндөлтийг гэмт хэрэг гэж үзэх, түүнчлэн үр хөндөлт хийсэн, эсхүл тусалсан эмнэлгийн ажилтнуудын эрхийг түдгэлзүүлэх нь Үндсэн хуулийг зөрчсөн хэмээн шийдвэрлэв.

Эрх баригчид охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэрэгт ял шийтгэл хүлээлгэдэггүй байдлыг эцэс болгох шаардлагатай. Засгийн газрууд аюулгүй үр хөндөлт, бэлгийн болон нөхөн үржихүйн бусад эрх, тэр дундаа бэлгийн цогц боловсролыг хүртэх эрхийг баталгаажуулах ёстой.

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

Аргентин, Бразил, Канад, Колумб, Гватемал, Гондурас, Парагвай, Перу, Пуэрто-Рико, АНУ зэрэг улсад ЛГБТИ хүмүүс өргөн хүрээтэй дарамт, ялгаварлан гадуурхалт, заналхийлэл, хүчирхийллийн халдлага, аллагын хохирогч болсоор байна. Ихэнх тохиолдолд гэм буруутай этгээдэд ял шийтгэл хүлээлгэхгүй байх нь түгээмэл байна.

Ижил хүйстний гэрлэлтийг хууль бус хэмээн үздэг Гватемал улсад хамгийн багадаа 34 хүн бэлгийн чиг баримжаа болон хүйсийн байдлаас болж амиа алдсан хэмээн Үндэсний LGBTIQ+ Хүний Эрхийн Ажиглагч байгууллага мэдээлэв. Бразил

улс 14 дэх жилдээ трансжендер хүний аллагын тоогоор тэргүүлэх улсаар нэрлэгдэв. Перу улсад ЛГБТИ хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, аллага хэд хэдэн удаа гарсан ч үзэн ядалтын гэмт хэргийн албан ёсны бүртгэл байхгүй хэвээр байна. Парагвай улсын шүүх жендерийн байдлыг үндэслэн трансжендер хүмүүсийн нэрийг хууль ёсны дагуу хүлээн зөвшөөрөх талаарх 5 хэргийг хэрэгсэхгүй болгов. АНУ-д ЛГБТИ хүмүүсийн эсрэг хууль тогтоомжийг муж улсын түвшинд батлах нь эрс нэмэгдсэн. АНУ-д насанд хүрсэн ЛГБТИ хүмүүсийн ердөө 54 хувь нь бэлгийн чиг баримжаа, хүйсийн ялгаатай байдал болон түүнийгээ илэрхийлэх эрхийг хамгаалсан, энэ эрхэд халдсан үйлдлийг үзэн ядалтын гэмт хэрэгт тооцдог хуультай мужид амьдарч байна.

Дөрөвдүгээр сард Аргентин улсад дээрмийн хэргээр саатуулагдсан 40 настай София Инес Фернандес гэх транс эмэгтэй Буэнос-Айресын Дерки хотын цагдаагийн газрын камерт нас барсан байдалтай олдсон. Уг хэрэгт сэжиглэгдсэн цагдаа нар түүнийг амиа хорлож нас барсан гэж мэдэгдсэн ч урьдчилсан задлан шинжилгээгээр амьсгалын тасалдлын улмаас нас барсан нь тогтоогджээ.

Хүний эрхийн нөхцөл байдал бүрхэг байгаа ч тодорхой ахиц гарсан. Дөрөвдүгээр сард Колумбийн нэгэн иргэн анх удаа нонбайнери жендерийн байдалдаа нийцүүлэн их сургуулийн диплом авчээ.

Эрх баригчид ЛГБТИ хүмүүсийн хамгаалалтыг бэхжүүлэх, тэр дундаа хүчирхийллийн талаарх мэдээллийг үр дүнтэй шалгаж, гэмт хэрэг үйлдэгчдийг шүүхэд шилжүүлэх шаардлагатай.

УУГУУЛ ХҮМҮҮСИЙН ЭРХ

Удаан хугацааны турш арьс үндсээр ялгаварласан гадуурхалт, алагчлалд өртсөөр ирсэн уугуул хүмүүс хүний эрхийн зөрчилд зүй бус хохирогч болсон хэвээр байна. НҮБ-ын Хүмүүнлэгийн асуудал эрхэлсэн байгууллагын мэдээлснээр Колумби улсад 2023 онд нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хохирогчдын 45% нь Афро үндэстний үр удам, 32% нь уугуул хүмүүс байжээ. Бразил улсын Уугуул хүмүүсийн асуудал эрхэлсэн сайдаар уугуул эмэгтэй Сониа Гуажажара анх удаа томилогдов. Бразил улсын Эрүүл Мэндийн Яамнаас хоол тэжээлийн дутагдал, бохирдол, бэлгийн хүчирхийлэлд өртсөн Яномами хүмүүст үзүүлэх тусламж байхгүйн улмаас үндэсний Эрүүл мэндийн онц байдал зарласнаа мэдэгдэв. Дээрх хүний эрхийн зөрчил нь Амазоны бүс нутагт тэдний нутаг дэвсгэрт хууль бус уул уурхайн үйл ажиллагаа явуулснаас үүдэлтэй юм.

Аргентин, Канад, Эквадор, Венесуэл зэрэг хэд хэдэн улсад эдийн засгийн томоохон төслүүдтэй холбоотой чөлөөт, урьдчилан болон мэдээлэлтэйгээр зөвшөөрөл авах эрхийг үгүйсгэсээр байна. Канад улсын Засгийн газраас 6 дугаар сард батлан гаргасан НҮБ-ын уугуул иргэдийн эрхийн тунхаглалыг хэрэгжүүлэх Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд хариуцлагын механизм, чөлөөт, урьдчилсан болон мэдээлэлтэйгээр зөвшөөрөл авах асуудлыг тусгаагүй байна. Ветсүвт дэх хэд хэдэн хүний эрх хамгаалагчдыг тав болон аравдугаар сард нутаг дэвсгэрээ дамжуулах хоолой барихаас хамгаалсан хэргээр шүүхэд шилжүүлжээ. Нэг нь арван нэгдүгээр сард гэм буруугүй болох нь шүүхээр тогтоогдсон бол бусад нь шүүхийн шийдвэрийг хүлээж байна. Хэрэв тэд гэм буруутай нь тогтоогдвол хорих ялаар шийтгэгдэх магадлалтай.

Хэд хэдэн улсад газрын эрхийн маргаан үргэлжилсээр байв. Парагвайд Ава Гуарани Паранаэнсегийн уугуул иргэд болох Текоха Саусын нийгэмлэг Итайпу Бинасионал усан цахилгаан станцаас өвөг дээдсийнхээ газар нутгийг эргүүлэн авахыг хүлээсээр байв. Өвөг дээдсийнх нь нутаг дэвсгэрийн өөр нэгэн бүс нутгаас иргэдийг нүүлгэн шилжүүлэх шийдвэрийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийг тус компани давж заалдсан.

Бүс нутгийн улсууд уугуул хүмүүс өөрсдийн газар нутаг, баялгаа өмчлөх, хараа хяналтдаа байлгах эрхийг баталгаажуулах ёстой. Тэд уугуул хүмүүсийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох бодлогыг хэрэгжүүлж, шударга ёс, үнэнийг мэдэх эрх, хүний эрхийн зөрчлийн хохирлыг барагдуулах баталгааг хангах шаардлагатай.

ДҮРВЭГСЭД, ЦАГААЧДЫН ЭРХ

Америкийн бүс нутгийг хамарсан улс төр, хүмүүнлэг, эдийн засгийн ноцтой хямрал нь аюулгүй байдлын төлөө эх орноо орхин, хүний эрхийн зөрчилд өртөгсдийн тоог системтэйгээр нэмэгдүүлэхэд нөлөөлсөн. НҮБ-ын дүрвэгсдийн асуудал эрхэлсэн байгууллага болох НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газрын мэдээлснээр оны эцэс гэхэд 7.72 сая гаруй Венесуэль иргэд эх орноо орхин гарчээ. Панамын эрх баригчдын мэдээлснээр Дариен цоорхойгоор 520,000 хүн Колумб, Панамын хил дамжин гарсан нь 2022 оныхоос хоёр дахин их байна. Мөн АНУ, эсхүл Канад руу хүрэхийн тулд Мексик улсыг зорин ирэх цагаачид, орогнол хүсэгчид болон дүрвэгсдийн тоо эрс нэмэгджээ.

Чили, Колумб, Эквадор, Мексик, Перу, АНУ зэрэг хэд хэдэн улсын эрх баригчид цагаачид болон дүрвэгсдийн эрх, түүний дотор орогнол хүсэх эрхийг хүндэтгэж, хамгаалж чадсангүй. АНУ-д 42 дугаар цагаачлалын бодлогыг хүчингүй болгосны дараа АНУ-Мексикийн хил дээр орогнол хүсэх эрхийг эрс хязгаарласан цагаачлалын шинэ арга хэмжээг хэрэгжүүлсэн. Уг арга хэмжээнд ихэнх тохиолдолд шаардлага хангаагүй гэж үзэх, уулзалт товлох маш хязгаарлагдмал гар утасны программыг заавал ашиглах зэрэг багтана. Үүний улмаас олон тооны орогнол хүсэгчид хүнлэг бус нөхцөлд хил дээр гацаж, дарамт, хүчирхийлэлд өртсөн.

АНУ-ын засаг захиргаа Гаити, Гондурган, Балба, Никарагуан, Сомали, Өмнөд Судан, Судан, Украин, Венесуэл, Йемен зэрэг улсын иргэдийн түр хамгаалалтын статусыг сунгаж, хөдөлмөр эрхлэх эрх болон АНУ-аас гаргахгүй байх баталгаа тогтоожээ. Куб, Гаити, Никарагуа, Венесуэлчүүдийг түр хугацаанд амьдрах эрх олгох үйл явцыг эхлүүлсэн бөгөөд энэ нь эдгээр улсаас сар бүр 30,000 хүртэлх иргэнд АНУ дахь ивээн тэтгэгчийн дэмжлэгтэйгээр АНУ-д нэвтрэх эрхийг олгосон.

АНУ-ын эрх баригчид аюулгүй байдлыг эрэлхийлсэн хүмүүсийг саатуулахын тулд хувийн шоронг ашиглаж, дур зоргоор цагаачдыг олноор нь саатуулсаар байна. Канад улсын Онтарио, Квебек, Саскачеван, Нью-Брансвик мужууд Канадын Хилийн албаны агентлагтай хамтран цагаачлалын саатуулах зохицуулалтаа зогсоож байгаагаа зарласан бөгөөд 2024 оны 7 дугаар сар гэхэд зөвхөн цагаачлалын үндэслэлээр хүмүүсийг саатуулахгүй байх талаарх Бритиш Колумб, Альберта, Манитоба, Нова Скотиа мужуудын амлалтад нэгджээ. Цагаачид болон орогнол хүсэгчдийг саатуулах нөхцөл маш хүнд гэгдэх Мексик улсын Дээд шүүхээс өнгөрөгч гуравдугаар сард цагаачдыг саатуулах төвд байлгах дээд хугацааг 36 цаг байхаар шийдвэрлэсэн бөгөөд эрх баригчид дээрх хугацаа дууссанаар цагаачид болон орогнол хүсэгчдийг суллах үүрэг хүлээсэн.

Өөрийн улсад ирэх өсөн нэмэгдэж буй цагаачид болон дүрвэгсдийн тоог зохицуулахын тулд цэргийн албаныхныг тараан байршуулах нь бүс нутаг даяар улам өргөжсөн. Хоёрдугаар сард Чили улсын засгийн газар аюулгүй байдлыг эрэлхийлсэн хүмүүсийг нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд Боливи, Перу улстай хиллэдэг хилийн дагуу цэргийн хүчнийхнийг тараан байршуулсан. Уг ажиллагаа нь гол төлөв Венесуэлчүүдэд нөлөөлжээ.

Чили, Колумби, Эквадор, Перу улс дахь Венесуэлчүүд орогнол хүсэх болон бусад түр болон нэмэлт хамгаалалтын хөтөлбөрт хамрагдахад ихээхэн саад бэрхшээлтэй тулгарчээ. Үүний улмаас олон хүн эрх зүйн байдлаа тогтоолгож чадахгүйд хүрч, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг чухал үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байна.

Эрх баригчид эрсдэлт нөхцөл байгаа жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөж буй Венесуэлийн эмэгтэйчүүдийг хамгаалж чадахгүй хэвээр байна. Тэдний олонх нь айдас, үл итгэх болон ташаа мэдээллийн улмаас хүчирхийллийн хэргийн талаар холбогдох байгууллагад мэдээлдэггүй бөгөөд хууль ёсны оршин суух эрхгүйн улмаас төрийн үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй.

Бүгд Найрамдах Доминикан улсад Гаитичүүд боло Гаити гаралтай хүмүүсийг ялгаварлан гадуурхах, хар арьстнуудыг арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзэл газар авч байгаа нь цагаачид, орогнол хүсэгчид, дүрвэгсэд, охид, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийг тодорхой эрсдэлд оруулж байна. Цагаачлалын албаныхан болон хууль сахиулах байгууллагын ажилтнууд Гаитигийн охид, эмэгтэйчүүдийг дур зоргоор баривчилж, албадан гаргахын тулд эмнэлгүүдэд ялгаварлан гадуурхалтад суурилсан эрэн хайх ажиллагаа явуулжээ.

Эрх баригчид хууль бусаар албадан гаргах ажиллагааг нэн даруй зогсоож, суугаа улсдаа шударга бусаар ял шийтгэгдэх, дүрвэгсэд, цагаачдыг нутаг буцаахгүй байх зарчмыг хүндэтгэж, дүрвэгсэд болон цагаачдыг цагдан хорихоос зайлсхийх шаардлагатай. Улс орнууд хүн бүрийн, ялангуяа нийтийг хамарсан хүний эрхийн зөрчлөөс зугтаж буй хүмүүсийн орогнол хүсэх, шударга, үр дүнтэй орогнол олгох журамд хамрагдах баталгааг хангаж, дүрвэгсдэд өөрсдийнхөө зохих хамгаалалтыг олгох шаардлагатай. Тэд цагаачид, дүрвэгсэд, орогнол хүсэгчдийн эсрэг арьс үндсээр ялгаварлан гадуурхах, гадаадынхныг үзэн ядах үзэлтэй тэмцэх шаардлагатай.

ҮНЭНИЙГ МЭДЭХ ЭРХ, ШУДАРГА ЁС, ХОХИРОЛ БАРАГДУУЛАХ

Болив, Бразил, Чили, Эквадор, Сальвадор, Гватемал, Гаити, Мексик, Никарагуа, Перу, Уругвай, Венесуэл зэрэг улсад хүний эрхийг зөрчил, тэр дундаа олон улсын эрх зүйн гэмт хэрэгт ял шийтгэл хүлээхгүй байх нь түгээмэл хэвээр байна.

10 дугаар сард Боливын асуудал эрхэлсэн салбар дундын бие даасан шинжээчдийн бүлгээс 2019 онд Боливт өрнөсөн улс төрийн хямралын хүрээнд үйлдэгдсэн хүний эрхийн зөрчлийг мөрдөн шалгах ажиллагаанд бага зэрэг ахиц гарсан хэмээн мэдээлсэн. Дээрх хямралын үеэр аюулгүй албаныхны гарт 37 хүн алагдаж, олон зуун хүн гэмтэж бэртсэн. Бразилын цагдаа нарын үйлдсэн хүн алах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа үр дүнгүй хэвээр байв. 2018 онд Бахиа мужийн Тукано хотод идэвхтэн Педро Хенрике Крузыг хөнөөсөн хэрэгт буруутгагдаж байсан гурван цагдаад холбогдох хэргийг шүүхэд шилжүүлээгүй байгаа бөгөөд хохирогчийн ээж Ана Марияг заналхийлж, айлган сүрдүүлжээ. Чили улсад 2019 онд өрнөсөн нийгмийн үймээн самууны үеэр үйлдэгдсэн хүний эрхийн зөрчлийн дийлэнх нь шийтгэл хүлээсэнгүй. Чилийн Ерөнхий Прокурорын газрын мэдээлснээр тухайн үед үйлдэгдсэн хүний эрхийн хүчирхийллийн хохирогчдын 10,142 гомдлын 127-д нь л эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд 38 хэрэгт ял оноож, 17 хэргийг цагаатгажээ.

Эквадор улсад 2019, 2022 онд болсон эсэргүүцлийн жагсаалын үеэр аюулгүй байдлын хүчнийхэн хүний эрхийг зөрчсөн үйлдэлдээ шийтгэл хүлээгээгүй хэвээр байна. Зургадугаар сард гарсан 755 дугаар тогтоолоор хүний биед гэмтэл учруулсан, гэмтээсэн, амь насыг нь хохироосон хэрэгт сэжиглэгдэж буй хууль сахиулах байгууллагын албан тушаалтныг зөвхөн гэм буруутайг нь тогтоож шийтгэл ногдуулсны дараа баривчлах буюу албан тушаалаас нь чөлөөлөх боломжтой байхаар заасан. 6 дугаар сарын байдлаар Колумби улсад 2016 онд байгуулсан Энх тайвны хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд багахан ахиц гарчээ.

Гэхдээ Аргентин, Чили зэрэг улсад шударга ёс, үнэнийг мэдэх эрх, хохирлыг барагдуулах үйл явцад зарим ахиц гарсан. Аргентинд 1976-1983 оны цэргийн

дэглэмийн үед үйлдэгдсэн хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг ердийн шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилсээр байна. Чили улсад Аугусто Пиночетын дэглэмийн үед (1973-1990) сураггүй алга болсон хүмүүсийг хайх үндэсний төлөвлөгөөг танилцуулсан бөгөөд хараахан хэрэгжээгүй байна. Мөн Засгийн газраас энэ үеийн дурсгалыг хүндэтгэх, дурсгалт газруудыг хамгаалах өвийн бодлогыг танилцуулав.

Өнгөрөгч зургаадугаар сард ОУЭШ-ийн Шүүх хуралдааны өмнөх танхимаас Венесуэлд үйлдэгдсэн хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн мөрдөн шалгалтын ажиллагааг үргэлжлүүлэх эрхийг Прокурорын газарт олгосон бөгөөд Аргентины холбооны прокурор Венесуэлд үйлдэгдсэн хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг хэргийн түгээмэл харьяаллын зарчимд үндэслэн эхлүүлсэн.

Улс орнууд ял шийтгэл хүлээхгүй байх явдалтай тэмцэхэд хүчин чармайлт гаргаж, үнэнийг мэдэх эрх, шударга ёс болон хохирлыг барагдуулах баталгааг хангах шаардлагатай.

ЭРҮҮЛ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Америкийн бүс нутаг, ялангуяа Аргентин, Боливи, Бразил, Канад, Эквадор, Мексик, Перу, АНУ зэрэг улсад хүний эрүүл орчинд амьдрах эрхийг хангах, уур амьсгалын хямралын хүнд нөлөөлөх сөрөг үр дагаврыг бууруулах хангалттай бөгөөд үр дүнтэй арга хэмжээ авч чадсангүй. Энэ нь ялангуяа том хэмжээний ашиглалтын төслийн уугуул хүмүүс, тэдгээр төслийн ойролцоо амьдардаг хүмүүс болон байгаль орчны доройтолд онцгой өртөмтгий, гадуурхагдсан бусад бүлгүүдэд илүү ноцтой нөлөөлж байгаагаас тодорхой харагдаж байна. Боливи улс ойн нөөцийг хадгалах амлалт өгсөн хэдий ч оны эцэс хүртэл уур амьсгалын өөрчлөлтийн улмаас улам бүр хүндэрсэн ойн түймрийн улирлаас урьдчилан сэргийлэх хангалттай арга хэмжээ авч чадаагүй хэмээн хүний эрх хамгаалагчид онцолсон.

Олон тооны улсад байгаль орчинд сөрөг нөлөөтэй олборлох бүтээн байгуулалтын төслүүдийг идэвхтэй эсэргүүцсэн уугуул иргэд болон бусад хүмүүст эрүүгийн ял шийтгэл хүлээлгэсэн.

2023 онд дэлхийн температур болон хүлэмжийн хийн ялгаруулалт дээд цэгтээ хүрсэн. Хэдийгээр Америкийн бүс нутгийн улс орнуудын үүнд оруулсан хувь нэмэр ихээхэн ялгаатай байсан ч Бразил, Канад, АНУ нь бүс нутаг болон дэлхийн хэмжээнд хүлэмжийн хийн ялгаруулалт хамгийн их гаргасан орны нэг байв. Бүс нутагт чулуужсан түлшний олборлолтыг өргөжүүлэх, түүхий газрын тос олборлох (хий шатаах)-той холбоотой хий шатаах төслүүд, түүнчлэн чулуужсан түлшний татаасыг хадгалах зэрэг нь Парисын хэлэлцээрт заасан дэлхийн уур амьсгалын зорилтуудын хэрэгжилтэнд саад болж байв. Бүс нутгийн засгийн газрууд бүх төрлийн чулуужсан түлшний хэрэглээ, үйлдвэрлэл болон бүх төрлийн чулуужсан түлшний татаасыг хурдан бөгөөд шударгаар зогсоох үүрэг амлалтаа биелүүлж чадсангүй.

Эрх баригчид бүс нутгийн хэмжээнд уур амьсгалын эсрэг арга хэмжээг боловсруулах замаар уур амьсгалын хямралын хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг яаралтай шийдвэрлэх шаардлагатай. Бүс нутгийн аж үйлдвэржсэн болон өндөр ялгаруулалт бүхий бусад улс орнууд чулуужсан түлшний үйлдвэрлэл, татаасыг нэмэгдүүлэхээ зогсоох замаар уур амьсгалын өөрчлөлтийг үр дагаврыг бууруулахад манлайлах ёстой. Түүнчлэн засгийн газрууд уур амьсгалын шударга ёс, байгаль орчны эрхийн төлөө тэмцэж буй уугуул хүмүүс болон хүний эрхийг хамгаалагчдын хамгаалалтыг хангах ёстой. Бүс нутгийн өндөр хөгжилтэй улс орнууд бага орлоготой болон хөгжиж буй орнуудын сөрөг нөлөөллийг бууруулах, дасан зохицох стратегийг дэмжихийн тулд уур амьсгалын санхүүжилтийг яаралтай өргөжүүлж, алдагдал, хохирлыг арилгахад тусгайлан зориулсан нэмэлт санхүүжилт олгох үүрэг хүлээх ёстой.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЭРХ

Тус бүс нутагт Ковид-19 тахлын үеэр хурдацтай өсөн нэмэгдсэн ядуурал болон нэн ядуурлын түвшин 2023 онд тахлын өмнөх түвшинд хүрсэн ч улс орнууд 2030 он гэхэд ядуурлыг арилгах зорилтыг биелүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч чадаагүй хэвээр байв. Латин Америкийн хүн амын 30 орчим хувь (183 сая хүн) нь ядуу, 11.4 хувь нь (72 сая) нэн ядуу амьдарч байна. Латин Америкийн нийт орлогын 34% нь хүн амын хамгийн чинээлэг 10% -д төвлөрч, тэгш бус байдал нь улс орнуудын хүртээмжтэй өсөлт, хөгжлийг дэмжих гол сорилт хэвээр байна.

Улс орнууд ядуурал, тэгш бус байдалтай тэмцэж, эрүүл мэнд, боловсрол, орон сууц, нийгмийн хамгаалал, чухал бараа, үйлчилгээг хүртэх эрхийн талаарх хүний эрхийн үүргээ биелүүлэхийн тулд санхүүгийн болон төсвийн хүчирхэг арга хэмжээг авах шаардлагатай.

АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Хэд хэдэн улсад эмэгтэйчүүд болон ЛГБТИ хүмүүсийн эрхийн талаар бага зэргийн ахиц гарсан. Тайландад эрүүдэн шүүх, хүчээр алга болгохыг гэмт хэрэгт тооцдог шинэ хууль батлагдсан. Малайзад цаазаар авах ялыг цуцалсан. Гэвч Ази, Номхон далайн бүс нутагт хүний эрхийн төлөв байдал ерөнхийдөө бүрхэг хэвээр байна.

Мьянмар дахь зэвсэгт мөргөлдөөн улам бүр даамжирч, энгийн иргэд амиа алдаж, дүрвэлээ. Афганистанд Талибанчуудын дарангуйлал ялангуяа охид, эмэгтэйчүүдийн эсрэг нэлээд эрчимжсэн. Олон улс оронд үзэл бодлоо илэрхийлэх, хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхэнд тавих хязгаарлалтыг чангатгаснаар бүс нутгийн ихэнх хэсэгт шүүмжлэх байдлыг үл тэвчих явдал улам нэмэгдсээр байна. Төрийн бодлого, үйл ажиллагааг шүүмжилсэн хүний эрх хамгаалагчид, улс төрийн зүтгэлтнүүд, сэтгүүлчдийг дур зоргоор баривчилж, цагдан хорьсон бол шударга бус явдлыг эсэргүүцсэн жагсаал цуглааны эсрэг хууль бус хүч албадлага, зарим тохиолдолд үхэлд хүргэх хүч хэрэглэсэн.

Шашны болон үндэстний цөөнх, нийгмийн эмзэг бүлэг хэмээн нэрлэгдэх охид, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүс, уугуул иргэдийг ялгаварлан гадуурхах олон жил үргэлжилсэн хэв маяг хэвээр байна. Эдийн засгийн хямрал дээрх болон бусад гадуурхагдсан бүлгүүдэд илүү хүндээр нөлөөлж байна. Мөн тэдгээр нийгмийн бүлгүүд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн ноцтой үр дагавар, тухайлбал цаг агаарын гамшигт тэргүүн эгнээнд өртөж байна. Гэвч бүс нутгийн засгийн газрууд нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг хязгаарлах, эсхүл хамгаалах, дасан зохицох үр дүнтэй арга хэмжээг бодитоор хэрэгжүүлж чадсангүй

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Засгийн газрууд хэвлэл мэдээлэл, хүний эрхийг хамгаалагчид, сөрөг хүчний намууд, засгийн газрыг шүүмжлэгчид болон бусад хүмүүсийг нухчин дарах ажиллагааг эрчимжүүлснээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө улам бүр аюулд орсоор байна.

Хэд хэдэн улс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд тогтоосон хэт хатуу хязгаарлалтыг хэвээр үлдээж, зарим нь улам чангатгасан. Афганистанд сэтгүүлчид болон бусад хэвлэл мэдээллийн ажилтнуудыг дур зоргоор баривчилан олон тооны хэвлэл мэдээллийн хэрэгсэл хаагдсан бөгөөд зарим нь хаалгаа барихаас өөр аргагүйд хүрчээ. Мьянмарт шударга бусаар шүүгдэн удаан хугацаагаар хорих ялаар шийтгэгдсэн хүмүүсийн дунд сэтгүүлчид мөн өртжээ. Хойд Солонгост иргэний орон зайд засгийн газрын бүрэн хяналтаа тогтоож, эсрэг үзэл суртал баримталж буй хүмүүст хатуу шийтгэл хүлээлгэдэг хэвээр байна.

Бусад улс оронд шүүмжлэлт дуу хоолойг боомилох засгийн газрын оролдлого янз бүрийн байдлаар илэрлээ. Бангладеш, Хятад, Энэтхэг, Пакистан, Папуа Шинэ Гвиней, Сингапур зэрэг улсад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан шинэ хууль, журам батлагдаж хүчин төгөлдөр үйлчилж эхлэв. Фижи улсын шинэ засгийн газар хэвлэл мэдээллийн эрхийг хязгаарласан хуулийг хүчингүй болгосон ч бусад хязгаарлалт бүхий хууль тогтоомж үйлчилсэн хэвээр байна.

Камбож улсад цөөхөн үлдсэн хараат бус, бие даасан хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэгнийх нь зөвшөөрлийг цуцалсан бол Энэтхэгийн засгийн газар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хүний эрхийн байгууллагуудад нэгжлэг хийж, тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэхийн тулд санхүү, мөрдөн байцаах төв байгууллагуудыг ашиглав. Төрийн албан хаагчдад хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтийн ашиг сонирхлын талаарх мэдээллийг түгээхийг хориглож Бутан улс дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний үзүүлэлтээр ухрав.

Эсэргүүцлийг нухчин дарахын тулд цензур, ажиглалт, тандалтын технологийг улам ихээр ашиглах болов. Хятад улс шинэ удирдамжаар нийгмийн сүлжээ ашиглагч нарт нэмэлт хязгаарлалт тавьсан бол социал медиа компаниуд тодорхой хэрэглэгчдээс хувийн мэдээллээ өгөхийг шаардах болсон нь хувийн нууцыг хамгаалах эрхийн асуудлыг улам бүр хөндөж байна. Хонконгод Үндэсний аюулгүй байдлын тухай хууль болон колоничлолын үеийн үймээн самууны хуулийг ном, дуу, социал медиа болон бусад цахим болон цахим бус контентын агуулгыг хянахад ашигласаар байна. Вьетнамд Predator тагнуулын программыг ашиглан олон арван нийгмийн сүлжээний хаягуудыг тагнах кампанит ажлын ард төрийн байгууллагууд эсвэл тэдний өмнөөс ажиллаж буй хүмүүс байж болзошгүй гэдгийг «Эмнести Интернэшнл» судалгаагаар тогтоосон бол Тайландын засгийн газар Pegasus тагнуулын программыг хүний эрхийн эсрэг ашиглаж байгаа асуудлыг шийдвэрлэж чадсангүй.

Засгийн газраас онцгой, эмзэг гэж үзсэн мэдээллийг түгээсэн, эсхүл энэ талаар үзэл бодлоо илэрхийлсэн хүмүүсийг шүүхээр дарамтлах нь түгээмэл байна. Вьетнамд сэтгүүлчид, идэвхтнүүдийг «төрийн эсрэг суртал ухуулга тараасан» хэрэгт буруутган хорих ял оноожээ. Мальдив улсад сэтгүүлчдийг эсэргүүцлийн жагсаал болон бусад үйл явдлын талаар мэдээлснийх нь төлөө баривчилжээ. Малайз улсын засгийн газар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарласан хуулиудыг хүчингүй болгох амлалтаа биелүүлээгүй төдийгүй бусад кино бүтээл туурвигчид, номын редакторууд зэргийг мөрдөн шалгахдаа үргэлжлүүлэн ашигласаар байна. Тайланд улсын эрх баригчид шүүмжлэгчдийг яллаж шийтгэхийн тулд цахим харилцааг хязгаарласан хуулиудыг үргэлжлүүлэн хэрэглэсээр байгаа бол Филиппиний засгийн газар шүүмжлэгчдэд хууль бус ял тулгасаар байна. Папуа улсын тусгаар тогтнолыг энх тайвнаар уриалсан нь Индонезид хоригдох ялтай гэмт хэрэгт тооцогдсон хэвээр байв. Лаос улсад хүний эрхийг хамгаалагчдыг айлган сүрдүүлэх, дур зоргоороо баривчлах, хууль бусаар алах, хүчээр алга болгох зэрэг үйлдэл олон жилийн турш үргэлжилсээр байна. Мөн Пакистанд сэтгүүлчид, хүний эрхийн хамгаалагчид болоод засгийн газар, цэргийн байгууллагыг шүүмжлэгчдийг дур мэдэн баривчилж, хүчээр алга болгосоор байна.

Эсэргүүцэл, шүүмжлэлийг улсын хил дамнуулан дарах хандлага газар авах төлөвтэй байна. Хятад, Хонконгийн эрх баригчид идэвхтнүүд, тэр дундаа гадаад руу зугатсан иргэдийг баривчлах шийдвэр гаргаж, санхүүгийн урамшуулал амлан, эх оронд нь буцаан шилжүүлэхийг бусад улс орноос шаардсан. Үүний дараа Лаосоос буцаж очсон хүний эрхийн хоёр хамгаалагчийг Хятадад баривчилжээ. Вьетнамын эрх баригчид нэр хүндтэй Ютүүбэрийг (Youtuber) Тайландаас хулгайлсан хэрэгт холбоотой байсан бол Лаосын хүний эрхийн хамгаалагч Тайландад буудуулж амиа алджээ.

Засгийн газрууд хууль ёсны үзэл бодлоо илэрхийлэхийг гэмт хэрэгт тооцсон, хязгаарласан бүх хууль тогтоомжоо хүчингүй болгож, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хууль ёсны дагуу хэрэгжүүлэхтэй холбоотой үндэслэлгүй мөрдөн байцаалт, ял шийтгэх ажиллагааг зогсоож, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хүндэтгэх ёстой.

ТАЙВАН ХУРАН ЦУГЛАХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Илүү хүлээцтэй байсан Фижи улсыг эс тооцвол бүс нутгийн засгийн газрууд тайван хуран цуглах эрх чөлөөнд цаашид хязгаарлалт тогтоохыг эрмэлзсээр байна.

Тайландад 2020 онд эхэлсэн улс төр, нийгмийн шинэчлэлийн төлөөх эсэргүүцлийн жагсаалд оролцсон үндэслэлээр оны эцэс гэхэд 2000 орчим хүнд эрүүгийн ял ногдуулжээ. 2022 онд БНХАУ-ын Өрөмч хотод гарсан орон сууцны гал түймрийн хохирогчдын дурсгалыг хүндэтгэх арга хэмжээнд оролцсон нилээд хэдэн жагсагчийг хорьсон. Мөн Ковид-19-ийн хязгаарлалтыг эсэргүүцсэн жагсаалд оролцсон хэргээр нийт хэдэн хүнийг саатуулсан нь тодорхойгүй ч жагсагчдыг хүчирхийлж байгааг цахим сүлжээнд түгээсэн Уйгар оюутанд гурван жилийн хорих ял оноосон. Малайз болон Монгол улсын эрх баригчид тайван жагсаал хийх эрхийг хязгаарлахын тулд дарангуйлагч хуулиудыг үргэлжлүүлэн хэрэглэсээр байгаа бол Өмнөд Солонгос улсад “хууль бус” жагсаалын эсрэг улам бүр хатуу байр суурь баримталж байгаа нь төрийн өмчит компани хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалагчдын эсрэг хохирол барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах нөхцөлийг бүрдүүлжээ. Мьянмарт шоронд хоригдож буй Төрийн зөвлөх асан Аун Сан Су Чигийн төрсөн өдөрт зориулж цэцэг зүүсэн олон арван хүнийг баривчилжээ.

Хууль бусаар хүч хэрэглэх нь гэмтэл бэртэл, зарим тохиолдолд үхэлд хүргэх нь түгээмэл хэвээр байв. Афганистан улсад Талибанчууд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах жагсаал, цуглааныг тараахын тулд галт зэвсэг, усан буу, цахилгаан буу ашиглажээ. Пакистан, Шри Ланкийн эрх баригчид эсэргүүцлийн жагсаалыг хориглохыг эрмэлзэж, эсэргүүцэгчдийн эсрэг хүч албадлагыг хэтрүүлэн, эсхүл хууль бусаар ашигласны улмаас дээрх улсад олон хүн амь насаа алдаж, түүнээс олон тооны хүн гэмтэж, шархаджээ. Бангладеш улсад цагдаа нар сөрөг хүчний тэргүүлсэн эсэргүүцлийн жагсаалын эсрэг резинэн сум, галт зэвсэг, нулимс асгаруулагч хий ашигласны улмаас нэг хүн амь үрэгджээ. Түүнчлэн олон мянган хүнийг баривчилжээ. Индонез, Мальдив, Балбад Аюулгүй байдлын албаныхан жагсагчдын эсрэг хууль бус хүч хэрэглэсэн байна.

Мөн хэд хэдэн улсад чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарлах явдал улам бүр гүнзгийрэв. Камбож улсад цорын ганц сөрөг хүчний намын сонгуульд оролцох хамгаалах жагсаал, цуглааныг тараахын тулд галт зэвсэг, усан буу, цахилгаан хугацаагаар хорих ялаар шийтгэв. Филиппин улсад хүний эрх, хүмүүнлэгийн байгууллагуудыг хориотой коммунист бүлгүүд, эсхүл “улаан шошго”-той холбоотой хэмээн буруутгаж, гишүүдийг нь хилс хэрэг, хууль бус аллага болон бусад хүний эрхийг зөрчсөн хэрэгт буруутгах явдал нэмэгджээ. Өмнөд Солонгост үйлдвэрчний эвлэлүүд дарамт, хүчирхийлэлд өртөж, хөдөлмөрлөх эрхийн төлөөх олон арван идэвхтнүүдийг эрүүгийн хэрэгт буруутган шалгажээ.

Засгийн газрууд тайван жагсаал, цуглаан, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хүндэтгэж, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх ёстой. Түүнчлэн хүний эрх хамгаалагчдын үйл хэргийг хүндэтгэж, хамгаалж, тэдэнд ажиллах аюулгүй, таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай.

ДУР ЗОРГООР БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ

Хүний эрх хамгаалагчид, улс төрийн болон байгаль орчны идэвхтнүүд болон засгийн газрын бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн бусад хүнийг үндэс угсаа, шашин шүтлэг болон бусад шинжээр нь дур мэдэн баривчилж, цагдан хорьсоор байна.

Хятадад Шинжаан-Уйгурын өөртөө засах орны Уйгур болон бусад мусульман шашинт голдуу үндэстний цөөнх хүмүүсийг дур мэдэн баривчилж, шударга бусаар

шүүх ажиллагаа үргэлжилсээр байна. Мьянмарт 2021 оны цэргийн эргэлтийг эсэргүүцсэн үндэслэлээр 20,000 гаруй хүнийг баривчилсан бөгөөд шударга бусаар шүүх ажиллагаа үргэлжилсээр байна.

Пакистан улсын эрх баригчид Ерөнхий сайд асан Имран Ханыг тавдугаар сард баривчилсны дараа жагсаалд оролцсон 4000 гаруй хүнийг дур зоргоор баривчлахын тулд Нийтийн хэв журам сахиулах тухай хууль болон тодорхой бус зохицуулалт бүхий Терроризмын эсрэг хуулийг ашигласан. Түүнчлэн улс төрийн манлайлагч, идэвхтнүүд зэрэг өөр 103 энгийн иргэнийг цэргийн шүүхээр шүүжээ. Энэтхэгийн шүүхүүдээс Жамму, Кашмирт дур зоргоор баривчилсан сэтгүүлчдийг батлан даалтад гаргаж, эсхүл цагдан хорих шийдвэрийг хүчингүй болгосон хэдий ч тус улсад хүний эрх хамгаалагчдыг шүүхийн шийдвэргүйгээр, ихэнхдээ олон жилийн турш хорьсон хэвээр байна.

Монгол Улсад хэрэг хянан шийдвэрлэх баталгаа алдагдсаны улмаас шүүхийн шийдвэргүйгээр баривчлах тохиолдол олноор гарч байна.

Засгийн газрууд засгийн газрыг шүүмжлэгчид болоод бусад хүнийг дур зоргоор баривчлах, цагдан хорих явдлыг таслан зогсоож, ердөө үзэл бодлоо илэрхийлсэн, тайван жагсаал цуглаан хийсэн, эвлэлдэн нэгдсэн болон бусад хүний эрх, эрх чөлөөгөө тайван замаар хэрэгжүүлснийхээ төлөө хоригдож байгаа хүн бүрийг нэн даруй суллах ёстой.

ЯЛ ЗАВШИХ, ШУДАРГА ЁСНЫ ЭРХ

Ял шийтгэлгүй үлдэх, ял завших байдал өргөн тархаж хохирогчдын шүүхэд хандах, үнэнийг мэдэх, хохирлоо барагдуулах эрхийг нь байнга үгүйсгэж байна. Олон улсын эрүүгийн шүүх Филиппин дэх мөрдөн шалгах ажиллагааг сэргээх шийдвэр гаргасан нь «хар тамхины эсрэг дайн»-ын үеэр хууль бусаар хөнөөсөн тоо томшгүй олон хохирогчдын ар гэрийнхэнд тодорхой хэмжээний итгэл найдвар төрүүлсэн хэдий ч хүний эрхийн ноцтой зөрчилд хариуцлага хүлээлгэх бараг боломжгүй хэвээр байна. Тайланд улсын төрийн аюулгүй байдлын албаныхан хууль бус аллагын гэмт хэрэгтээ ял шийтгэл хүлээсэнгүй. Шри Ланка, Балбын засгийн газар дотоодын зэвсэгт мөргөлдөөний үеэр олон улсын хууль тогтоомжид заасан гэмт хэрэг, хүний эрхийн бусад ноцтой зөрчлийн мянга мянган хохирогчдын шударга ёсыг сахиулах, үнэнийг мэдэх, хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг хэрэгжүүлэх чиглэлээр дахин ахиц гаргаж чадсангүй.

Засгийн газрууд олон улсын хууль тогтоомжид заасан гэмт хэрэг болон хүний эрхийн бусад ноцтой зөрчлийг нарийн нягт, хараат бус, шударга, мөрдөн байцаалт явуулах замаар гэмт хэрэг үйлдсэн сэжигтнүүдийг шударгаар шүүж, ял шийтгэлгүй үлдэх асуудлыг шийдвэрлэх ёстой. Өнгөрсөнд үйлдэгдсэн хүний эрхийн хүчирхийллийг мөрдөн шалгах олон улсын ажиллагаа, шударга ёсны үйл явц, хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлд хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай.

ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН ЗӨРЧИЛ

Мьянмарт олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг зөрчих явдал үргэлжилсээр байгаа бөгөөд цэргийн болон холбогдох зэвсэгт хүчний агаарын, газрын халдлага улс орон даяар тархсаны улмаас 1000 гаруй энгийн иргэн амиа алджээ. Сөргөлдөгч зэвсэгт бүлгийнхэн Мьянмарын цэргийн эрх баригчидтай холбоотой энгийн иргэд рүү зэвсэгт халдлага үйлдсэн гэх мэдээлэл ч байна. Афганистаны Панжшир мужид Талибанчуудын эсрэг үргэлжилж буй зэвсэгт эсэргүүцлийн хүрээнд энгийн иргэдэд хамтын шийтгэл ногдуулсан, Үндэсний эсэргүүцлийн фронтын олзлогсдыг шүүхээс

гадуур цаазалсан тухай шинэ нотлох баримтууд гарч ирсний зэрэгцээ зэвсэгт бүлэглэлүүд, тэр дундаа Хорасан мужийн Исламын улс бүлэглэлийн дайралтын улмаас олон мянган хүн амь нас үрэгджээ.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч бүх талууд энгийн иргэд болон иргэний дэд бүтцийг ялгахгүйгээр, эсхүл шууд чиглүүлсэн халдлага үйлдэхээ зогсоох зэргээр олон улсын хүмүүнлэгийн хуулийг дагаж мөрдөх ёстой

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ

Хэд хэдэн улс эдийн засгийн ноцтой хямралд нэрвэгдсэн хэвээр байв. Лаос, Пакистанд инфляцын огцом өсөлтийн улмаас амьжиргааны өртөг нэмэгдсэн нь ялгаварлан гадуурхалд хамгийн өртөмтгий хүмүүст ноцтой нөлөөлсөн. Хүн амын дөрөвний нэгээс дээш хувь нь ядуурлын сугамаас доош унах эрсдэлтэй Шри Ланка улсад хоол хүнс, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон бусад үндсэн хэрэгцээг хангах нь ялангуяа өдрөөр цалинждаг хүмүүс болон Малайяха Тамилчуудын хувьд өдөр тутмын томоохон сорилт болжээ. Афганистан дахь хүмүүнлэгийн хямрал улам гүнзгийрч, хүмүүнлэгийн тусламжид найдсан хүмүүсийн тоо улам бүр нэмэгдэх тооцоолол байгаа хэдий ч хүмүүнлэгийн тусламжийн төлөвлөгөө санхүүжилтийн дутагдалтай хэвээр байна.

Папуа Шинэ Гвинейд эрүүл мэндийн тогтолцооны нөөцийн хомсдолын улмаас хүн амын ихэнх нь зохих эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч чадахгүйд хүрчээ. Хойд Солонгост хүнсний аюулгүй байдал алдагдсан хэвээр байгаа бөгөөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, түүний дотор зайлшгүй шаардлагатай эм, вакцин олох боломжгүй байв.

Албадан нүүлгэн шилжүүлэлт, орон байраа нураалгасны улмаас олон мянган хүн орон гэргүй, амьдрахад маш хүнд, эрсдэлтэй нөхцөлд хүрэв. Камбожид ЮНЕСКО-гийн Дэлхийн өвд бүртгэгдсэн Ангкороос 10,000 гэр бүлийг албадан нүүлгэх ажиллагаа үргэлжилсээр байна. Энэтхэгт албан бус барилга байгууламжийг нураасны дараа 300,000 орчим хүн орон гэргүй болжээ. «Их 20»-ийн дээд хэмжээний уулзалтын өмнө Дели хотод суурьшсан голдуу лалын шашинтнуудын гэр орон, бизнес, мөргөлийн газруудыг нурааж хамтын хүчирхийллийн шийтгэлийг үргэлжлүүлэв. Индонез улсын эрх баригчид төлөвлөгөөт нүүлгэн шилжүүлэлт болон дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслүүдийг эсэргүүцсэн иргэдийн эсрэг хүч, албадлагыг хэтрүүлэн хэрэглэсэн бол, Лаос улсад далан барих төслийн улмаас олон мянган иргэдийг зохистой нөхөн олговоргүйгээр нүүлгэн шилжүүлэх эрсдэлтэй байна.

Төвд, Уйгур хүүхдүүдэд чиглэсэн засгийн газрын бодлого, түүний дотор уусгах бодлогоос үүдэн Хятад даяар үндэстний цөөнхийн соёл, эх хэлний эрх болон сурч боловсрох эрх зөрчигдөж байна.

Засгийн газрууд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хамгаалж, бодлого нь хоол хүнс, эрүүл мэнд, амьжиргааны эрхийг зөрчихгүй байх баталгааг хангах шаардлагатай.

БИЗНЕСИЙН БУЮУ КОРПОРАЦУУДЫН ХАРИУЦЛАГА

Хүний эрхийг зөрчилд компани хариуцлага хүлээхгүй байх нь нийтлэг хэвээр байна. Гэхдээ Эмнести Интернэшнлийн Мьянмарын талаар хийсэн судалгаа эерэг үр дүнд хүрсэн бөгөөд Мьянмарын арми энгийн иргэдийн эсрэг агаарын цохилт хийхдээ ашигладаг байсан онгоцны түлшийг нийлүүлэгч хэд хэдэн компани нийлүүлэлтээ зогсоосон. Түүнчлэн ЕХ, Их Британи, АНУ болон бусад улс орнууд эдгээр компаний заримыхн нь эсрэг зорилтот хориг арга хэмжээ авсан.

Засгийн газрууд бизнесүүд өөрсдийн болон бизнесийн түншүүдийн үйл ажиллагаа нь хүний эрхийг зөрчихгүй байх, мөн тэдний үйл ажиллагаанаас учирсан аливаа хор уршгийг арилгахын тулд хүний эрхийн хэрэгжилтийн зохих шалгалт явуулахыг шаарддаг хууль тогтоомжийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой.

ШАШИН ШҮТЭХ, ИТГЭЛ ҮНЭМШИЛТЭЙ БАЙХ ЭРХ ЧӨЛӨӨ

Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө, ялангуяа Өмнөд Азид зөрчигдсөн хэвээр байна. Энэтхэгт лалын шашинтнуудыг хүчирхийлж, айлган сүрдүүлсэн олон зуун тохиолдол бүртгэгджээ. Ахмадигийн булшийг сүйтгэснээр Пакистан улсад шашны цөөнхийн эсрэг хүчирхийлэл өргөн тархсан бөгөөд цөөнхийг эсрэг үл хүндэтгэж байгаагаа илэрхийлэн нэг өдрийн дотор 20 гаруй сүм хийдийн эсрэг халдлага үйлджээ. Афганистанд Шиа, Хазара Шиа, Сикх, Хинду, Христ, Ахмадия, Исмаилит зэрэг шашны цөөнхүүд албан ёсны шашны сургаалыг зөвхөн Исламын суннит урсгалд үндэслэсэн хэмээн үздэг талибуудын хэт ялгаварлан гадуурхалттай тулгарсан.

Засгийн газар шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг ялгаварлан гадуурхахгүйгээр бүрэн хамгаалах, дэмжих, баталгаажуулахын тулд шаардлагатай хууль эрх зүйн болон бодлогын шинэчлэл зэрэг үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

Зөвшөөрөөгүй бэлгийн харьцааг эрүүгийн хуулиар хүчингийн гэмт хэрэг болгон өргөтгөн Япон улсад бэлгийн хүчирхийллийн эсрэг хууль эрх зүйн хамгаалалтыг чангатгасан бол Фижи улсад гэрлэсэн эмэгтэйчүүдийн сонгуульд оролцоход тулгарч байсан хуулийн саадыг арилгасан.

Гэвч бодит байдалд бүс нутгийн хэмжээнд олон тооны охид, эмэгтэйчүүд тогтолцооны ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд өртсөн хэвээр байна. Ялангуяа Өмнөд Азид хүчингийн болон бэлгийн бусад төрлийн хүчирхийллийн тохиолдол олноор бүртгэгдсэн хэвээр байгаа хэдий ч хариуцлага хүлээх нь ховор байв. Энэтхэгт давамгайллагч кастын бүлгийн гишүүд Далиц, Адиваси, Куки эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэх тохиолдол ихээр гарах болсон нь анхаарах асуудал болж байна.

Ялгаварлан гадуурхалт нь олон хэлбэрээр илэрч байна. Афганистанд охид, эмэгтэйчүүдийг эрхийг улам бүр хязгаарлаж байгаа бөгөөд тэдний эсрэг чиглэсэн хүний эрхийн зөрчлийн цар хүрээ нь хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн түвшинд хүрлээ. Балбад эмэгтэйчүүдийн тэгш байх эрх зөрчигдсөн хэвээр байна. Бутан, Фижи, Япон болон бусад улсад эмэгтэйчүүд төрийн албан тушаал, ажиллах хүчний хувь хэмжээнд эзлэх байр суурь бага хэвээр байна. .

Засгийн газрууд охид, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, дэмжих, тэдний эсрэг жендэр болон олон шинжид үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг зогсоох, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэх хүчин чармайлтаа эрчимжүүлэх шаардлагатай.

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

ЛГБТИ хүмүүсийн эрхийн асуудалд ахиц дэвшил, бас ухралт гарлаа. Тайваны эрх баригчид ихэнх гадаад улсын иргэдтэй гэр бүл болох ижил хүйстэн хосуудын эрхийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд 12 дугаар сарын 21-нд Тайландын хууль тогтоогчид ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хуульчлах үйл явцыг эхлүүлсэн. Хонконг, Балба, Өмнөд Солонгосын шүүхээс ижил хүйстэн хосууд, эсхүл трансжэндэр хүмүүсийн эрхийг илүү ихээр хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргасан. Гэвч Өмнөд Солонгос улсын Үндсэн хуулийн шүүх зөвшилцөлд үндэслэсэн ижил хүйстнүүдийн бэлгийн харьцааг Солонгосын армийн хүрээнд гэмт хэрэгт тооцохыг дэмжсэн. Нэмж дурдахад, засгийн газрууд ихэнх тохиолдолд хүний эрхийг баталгаажуулсан шүүхийн шийдвэрийн эсрэг гомдол гаргадаг бөгөөд энэ нь хүний эрхийг хэрэгжүүлэхэд чөдөр болсоор байна.

ЛГБТИ хүмүүсийн эсрэг засгийн газраас явуулж буй кампанит ажлын улмаас Хятадад нэр хүнд бүхий ЛГБТИ байгууллага хаагдахаас өөр аргагүйд хүрч байгаа нь ЛГБТИ хүмүүс болон бүлгүүдийн аюулгүй байдал алдагдаж байгаа илтгэж байна. Пакистанд улс төрийн болон исламист бүлэглэлүүдийн удирдан явуулсан худал мэдээлэл түгээх кампанит ажил нь трансжэндэр хүмүүсийн хуулийн хамгаалалтыг эрсдэлд оруулж, трансжэндэр болон хүйсийн ялгаатай хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, дарамтыг нэмэгдүүлсэн. Энэтхэг улсын Дээд шүүх ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хуулиар хүлээн зөвшөөрөхөөс татгалзжээ. Малайзад ЛГБТИ хүмүүсийн амьдралын хэв маягийг сурталчилсан ном болон бусад материалыг хориглосон бол Монгол улсад ЛГБТИ хүмүүсийн эрхийг дэмжсэн жагсаалыг хоригложээ.

Засгийн газрууд ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхсан хууль, бодлогыг хүчингүй болгож, ижил хүйстнүүдийн зөвшилцсон бэлгийн харилцааг гэмт хэрэг гэж үзэхгүй байх, ижил хүйстний гэрлэлтийг хүлээн зөвшөөрөх, ЛГБТИ хүмүүсийн эрхийг дэмжиж, хамгаалах, тэднийг аюулгүй, нэр төртэй амьдрах баталгаагаар хангах ёстой.

УУГУУЛ ХҮМҮҮСИЙН ЭРХ, ҮНДЭС УГСАА, КАСТЫН ТОГТОЛЦООНД СУУРИЛСАН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

Уугуул хүмүүсийг үндэс угсаа, кастаар нь ялгаварлан гадуурхах явдал өргөн тархсан хэвээр байв. Камбож, Индонези, Малайз зэрэг улсад уугуул хүмүүсийн эрхийг үл тоомсорлож, газар нутгийг нь арилжааны зорилгоор ашиглаж тэдний амьдрал, амьжиргаанд заналхийлж байна. Нөлөөлөлд өртсөн бүлгүүдтэй хийх зөвшилцөл нь ихэвчлэн нэр төдий бөгөөд уугуул хүмүүсийн эрхийн төлөөх идэвхтнүүд хүний эрхийн зөрчилд өртөмтгий байсаар байна. Филиппинд байгаль орчныг хамгаалах хоёр уугуул идэвхтнийг хүчээр алга болгож, уугуул иргэдийн эрхийн удирдагчдыг террорист хэмээн зарлав.

Австрали дахь Анхны Үндэстэн Хүмүүсийн парламентад шууд төлөөлөх боломжтой уугуул иргэдийн “дуу хоолой”-г байгуулах саналыг бүх нийтийн санал асуулгаар татгалзсан. Шинэ Зеландад Маори хүмүүс ялгаварлан гадуурхах, үл тоох, ялангуяа эрүүгийн гэмт хэрэгт холбогдох хувь хэмжээ харьцангуй өндөр байна. Энэтхэгт кастаар ялгаварлан гадуурхах явдал буурахгүй байна.

Засгийн газар үндэс угсаа болон кастаар ялгаварлан гадуурхалтын хохирогчдын шүүхийн хүртээмжийг нэмэгдүүлэх, Далитууд, уугуул хүмүүс болон эрсдэлт бүлгийн бусад хүмүүсийн эсрэг хүний эрхийн зөрчилд ял завших явдлыг зогсоож, бүтцийн ялгаварлан гадуурхалт, тэр дундаа эрүүгийн эрх зүйн тогтолцооны ялгаварлан гадуурхалтыг арилгах бодлого, хөтөлбөрүүдийг нэн тэргүүнд бүрдүүлэх шаардлагатай.

ЭРҮҮДЭН ШҮҮХ, БУСАД ЗҮЙ БУС ХАРЬЦАА

Тайланд улсад эрүүдэн шүүх, хүчээр алга болгох үйлдлийг гэмт хэрэгт тооцох болсон нь хохирогчид болон хүний эрхийг хамгаалагчдын хамтарсан кампанит ажлын үр дүн хэдий ч эрүүдэн шүүх болон бусад төрлийн зүй бусаар харьцаанаас урьдчилан сэргийлэх тулд хийх олон ажил байна.

Бус нутгийн түвшинд баривчлагдсан хүмүүсийг эрүүдэн шүүж, зүй бусаар харьцсан олон тохиолдол бүртгэгдсэн бөгөөд баривчлах байранд нас барах тохиолдол маш түгээмэл байсан. Бангладеш улсад нэг жилийн хугацаанд хамгийн багадаа 94 хүн, Малайзад 13 хүн баривчлах байранд нас баржээ. Балбад эрүүдэн шүүж, зүй бус харьцсан олон тохиолдол гарсан боловч хэнд ч хариуцлага хүлээлгэсэнгүй. Афганистанд цагдан хорих байранд эрүүдэн шүүх явдал өргөн тархсан хэвээр байгаа бөгөөд эрүүдэн шүүх эсвэл бусад зүй бусаар харьцах үйлдэлтэй дүйхүйц түвшинд олон нийтээр ял гүйцэтгэх бие махбодын шийтгэлийг гүйцэтгэж байна. Индонезийн цэргийн хүчин Папуа улсын уугуул хүмүүс, тэр дундаа хүүхдүүдийг дур зоргоор цагдан хорьж, эрүүдэн шүүж, амь насыг нь хохироосон үйлдэлд хариуцлага хүлээсэн.

Засгийн газрууд эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах үйлдлийг хориглож, гэмт хэрэгт тооцох, түүнчлэн ялгаварлан гадуурхагдсан болон эрсдэлтэй бүлгийн хүмүүсийг хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг авах шаардлагатай. Улс орнууд дээрх гэмт үйлдлийг мөрдөх шалгах, холбогдох этгээдэд хариуцлага хүлээлгэх, хохирогчдын зөрчигдсөн эрхийг цаг тухайд нь сэргээх шаардлагатай.

ЭРҮҮЛ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Бус нутгийн түвшинд тохиосон аймшигт үер, хэт халалт, үхлийн аюултай хар салхи зэрэг нь уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг болохыг илтгэж байна. Гэвч нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах, бэлэн байдал, дасан зохицох арга хэмжээнүүд хангалтгүй хэвээр байна. Өмнөхтэй нэгэн адил эдгээрийн хортой үр дагавар хамгийн ядуу, хамгийн гадуурхагдсан хүмүүст хүндээр тусаж байна.

Тавдугаар сард Мьянмарыг дайрсан хар салхины улмаас Рохинжа үндэстнүүдийн дунд амиа алдагсдын тоо их байгаа нь 2012 онд албадан нүүлгэн шилжүүлснээс хойш амьдралын нөхцөл нь улам хүндэрсэнтэй холбоотой. Энэтхэг улсад Гималайн бүс нутагт тохиосон үер, Уттар Прадеш, Бихар мужид болсон хэт халалтын улмаас 200 орчим хүн нас баржээ. Пакистанд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хэт халалтын давллагаа үргэлжилсээр байгаа бөгөөд энэ нь ялангуяа ядууралд өртсөн болон албан бус салбарын ажилчдын эрүүл мэндэд ноцтой нөлөөлж байна.

Дэлхийн дундаж температурын өсөлтийг аж үйлдвэржилтийн өмнөх үеийнхээс 1.5°C-ээс доош байлгахын тулд нүүрс хүчлийн хийн ялгарлыг бууруулах улс орнуудын хүчин чармайлт, ялангуяа томоохон ялгаруулагч улсуудад хангалтгүй хэвээр байв. Улс орнуудын бодлого, үйл ажиллагаа нь тэдний хүлээсэн үүрэг зорилтоо биелүүлэхтэй нь байнга зөрчилдөж байна. Тухайлбал, Тайваны Засгийн газраас ялгаруулалтыг бууруулах хууль тогтоомжийг баталсан ч чулуужсан түлшийг үе шаттайгаар зогсоох хугацаа тодорхойгүй, газрын тосны хайгуулын ажил үргэлжилсээр байна.

Бус нутгийн эрчим хүчний системд нүүрсний хамаарал буурах шинж бараг ажиглагдахгүй байна. Үүний эсрэгээр Австрали, Хятад, Индонези, Өмнөд Солонгос зэрэг улсын засгийн газраас шинэ нүүрсний үйлдвэрүүд болон нүүрсний уурхайн төслүүдэд зөвшөөрөл олгосон нь дотоодын хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан. Япон

улс цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд нүүрсний хэрэглээг аажмаар зогсоох үүрэг хүлээгээгүй дэлхийн цорын ганц аж үйлдвэржсэн орон юм.

Улс орнууд олборлох үйлдвэрлэлийн байгаль орчин, уугуул хүмүүс болон нөлөөлөлд өртсөн бусад хүмүүст үзүүлэх сөрөг нөлөөллийг удаа дараа үл ойшоож байна. Тухайлбал, Монгол Улсын говийн бүсэд явуулж байгаа уул уурхайн үйл ажиллагааны малчдын эрүүл мэнд, амьжиргаанд үзүүлэх нөлөөллийг арилгах арга хэмжээ хангалтгүй байсаар байна. Папуа Шинэ Гвиней улсын засгийн газар өмнө нь хүний эрхийг ноцтойгоор зөрчиж, байгаль орчинд хохирол учруулсан алт олборлолтын үйл ажиллагааг дахин нээх зөвшөөрөл олгохдоо зөрчилд холбогдогч компаний асуудлыг зохистойгоор шийдвэрлээгүй байна.

Бүс нутгийн аж үйлдвэржсэн болон бусад өндөр ялгаруулалт бүхий улс орнууд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, тэр дундаа чулуужсан түлшний үйлдвэрлэл, түүнд олгох татаасыг өргөжүүлэх явдлыг зогсоож, уур амьсгалын бодлого нь дэлхийн дулаарлыг 1.5 хэмд тогтоон барих зорилтод нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах ёстой. Засгийн газрууд гамшгийн бэлэн байдал, дасан зохицох ажилд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж, уур амьсгалын хямралд илүүтэй өртөж буй гадуурхагдсан болон бусад эмзэг бүлгийг хамгаалахад тэргүүлэх ач холбогдол өгөх ёстой

ДҮРВЭГСЭД, ЦАГААЧДЫН ЭРХ, ХҮНИЙ НАЙМАА

Дүрвэгсэд болон орогнол хүсэгчдийг тодорхойгүй хугацаагаар саатуулахыг Австрали, Өмнөд Солонгос улсын шүүхээс тус улсын Үндсэн хуулийг зөрсөн хэмээн шийдвэрлэсэн боловч дүрвэгсэд, орогнол хүсэгчид болон цагаачдын хамгаалалт бүс нутаг даяар хангалтгүй, хүний эрхийг үл тоомсорлосон хэвээр байна.

Олон тооны дүрвэгсэд, цагаачдыг цагаачлалын цагдан хорих төвүүдэд дур зоргоор, тодорхойгүй хугацаагаар саатуулах, эсхүл зохистой орон байр, наад захын үндсэн үйлчилгээ авах эрхийг үгүйсгэн, чөлөөтэй зорчих эрх чөлөөг хязгаарлаж байна.

Малайзын эрх баригчид 2022 онд цагаачдын хорих төвүүдэд эмэгтэйчүүд, хүүхэд зэрэг 150 хүний амь нас хохирсон хэргийг шалган шийдвэрлээгүй бөгөөд тус төвүүдийн нөхцөл байдлын талаарх санаа зовоосоор байна. Бангладеш улсад нэг хуаранд гал гарч, хар салхины улмаас олон мянган Рохинжа дүрвэгч дахин орон гэргүй болжээ. Тайландад дүрвэгсэд болон орогнол хүсэгчдийг шалгах шинэ механизм бий болсон хэдий ч хүнд нөхцөлд, тодорхой хугацаагүйгээр цагдан хорьсны улмаас хоёр Уйгур залуу амиа алдсан байна. Япон улсын цагаачлалын тухай шинэ хуулиар дүрвэгсэд болон орогнол хүсэгчдийг тодорхойгүй хугацаагаар цагдан хорихыг зөвшөөрсөн бол Тайвань улсын цагаачлалын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр дүрвэгсэд, орогнол хүсэгчдийг буцаан шилжүүлэхээс хамгаалах арга хэмжээг тусгаагүй.

Хүнд ял шийтгэл хүлээж болзошгүй талаарх анхааруулгыг үл харгалзан Хятадын засгийн газар Хойд Солонгосын олон зуун иргэнийг өөрийн улсаас албадан нутаг буцаав. Пакистаны засгийн газар тус улсад бүртгэлгүй Афганистаны дүрвэгсдийг нэг сарын дотор орхин явах мэдэгдлийг 10-р сард гаргасны дараа Талибанчуудын хавчлагаас дүрвэсэн 490,000 гаруй хүнийг Афганистан руу албадан буцаажээ. Мөн Малайз улс Мьянмараас дүрвэгсдийг албадан буцаахгүй байх зарчмыг үл хайхран хүний эрхийг ноцтой зөрчлөө.

Камбож, Лаос, Мьянмар, Тайландад хүний наймааны эсрэг засгийн газрын хариу

арга хэмжээ хангалтгүй хэвээр байгаа бөгөөд гадаадын ажилчдыг хууран мэхлэх, эсхүл хүч хэрэглээхээр заналхийлэх замаар цахим залилан, хууль бус мөрийтэй тоглоомын үйл ажиллагаанд албадан ажиллуулдаг.

Засгийн газар орогнол хүсэгчдийг цагаачлалын статуст нь үндэслэн цагдан хорих явдлыг зогсоож, тэдгээрийн олон улсын хамгаалалт хүсэх боломжийг хүлээн зөвшөөрөх ёстой. Ямар ч тохиолдолд хэн нэгнийг хууль бусаар ял шийтгэгдэх, хүний эрхийн бусад зөрчилд өртөж болзошгүй газар руу албадан буцааж болохгүй. Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг хамгаалалтыг улс бүр бэхжүүлж, амьд үлдсэн хүмүүст хууль эрх зүйн болон бусад дэмжлэг үзүүлэх, тэр дундаа аюулгүй тохиолдолд эх оронд нь буцаах зэрэг бусад дэмжлэгийг үзүүлэх шаардлагатай.

ЦААЗААР АВАХ ЯЛ

Малайзын засгийн газар бүх гэмт хэрэгт ногдуулах цаазаар авах ялыг хүчингүй болгосны зэрэгцээ, долоон гэмт хэрэгтэнд оноосон цаазын ялыг бүхэлд нь цуцаллаа. Гэвч бүс нутгийн улс орнууд цаазаар авах ялыг олон улсын хууль тогтоомж, стандартыг зөрчин өргөн хүрээнд хэрэглэсэн хэвээр байна. Хятад, Вьетнамд цаазаар авах ялыг гүйцэтгэсэн талаар мэдээлсэн ч энэ талаар тоо баримт нь улсын нууцад хамаардаг. Афганистанд цаазаар авах ялаар шийтгэж байгаа талаарх мэдээлэл бүртгэгдсэн бөгөөд чулуу шидэх гэх зэрэг хэрцгий, хүнлэг бус эсвэл нэр төрийг гутаан доромжилж шийтгэх аргуудыг хэрэглэж байна. Сингапурт хар тамхитай холбоотой хэргээр цаазлагдсан хүмүүсийн дунд нэг эмэгтэй байжээ. Цаазаар авах ялын эсрэг тэмцэгчид болон хуульчид заналхийлэл, хүчирхийлэлд өртжээ.

Цаазаар авах ялыг хадгалсаар байгаа улс орнууд уг ялыг эрүүгийн хуулиас хасах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай.

ХҮҮХДИЙН ЭРХ

Хүүхдэд эрүүгийн ял шийтгэл оногдуулах асуудал хэд хэдэн оронд түгшүүр төрүүлсээр байна. Австрали, Шинэ Зеланд улсад 10-аас доош насны хүүхдүүдийг цагдан хорьсон хэвээр байгаа бөгөөд тэдгээр улсын хүүхдийн цагдан хорих ангиуд нь хүүхдүүдэд аюул учруулдаг болохыг тогтоожээ. Тайландад сүүлийн жилүүдэд өрнөсөн тайван жагсаалд оролцсон үндэслэлээр 300 орчим хүүхдэд эрүүгийн хэрэг үүсгэн шалгажээ. Тэдний дотор 2020 онд 16 настай байхдаа эзэн хааныг шоглосон загвар өмсөгчдийн шоууд оролцсон хэргээр нэг жилийн хорих ялаар шийтгүүлсэн залуу багтжээ. Хойд Солонгост хүүхдүүдийг албадан хөдөлмөрлүүлж байгаа тухай мэдээллүүд гарсаар байна.

Засгийн газрууд хүүхдийг тайван жагсаал, цуглаан хийх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдэлснийх нь төлөө ямар ч нөхцөлд баривчлах, цагдан хорих ёсгүй. Засгийн газар эрүүгийн хариуцлагын доод насыг 14 ба түүнээс дээш болгон нэмэгдүүлж, хууль тогтоомжийн зөрчил бий болсон үед хүүхдийн шударга ёсны зарчмын үүднээс, тэр дундаа цагдан хорих явдлыг хатуу хязгаарлан харьцах шаардлагатай.

ЕВРОП, ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

ЗҮҮН ЕВРОП, ТӨВ АЗИ

Бүс нутаг даяар авторитар үзлийг улам хүчирхэгжүүлэхэд чиглэсэн Орос улсын Украины эсрэг өдүүлсэн дайны улмаас хүний эрх, эрх чөлөө, байнгын халдлагад өртөх болов. Засгийн газрууд хүний эрх хамгаалагчдыг хавчиж, шүүмжлэлт үзлийг дарангуйлахын зэрэгцээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хүний эрхийн хараат бус мэдээллийг "хуурамч мэдээ", эсхүл төрийн бодлого болон байгууллагуудыг "гүтгэх" оролдлого хэмээн үзэж гэмт хэрэгт тооцов. Хүний эрхийг үр дүнтэйгээр дэмжих, хамгаалах ирээдүйн төлөв байдал бүрхэг байна.

Дайн нь энэ бүс нутагт «шинэ ердийн» зүйл болон хувирав. Азербайжан улс Уулын Карабахаас салан тусгаарласан нутаг руу нэвтрэх гол замыг хаасан нь олон мянган хүний амь насанд аюул учруулах хүмүүнлэгийн хямралыг бий болгосон бөгөөд цэргийн довтолгооны дараа бараг нэг шөнийн дотор 100,000 гаруй хүн Армен руу дүрвэжээ.

ОХУ-ын Украины эсрэг түрэмгийлэл нь сүйрлийн дайн болон хувирч, олон улсын эрх зүйг зөрчсөн дайны гэмт хэрэг, бусад төрлийн гэмт хэргийн жагсаалт улам бүр нэмэгдлээ. Энгийн иргэд, ялангуяа хүүхдүүд амь насаа алдаж, бэртэж гэмтсэний зэрэгцээ, орон сууц, үндсэн дэд бүтцийн байгууламжийг сүйтгэх, олноор нүүлгэн шилжүүлэх, хүрээлэн буй орчны аюул, сүйрлийн улмаас хүмүүс асар их зовлон зүдүүрийг туулж байна.

Украины дайнаас үүдэлтэй олон улсын шударга ёсны механизмыг бий болгох, ялангуяа түрэмгийллийн гэмт хэргийн талаар хийсэн оролдлого үр дүнд хүрсэнгүй. Олон Улсын Эрүүгийн Шүүхээс Ерөнхийлөгч Владимир Путиныг баривчлах тушаал гаргасан хэдий ч түүний айлчлалыг зохион байгуулсан улсуудын дунд Казахстан, Киргизстан, Саудын Араб зэрэг ОУЭШ-ийн гишүүн бус улсууд багтжээ.

Зэвсэгт мөргөлдөөнөөс гадна шашны цөөнхийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэх явдал түгээмэл байв. Эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах явдал өргөн тархсан бөгөөд энэ төрлийн эрүүгийн хэрэгт холбогдсон хүмүүс ял шийтгэлгүй өнгөрч байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл өндөр түвшинд хүрсэн хэвээр байгаа бөгөөд жендэрийн эрхийн хамгаалалтад ухралт гарлаа. Гол төлөв чулуужсан түлшнээс үүдсэн агаарын бохирдол нь бүс нутаг даяарх хүний эрүүл мэндэд хохирол учруулж байна.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Шүүмжлэлт дуу хоолойг "хэт даврах үзэл", "терроризмыг зөвтгөх", "санаатай худал мэдээлэл тараах", ЛГБТИ "суртал ухуулга" гэх зэрэг сөрөг байдлаар буруутгах, хэлмэгдүүлэх зэрэг хариу арга хэмжээ нэмэгдэж байгаагийн улмаас үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө уналтад оров.

Орос улсад дайны цаг үеийн цензур шинэ дээд түвшинд хүрсэн бөгөөд шүүмжлэлт дуу хоолойг нэгд нэгэнгүй хянаж байна. Хэдэн мянган хүн шийтгэгдэж,

олон зуун хүн үндэслэлгүйгээр эрүүгийн хэрэгт татагдсаны дотор “эх орноосоо урвасан» хэргээр 25 жилийн ялаар шийтгэгдсэн сөрөг хүчний идэвхтэн Владимир Кара-Мурза байв.

Азербайжан, Беларусь, Казахстан, Тажикстан зэрэг улсууд засгийн газрыг шүүмжлэгчдийг олон зуугаар нь хорьж байна. Киргизстан улсын Хэвлэл мэдээллийн тухай хуулийн төсөлд “хүн амын эрүүл мэнд, ёс суртахуунд хохирол учруулсан материал” тараахыг хориглохоор тусгажээ. Туркменистанд чөлөөт мэдээллийг дарангуйлсан хэвээр байгаа тул хүнсний хомсдол, албадан хөдөлмөрийн талаарх мэдээлэл дарагдсаар байна.

ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Бүс нутаг даяар иргэний нийгмийг хязгаарлаж, үйл ажиллагааг нь зогсоосоор байна. Орос улс эвлэлдэн нэгдэх эрхийг дарангуйлах харгис төлөвлөгөөг үргэлжлүүлсээр байгаа бөгөөд өмнө нь байгаагүй хэмжээнд өсөн нэмэгдэж байгаа иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийг «гадаадын агент» эсвэл «сэжигтэй байгууллага» гэх зэрэг хаяг шошго зүүж, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох эрхийг нь хязгаарлав. Мөн ОХУ-д бүртгэлгүй гадаадын төрийн бус байгууллагуудын “үйл ажиллагааг шийтгэх” зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, тус улсаас гадуур иргэний нийгмийн бүлэгтэй хамтран ажиллах ихэнх хэлбэрийг эрүүгийн хуулиар шийтгэхээр тусгасан. Москвагийн Хельсинкийн групп, Сахаровын төв, Сова төв зэрэг хүний эрхийн тэргүүлэх байгууллагуудыг хаажээ.

Беларусь улс хүний эрхийн нэр хүнд бүхий Виасна бүлэг болон бие даасан олон тооны иргэний нийгмийн байгууллагуудыг хааж, тэргүүлэгч гишүүдийг олон жилээр хорих ял шийтгэжээ. Киргиз улс ОХУ-ын “Гадаадын төлөөлөгчдийн тухай» хуулийг загвар болгон боловсруулсан “Гадаадын төлөөлөгчдийн тухай» хуулийн төслийг батлахаар хэлэлцэж байгаа нь олон тооны төрийн бус байгууллагыг хаах аюул дагуулж байна. Молдова улсад Шанса намын гишүүдийг орон нутгийн сонгуульд нэр дэвших боломжийг дур мэдэн хязгаарлав.

Гүрж улсад Гадаадын нөлөөллийн ил тод байдлын тухай хуулийн төслийн эсрэг олон нийтийн эсэргүүцэлд үндэслэн уг хуулийн төслийг эргүүлэн татсан нь амжилтын цөөн түүхийн нэг байв.

ТАЙВАН ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ

Бүс нутгийн улс орнуудад гудамж талбайд тайван журмаар явагдаж байгаа эсэргүүцлийн жагсаалыг эрс хязгаарласан бол харин Орос болон бусад зарим улсад засгийн газрыг дэмжсэн томоохон жагсаал цуглаан зохион байгуулжээ. Хууль сахиулагчид хууль бусаар хүч албадлага хэрэглэх нь ердийн үзэгдэл болжээ. Киргизстан улс нийслэл Бишкек болон зарим бүс нутгуудад тайван жагсаал зохион байгуулахыг бүрэн хориглов. Беларусь, Казахстан улсын эрх баригчид урьд өмнө эсэргүүцлийн жагсаалд тайван замаар оролцогчдыг олж илрүүлэх, хорих ялаар шийтгэж ажиллагаа үргэлжилсээр байна.

Гуравдугаар сард болсон тайван жагсаалыг тараахын тулд Жоржиа мужийн цагдаа нар нулимс асгаруулагч хий, усан буу ашиглажээ. Туркменистанд талхны хомсдолыг эсэргүүцсэн жагсаалыг зогсоохын тулд цагдаа нар зайлшгүй шаардлага үүсгэгүй байхад, тухайн нөхцөл байдалд тохирохгүй хүч хэрэглэсэн.

Эрх баригчид эсэргүүцэл, шүүмжлэлийг дарангуйлах болон хүний эрхийн асуудлыг хэлэлцэхэд саад учруулахад ашигладаг элдэв шалтгийг эцэс болгох ёстой. Мөн шүүмжлэгчдийг шийтгэх, хүчирхийлэх явдлыг дуусгавар болгож, эсэргүүцлийн жагсаалын үеэр аюулгүй байдлын хүчнийхэн хууль

бус хүч хэрэглэхийг зогсоож, тайван жагсаал хийх эрх чөлөөг зөрчсөн хууль тогтоомжийг хүчингүй болгох, өөрчлөх шаардлагатай.

ШАШИН ШҮТЭХ, ИТГЭЛ ҮНЭМШИЛТЭЙ БАЙХ ЭРХ ЧӨЛӨӨ

Шашны цөөнхийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэх нь бүс нутгийн хэмжээнд түгээмэл байв. Исмаилитуудын эсрэг Тажикстаны дарангуйлал үргэлжилсээр байгаа бөгөөд хувийн сууцандаа хамтаараа залбирсан үйлдэлд хүртэл шийтгэл ногдуулж байна. Еховагийн Гэрчүүд Орос болон Орост эзлэгдсэн Украйны нутаг дэвсгэрт итгэл үнэмшлийнхээ төлөө шоронд хоригдсон бол хууль сахиулах байгууллагууд Беларусь дахь католик шашны санваартан болон Украин дахь Украйны үнэн алдартны сүмийн санваартан нарыг онилж байна. Узбекистанд лалын шашинтнуудыг хэт ерөнхий, тодорхой бус агуулга бүхий хэт даврагч үзэлтэй холбоотой хуулийн заалтыг үндэслэн шийтгэл ногдуулсаар байна.

Засгийн газрууд шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг бүрэн хамгаалах, хангах, баталгаажуулахад чиглэсэн хууль зүйн болон бодлогын шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай.

ЭРҮҮДЭН ШҮҮЛТ, БУСАД ЗҮЙ БУС ХАРЬЦАА

Олон оронд эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах явдал түгээмэл хэвээр байгаа бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон хүмүүс ял шийтгэлгүй өнгөрдөг. Беларусь улсад улс төрийн хэргээр хоригдож буй хүмүүсийг ганцаарчлан хорих, шаардлагатай эрүүл мэндийн тусламж үзүүлэхгүй байх зэргээр хүнлэг бус нөхцөлд ял шийтгэл эдлүүлж байна. Казахстанд 2022 оны нэгдүгээр сард болсон эсэргүүцлийн жагсаалын дараа эрүүдэн шүүлтийн улмаас хүний амь нас хөнөөсөн зургаан хэргийн тав нь 2023 оны эцэс гэхэд шүүхэд шилжсэн бол үлдсэн хэргийг нотлох баримт дутуу гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болжээ. Молдова улсад хүмүүсийг хэт олноор нь нэг дор хорих, эрүүл ахуйн шаардлага хангаагүй, эрүүл мэндийн шаардлагатай тусламж тааруу нөхцөлд цагдан хорьсоор байна. Гүржид тус улсын ерөнхийлөгч асан Михаил Саакашвилигийн биеийн байдал эрс муудсан, зохих эмнэлгийн тусламж шаардлагатай гэх хүмүүнлэгийн үндэслэлээр суллах хүсэлт гаргасан ч хүсэлтийг татгалзжээ. ОХУ-д Алексей Навальнийг хүчээр алга болгож, олон удаа дур мэдэн ганцаарчлан хорьсон.

Засгийн газрууд эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцах явдлыг нэн даруй эцэс болгож, тэдгээр гэмт үйлдэлд шударга шүүхээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлагатай.

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ, ХҮЧИРХИЙЛЭЛ

Узбекистан улсад гэр бүлийн хүчирхийллийг анх удаа гэмт хэрэгт тооцов. Гэвч дайн, “уламжлалт” болон “гэр бүлийн” үнэт зүйлсийг бэхжүүлсэн хууль тогтоомж зэрэг нь бүс нутагт жендэрт суурилсан хүчирхийлэл, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нэмэгдэхэд хүргэж байна.

Украинд өрнөж буй дайны ширүүн нөхцөлд гэр бүлийн хүчирхийллийн хэргийн

тоо түүхэн дээд хэмжээндээ хүрсэн бол Киргиз улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэр дундаа охидын эсрэг бэлгийн болон бусад төрлийн хүчирхийлэл өргөн тархсан байна. Гүрж улсад ялангуяа эрх баригч намынхан улс төрийн өрсөлдөгчдийн эсрэг сексист буюу эмэгтэйчүүдийг гутаан доромжлох үг хэллэг улам бүр нэмэгдэж байна. Азербайжанд эмэгтэйчүүд жендэрийн хүчирхийллийн янз бүрийн хэлбэр, тэр дундаа улс төрийн өшөө авахад чиглэсэн хэрэгсэлд ихээр өртөж байна.

Засгийн газрууд охид, эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийлэл, тэр дундаа жендэрийн ялгаварлан гадуурхалт, хор хөнөөл бүхий хэвшмэл ойлголттой тэмцэх, урьдчилан сэргийлэх цогц бодлогыг хэрэгжүүлэх, хохирогчдод хамгаалалт, дэмжлэг авах боломжийг хангах, холбогдох гэмт хэрэгт ял шийтгэлгүй үлдэх асуудлыг шийдвэрлэх ёстой.

ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН ЗӨРЧИЛ

ОХУ-ын Украины эсрэг түрэмгийллийг дайны гэмт хэрэг хэмээн тэмдэглэж байна. ОХУ-ын цэргийн хүчнийхэн хүн ам суурьшсан газар нутаг, иргэний эрчим хүч, үр тарианы экспортын дэд бүтцийг ялгахгүйгээр дайралт хийх нь түгээмэл байна. Орос болон Украины цэргийн хүчнийхэн энгийн иргэд болон иргэний байгууламжийг ялгах боломжгүй, түүнчлэн энгийн иргэдийн хувьд урт хугацааны эрсдэлтэй хор дагаврыг бүхий кластер бөмбөгдөгчийг ашигласаар байна. Украин бол энэ салбарт дэлхийн хамгийн их нөөцтэйд тооцогддог. ОХУ болон Оросын эзэлсэн Украины нутаг дэвсгэрт олзлогдосдыг эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах явдал өргөн тархаж байна. Москвагийн шүүх Украины хүний эрхийн хамгаалагч Максим Буткевичийг тэрээр үйлдэх ямар ч боломжгүй дайны гэмт хэрэг үйлдсэн хэмээн үзэж 13 жилийн хорих ялыг хэвээр үлдээв.

Азербайжан цэргийнхэн Уулын Карабахыг эзлэн авсны дараагаар Азербайжан болон Арменийн цэргийн хүчний аль аль нь энгийн иргэд болон иргэний байгууламжийг ялгахгүйгээр халдлага үйлдэх, олзлогдосдыг эрүүдэн шүүх, алах гэх зэргээр олон улсын хүмүүнлэгийн хуулийг зөрчсөн боловч тэдгээр үйлдлийг мөрдөн шалгах ажиллагаанд ямар ч ахиц гарсангүй.

Дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн бүхий л тохиолдлыг нийтлэг шүүхийн харьяаллын зарчмын дагуу шударга, хараат бусаар мөрдөн шалгах ёстой.

ШУДАРГА БУСААР ШҮҮХ АЖИЛЛАГАА

Улс орнууд шүүхийн тогтолцоог хүний эрхийг хамгаалах бус, харин дарангуйлах зорилгоор ашиглаж байна. ОХУ-ын шүүхүүд хэт яллах талыг барьж шүүгдэгч нартай харьцдаг бөгөөд терроризм, хэт даврах үзэл, эх орноосоо урвах гэх зэрэг хэргийг шийдвэрлэхдээ шүүх хурлыг олон нийтэд хаалттай явуулав.

Беларус улс шүүх эрх мэдлийн байгууллагыг хүний эрх хамгаалагчид, хуульчдын шүүмжлэл, эсэргүүцлийг дарах зэвсэг болгон ашиглаж байна. Светлана Цихновская, Павел Латушка, Мария Мароз, Волха Кавалкова, Шархей Дилевски нарын эзгүйд тэдэнд хилс хэрэгт удаан хугацаагаар хорих ял оногдуулсан бол Наста Лойка долоон жилийн хорих ялаар шийтгүүлсэн. Казахстанд алдарт тамирчин Марат Жыланбаевыг тайван замаар эсэргүүцсэнийх нь төлөө долоон жилийн хорих ялаар шийтгэв. АНУ-ын Төрийн департаментаас Гүржийн дөрвөн шүүгчийг албан тушаалаа урвуулан ашиглаж шүүхийн тогтолцоонд хохирол учруулах авлигын хэрэгт буруутган хориг тавьжээ.

Тажикстан улс террорист байгууллагуудыг хэт өргөн хүрээнд тодорхойлж түүний эсрэг шуурхай арга хэмжээ авах, зохих журмын дагуу хязгаарлалт хийх боломжтой

болсонд НҮБ санаа зовниж байгаагаа илэрхийлэв. Герман улс орогнол хүсэгч Абдуллохи Шамсиддиныг Тажикстан руу албадан гаргасны дараа тэрээр долоон жилийн хорих ялаар шийтгүүлсэн бөгөөд уг ялаар шийтгэхээс өмнө түүнийг хүчээр алга болгосон юм. Узбекистан улсын Каракалпакстан хотод 2022 онд өрнөсөн олон нийтийн эсэргүүцлийн жагсаалд оролцсон олон арван хүнийг улс төрийн хэргээр шударга бус шүүхээр ялласан.

ХҮҮХЭД, АХМАД НАСТНУУДЫН ЭРХ

Украины эсрэг ОХУ-ын дайн нь бүхий л украинчуудад зовлон зүтгүүр, асар хүнд гарз хохирол учруулж байгаа бөгөөд энэ нь хүүхэд, хөгшин хүмүүст илүү эмзэг тусаж байна.

НҮБ-ын 11 дүгээр сард гаргасан мэдээллээр 2022 оны хоёрдугаар сараас хойш хамгийн багадаа 569 хүүхэд амиа алдаж, 1229 гаруй хүүхэд шархаджээ. ОХУ-ын эзэлсэн нутаг дэвсгэрээс ОХУ-д хууль бусаар шилжүүлсэн хүүхдүүдийн тоо хэдэн зуу, магадгүй мянгаар тоологдож байна. Гуравдугаар сард ОУЭШ-ээс Ерөнхийлөгч Владимир Путин, Хүүхдийн эрхийн комиссар Мария Львова-Белова нарыг цэргийн гэмт хэрэгт буруутай хэмээн баривчлах шийдвэр гаргасан.

Зэвсэгт мөргөлдөөнд ахмад настнууд харьцангуй ихээр өртөж байгаа бөгөөд амь насаа алдаж, шархадсан ахмад настнуудын тоо энгийн иргэдээс өндөр байна. Нүүлгэн шилжүүлсэн хүмүүс гэр бүлээрээ тусдаа хувийн орон сууцанд орохоор тэмцэлдсээр байсан бөгөөд түр хамгаалах байрууд ахмад настан, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бие махбодын хувьд нэвтрэх боломжгүй хэвээр байв.

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ

Бүс нутаг дахь цэргийн мөргөлдөөн эдийн засаг, нийгмийн эрхэд нөлөөлсөөр байна. Азербайжан улс есдүгээр сард довтолгоо хийхээс өмнө есөн сарын турш Уулын Карабахыг Арментай холбосон зам болох Лачин коридорыг хаасны улмаас хоол хүнс, эм тариа, шатахуун зэрэг наад захын хэрэгцээт бараа бүтээгдэхүүний хомсдол үүсэж, улмаар салан тусгаарласан бүс нутагт хүмүүнлэгийн хямрал нүүрлэжээ.

Есдүгээр сард ОХУ даяар болон Украины эзлэгдсэн нутаг дэвсгэрт ахлах сургуулийн сурагчдад Орос, Зөвлөлтийн эрх баригчдын хүний эрхийн түүхэн баримтыг цайруулахыг оролдсон түүхийн шинэ «нэгдсэн» сурах бичгүүдийг тарааж сургуулийн хүүхдүүдийг хууль бусаар сургах ноцтой оролдлого хийгдсэн. ОХУ-д эзлэгдсэн нутаг дэвсгэрт байгаа хүүхдүүдэд хэлмэгдүүлэлтээс зайлсхийхийн тулд Украины сургалтын хөтөлбөрийг нэр төдий зааж байна.

Засгийн газар хүн бүрийн зохистой амьдралын түвшин, чанартай боловсрол эзэмших эрхийг хангах ёстой.

Засгийн газрууд хүн бүрийн амьжиргааны зохистой түвшинд аж төрөх, чанартай боловсрол эзэмших эрхийг хангах шаардлагатай

ДҮРВЭГСЭД, ЦАГААЧДЫН ЭРХ

Нүүн шилжиж байгаа хүмүүс бүс нутаг даяар зовлонд нэрвэгдсээр байна. Эргэн очсон тохиолдолд ноцтой үр дагаварт өртөх цагаачдыг Беларусын эрх баригчид Европын Холбооны хил дагуу хүч хэрэглэн албадан гаргасан бол Оросын эрх баригчид цагаачдыг цэргийн албанд татахын тулд хууран мэхлэлт, дарамт шахалт үзүүлжээ. Уулын Карабахаас Армени руу дүрвэсэн 100 мянга гаруй армян үндэстэн эдийн засгийн бэрхшээлтэй тулгарч, эргэн ирэх эсэх нь тодорхойгүй байв

Засгийн газрууд дарангуйлал, хүний эрхийн зөрчлөөс дайжиж байгаа хүн бүрийн аюулгүй байдал, олон улсын хамгаалалт хүртэх, хүний эрхийн ноцтой хүчирхийлэлд өртөх нөхцөлд хэнийг ч нутаг буцаахгүй байх баталгааг хангах шаардлагатай.

ЭРҮҮЛ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Украинд өрнөж буй Дэлхийн хоёрдугаар дайны хэв маяг бүхий цэргийн ажиллагаа болон бүс нутгийн түвшинд чулуужсан түлш үйлдвэрлэгч, томоохон ялгаруулагч улс орнууд байгаль орчныг асар ихээр сүйтгэж, бохирдуулж байна.

Украин дахь Оросын түрэмгийлэл нь агаар, ус, газрын бохирдол, хяналтгүй их хэмжээний аюултай хог хаягдлыг бий болгосон. Оросын цэргийн хүчний санаатай үйлдсэн хэмээн таамаглаж цэргийн ажиллагааны хүрээнд Каховка далан сүйрсэн нь Украины хилийн гадна удаан хугацаанд үргэлжлэх экологийн ноцтой үр дагавар бүхий бохирдлыг бий болгосон.

Ихэвчлэн чулуужсан түлш шатааснаас үүдсэн агаарын бохирдлын улмаас хүний эрүүл мэнд хохирч байна. Ийм бохирдлын улмаас Казахстанд жил бүр 10,000 гаруй хүн нас барсан бол Беларусьт цус харвалт, зүрхний өвчнөөр нас барсан хүмүүсийн 18 хувь нь энэ төрлийн бохирдлын улмаас нас барсан гэсэн тооцоо бий. Киргизийн нийслэл дэлхийн хамгийн их бохирдолтой хотуудын нэг байв.

Бүс нутаг даяар байгаль орчныг хамгаалагч хүмүүс эрсдэлд өртөв. Арменид алт олборлох төслийг эсэргүүцсэн идэвхтнүүдийн эсэргүүцэл, шүүмжлэлийн улмаас бизнест учруулсан их хэмжээний санхүүгийн нөхөн төлбөр шаардсан нэхэмжлэлийг төсөл хэрэгжүүлэгч байгууллага шүүхэд гаргажээ. ОХУ-д байгаль орчны томоохон хоёр ТББ-ыг “сэжигтэй” хэмээн зарлаж, тус улсаас гарахыг хориглосон.

Засгийн газрууд уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын эрс тэс нөхцөл байдлын эрсдэл, нөлөөллөөс хувь хүн, олон нийтийг хамгаалах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх, ялангуяа уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хор хохирлыг бууруулах арга хэмжээг хангалттай хэмжээнд авч хэрэгжүүлэхийн тулд олон улсын тусламж, хамтын ажиллагааг эрэлхийлэх шаардлагатай.

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

Украин улс хамтран амьдрагч иргэдийн тухай хуулийн төсөлд ижил хүйстэн хосуудын харилцааг зохицуулахаар тусгаж хуулийн төслийг өнгөрсөн гуравдугаар сард бүртгэсэн. Гэвч уг хуулийн төсөлд ижил хүйстэн хосууд хүүхэд үрчлэн авахыг хориглодог асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тусгаагүй байна.

ОХУ трансфоби буюу трансгендэр хүмүүсээс айх, тэдгээрийг үзэн ядах, үл ойлгож ялгаварлах шинэ хуулийг баталж, ЛГБТИ хүмүүсийн эрхтэй холбоотой олон нийтийн аливаа үйл ажиллагаа, тухайлбал «олон улсын ЛГБТ хөдөлгөөн»-ийг «хэт даврагч» хэмээн тодорхойлж хориглов. Төв Ази болон бусад орнуудад жендэрийн эрхэд ухралт гарч, Киргиз улс “гэр бүлийн үнэ цэнийг үгүйсгэх” мэдээлэл, “уламжлалт бүс бэлгийн харилцаа”-г сурталчлахыг хуулиар хориглох нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулсан бол Туркменистан, Узбекистан улс харилцан тохиролцсон ижил хүйстнүүдийн бэлгийн харилцааг гэмт хэрэгт тооцсон хэвээр байна.

Засгийн газрууд ижил хүйстнүүдийн зөвшилцсон бэлгийн харьцааг гэмт хэрэгт тооцохгүй байх, ижил хүйстнүүдийн гэрлэлтийг үгүйсгэх хууль эрх зүйн саадыг арилгах зэргээр ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхсан хууль, бодлого, үйл ажиллагааг хүчингүй болгох ёстой.

БАРУУН, ТӨВ, ЗҮҮН ӨМНӨД ЕВРОП

2023 онд Европын олон орны улс төрчид эмэгтэйчүүдийн болон ЛГБТИ хүмүүсийн эрх, шилжилт хөдөлгөөн, уур амьсгалын шударга ёс, Израйл болон Палестины эзлэгдсэн нутаг дэвсгэрт болсон аймшигт үйл явдлуудын талаар нийгмийн туйлшралыг гааруулав. Засгийн газрууд хүний эрхийг нийгмийн бүлүүдийг гутаан доромжлох, иргэний орон зайд үндэслэлгүй хязгаарлалт тогтоох, мөн уур амьсгалын эсэргүүцэгчид, шүүмжлэлт, өөр үзэл санаа бүхий хүмүүс, ялангуяа Палестинчууд, лалын шашинтнууд болон бусад арьс үндсээр ялгаварлан гадуурхагдсан хүмүүсийн хамтын нэгдлийг онилох зорилгоор ашиглаж байна.

Системт байдлаар арьс үндсээр ялгаварлан гадуурхах нь хүний эрхийг зөрчиж, амь насыг хохироосон хэвээр байв. Бүс нутгийн улс орнууд Африк, Ойрх Дорнод, Азиас гаралтай хүмүүсийг арьс үндсээр ялгаварлан гадуурхах бодлого баримталж байгаагийн уршгаар далайн болон хуурай газрын хил дээр хүмүүс амь насаа алдаж, хохирол амссаар байна. Засгийн газрууд өнөөг хүртэл үргэлжилсээр байгаа цыгануудыг ялгаварлан гадуурхах, ялгаварлан тусгаарлах явдлыг шийдвэрлэхэд ахиц гаргаж чадсангүй. Улс орнууд арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг арга хэмжээг хэрэгжүүлж чадаагүйн зэрэгцээ арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзлийг улс төрийн мөлжлөгт ашиглаж байгаа нь христ болон лалын шашинтнуудын эсрэг арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзлийг огцом нэмэгдэхэд хүргэсэн.

Жендэрт суурилсан хүчирхийлэл, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн асуудалд ахиц дэвшил, ухралтын аль аль нь гарлаа. Ажиглалт, тандалтын технологид шилжсэн хэвээр байна. Нийгмийн эмзэг бүлгийнхэн, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн хамгаалал хүртэж чадахгүй байна.

Давхар стандарт буюу ялгамжтай хэм хэмжээ үйлчилж байгаа нь үг, бодлого, үйл ажиллагаанаас тодорхой харагдаж байна. Израйлын эсрэг Палестины хүний эрхийн төлөөх эв нэгдлийн хөдөлгөөнд тавьсан хязгаарлалт; чулуужсан түлшний хэрэглээ, үйлдвэрлэлийг үргэлжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг эсэргүүцэгчдийг нухчин дарж байгаа хэрнээ COP28 дээр хэлэгдсэн сайхан үгс; Европт хүний эрхийн асуудал ухралт явагдсаар байгаа хэрнээ бүс нутгаас гадуурх улс орнуудыг шүүмжилж байгаа зэрэг нь давхар стандартын тодорхой жишээ юм.

ДҮРВЭГСЭД, ЦАГААЧДЫН ЭРХ

ЕХ-ны гишүүн улс орнууд арьс үндсээр ялгаварлан гадуурхах ноцтой үр дагавар бүхий бодлогыг хэвээр хадгалсаар байгаа бөгөөд энэ талаар ЕХ-ны хүрээнд үүрэг хариуцлагаа хуваалцах талаар багахан ахиц дэвшил гарсан. ЕХ-ны орогнолын асуудлаар шинэтгэл хийх хэлэлцээ нь аюулгүй байдлыг эрэлхийлж буй хүмүүсийн хамгаалалтыг бууруулж, зовлон зүдүүрийг нэмэгдүүлэх агуулга руу чиглэв. Улс орнууд аюулгүй, хууль ёсны маршрут тогтоож чадаагүй бөгөөд эсрэгээр хуурай газрын болон далайн хил дээр дүрвэгч, цагаачдын эсрэг хүчирхийлэл үйлдэж, аюул эрсдэлд оруулав. Грекийн Пилосын ойролцоо усан онгоц сүйрсэн зөвхөн нэг тохиолдлын улмаас арьс үндсээр ялгаварлан гадуурхагдсан 600 гаруй хүн, түүний дотор хүүхдүүд нас барсан бол Африк, Ойрх Дорнод, Азиас ирж буй бусад хэдэн зуун хүн хүчирхийлэлд өртөж, Европын хилийн дагуу дүрвэгсэд, цагаачдыг бөөнөөр нь албадан нутаг буцаах ажиллагаа олон жил үргэлжлэн өдөр тутмын ердийн үзэгдэл болов.

Латви, Литва улс дүрвэгсдийг бөөнөөр нь нутаг буцаан зохицуулалтыг үндэсний хууль тогтоомжид нэвтрүүлсний дараа Европын Комиссоос тэдний эсрэг урьдчилан

хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлж чадсангүй. Хилийн хүний эрхийн зөрчилд холбогдогч нарт хариуцлага хүлээлгэдэггүй байдал өргөн хэвээр байна. 2022 онд Мелилла болон Мароккогийн хооронд дүрвэгсдийг хууль бусаар хөөсөн, амь насыг нь бүрэлгэсэн, эрүү шүүлт тулгасан хэргийг Испани улс үр дүнтэй мөрдөн шалгаж чадсангүй.

Европын зарим орнууд Афганистан дүрвэгсдийн аюулгүй байдлыг эрэлхийлэх эрхийг хангаж чадсангүй. Герман улс сард 1000 Афган иргэнийг хүлээн авах хүмүүнлэгийн хөтөлбөрт 100 хүрэхгүй хүн хамруулжээ. Дани, Финлянд, Швед улсууд Афганистаны охид, эмэгтэйчүүдэд дүрвэгсдийн статусыг анхны шалгалтаар хүлээн зөвшөөрөх эерэг алхам хийсэн.

Чех, Кипр, Грек, Герман улсад дүрвэгсэд болон цагаачдын эсрэг халдлага үйлдэгджээ. Улс төрчид сонгуулийн үеэр дүрвэгсэд болон цагаачдыг ялгаварлан гадуурхсан, арьс өнгөөр ялгаварласан үзэл бүхий үг хэллэг ихээр хэрэглэж байгаа нь Турк улсад явагдсан сонгуулиас тодорхой харагдана.

Европын улсууд хүний эрхийг үл тоомсорлон хилийн хяналтыг хэрэгжүүлэхдээ ялгавартай хандсаар байв. Итали улсын Албани улстай байгуулсан орогнол хүсэгчдийг оффшорын журмаар шийдвэрлэх гэрээг илүү олон улс байгуулахаар эрэлхийлж байна. Харин ЕХ хүний эрхийг зөрчих эрсдэлтэй Тунис улстай хийх хэлэлцээрийг ахиулсан. Мянга мянган дүрвэгсдийг нутаг буцаасан Турк улстай хамтын ажиллагаа үргэлжилсээр байна. Шүүхийн маргаанд ялагдал хүлээсэн хэдий ч Их Британийн засгийн газар орогнол хүсэгчдийн орогнол хүссэн өргөдлийг нь шийдвэрлэхээр Руанда руу шилжүүлэх төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхээр зорьж байна.

Засгийн газрууд арьс үндсээр ялгаварлан гадуурхах бодлогоо зогсоох ёстой. Харин үүний оронд бодлого, үйл ажиллагаа нь дүрвэгсэд болон цагаачдын амьд явах эрхийг хамгаалах, хүндэтгэх, биелүүлэх, түүнчлэн хил дээр орогнол хүсэх хүний эрхийг хангаж, аюулгүй, хууль ёсны арга замыг бий болгох шаардлагатай.

ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

Латви улс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай Европын зөвлөлийн конвенцийг соёрхон баталсан бол Хойд Македон улс үндэсний хууль тогтоомжийг уг гэрээнд нийцүүлжээ. Хорват улс жендэрийн шинжид үндэслэн эмэгтэйчүүдийг хөнөөсөн нь бие даасан гэмт хэрэг болно хэмээн мэдэгдэв. Швейцар улс хүчингийн гэмт эрхийн тодорхойлоход зөвшилцөлд үндэслэсэн байх шалгуурыг баталсан бөгөөд Нидерландад ийм тодорхойлолтыг батлахад ахиц гарсан.

Гэвч хэд хэдэн улсад охид, эмэгтэйчүүд эсрэг жендэрт суурилсан хүчирхийлэл өндөр хувь хэмжээтэй байгаа бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх төрийн арга хэмжээ хангалтгүй байна. Албани, Австри, Грек, Итали, Серби, Испани, Турк улсад хийсэн мониторингийн үр дүн хэдэн зуун эмэгтэйг жендэрт үндэслэн хөнөөсөн талаар мэдээлжээ. Босни Герцеговина болон Болгар улсад хүн амины хэргийн дүрс бичлэгийг шууд цацсан нь эсэргүүцлийн жагсаал цуглааныг өдөөсөн бол Болгарт хэрэг үйлдсэн этгээдэд хөнгөн шийтгэл ногдуулсан нь эсэргүүцлийн жагсаалд хийхэд хүргэсэн.

Финландад жирэмсний эхний 12 долоо хоногт хүсэлтээр үр хөндөлт хийхийг зөвшөөрсөн хууль хүчин төгөлдөр болж, Испанид эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр 16-17 насны хүүхдүүд үр хөндөлт хийлгэхийг зөвшөөрсөн хуулийн төслийг баталсан. Гэвч хэд хэдэн улс үр хөндөлтийг хязгаарласан хэвээр байна. Польшид үр хөндөлтийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзсаны улмаас нэг эмэгтэй нас баржээ. Хорват, Ирланд, Итали, Умард Ирландад эрүүл мэндийн ажилтнууд үр хөндөлт хийхээс өмнө үйлдлээ ухамсарласан эсэх талаарх нөхцөлийг байнга сануулдаг. Австрийн зарим хэсэгт үр хөндөлтийг эрүүл мэндийн тогтолцооноос хассан бол Чех улс Европын холбооны

гишүүн бус иргэдэд энэ төрлийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзжээ. Мальтад үр хөндөлтийг хориглосон хуульд өөрчлөлт оруулсан боловч үр хөндүүлэх боломж маш хязгаарлагдмал хэвээр байв. Андорра улс үр хөндөх эрхэд бүрэн хориг тогтоосон бүс нутгийн цорын ганц улс юм.

Засгийн газрууд жөндөрт суурилсан бүхий л хэлбэртэй шуурхай тэмцэж, суурь үндсийг нь шийдвэрлэх шаардлагатай.

ХУВИЙН НУУЦТАЙ БАЙХ ЭРХ

Швейцарын хэд хэдэн хот, кантон олон нийтийн газарт нүүр царайг таних технологийг хориглосон. Харин Франц улсын баталсан шинэ хуулиар 2024 оны Олимпод олон нийтийн биометрийн тандалт хийхийг зөвшөөрсөн. Австри, Швейцар, Герман зэрэг олон оронд Предатор(Predator) тагнах программыг худалдаалдаг компаниудын Интеллекса(Intellexa) Холбоотнуудыг Эмнести Интернэшнл нийтэд ил болгосон бөгөөд Берлиний мэдээллийн сайт, Европын байгууллагууд, судлаачдын эсрэг Predator ашиглаж байсныг тогтоосон. Испанид 65 хүн (Pegasus)Пегасус тагнах программын халдлагад өртсөн бөгөөд тэдний дийлэнх нь Каталонид амьдардаг юм.

ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХ, ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ АЛДАГДУУЛАХ

Унгар, Польш, Турк улсад шүүхийн хараат бус байдал алдагдсаар байна. Унгар улс шүүхийн эрх мэдлийг хязгаарлах арга хэмжээ авсан. Польш улсын засгийн газар асуудалд шүүмжлэлт байр сууринаас ханддаг шүүгчдийг онилов. Туркийн давж заалдах шатны шүүх Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхээ хэтрүүлсэн үндэслэлээр түүнийг шийдвэрийг хэрэгжүүлэхээс татгалзав.

Засгийн газрууд тандалтын нийгэм рүү шилжиж байгаа үйл явцыг зогсоож, шударга шүүхээр шүүлгэх эрхийг хүндэтгэн, шүүхийн хараат бус байдлыг алдагдуулах явдлыг зогсоох ёстой.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Бүс нутгийн улс орнуудад сэтгүүлчийн эсрэг халдлагууд бүртгэгдсэн. Турк улсад сэтгүүлчдийг терроризмтой холбоотой хилс хэрэгт холбогдуулан баривчлах, цагдан хорих үйл ажиллагааг үргэлжлүүлсээр байна.

Австри, Болгар, Хорват, Грек, Хойд Македон, Серб зэрэг улсад улс төрчид, бизнес эрхлэгчид сэтгүүлчид, эсхүл хүний эрхийн идэвхтнүүдийн дуу хоолойг нухчин дарахын тулд олон нийтийн оролцооны эсрэг стратегийн зарга маргааныг ашигласаар байна. Босни Герцеговина улсын Бүгд Найрамдах Серпскаяд гүтгэлгийг гэмт хэрэгт тооцдог бол харин Болгар улс төрийн албан тушаалтнуудын нэр төрд халдсан тохиолдолд оногдуулдаг торгуулийг бууруулж, Хорват улс олон нийтийн оролцооны эсрэг стратегийн зарга маргааныг урьдчилсан журмаар хэрэгсэхгүй болгох төлөвлөгөөг баталсан.

Бүс нутгийн хэмжээнд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, тухайлбал Израйлын Газын зурвас дахь бөмбөгдөлтийн кампанит ажлыг шүүмжилж, Палестины хүний эрхийг дэмжих зэргийг зүй бусаар хязгаарлахад чиглэсэн арга хэмжээг хуульчлах, эсхүл хуулийн төсөл боловсруулах ажиллагаа хийгдсээр байгаа бөгөөд ингэхдээ хуулийн хязгаарлалт хамаарахгүй байх цөөн тооны нөхцөлийг тусгажээ.

ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал гүнзгийрэх тусам тайван жагсаал, цуглаан нэмэгдэж байгаа бөгөөд үүний эсрэг эрх баригчид хүчирхийллийн хариу арга хэмжээ авсаар байна. Иргэний үл захирагдахуйн тайван жагсаал, цуглаанд оролцсон уур амьсгалын өөрчлөлтийг эсэргүүцэгчдийг олноор нь баривчилж, хүнд гэмт хэрэг болон гүтгэх гэмт хэрэгт буруутган яллаж байна.

Хэд хэдэн улс хуран цуглах эрхэд хэт хязгаарлалт тогтоосон. Нидерландын цагдаа нар иргэний үнэмлэхийг шалгах хэрэгслийг жагсагчдыг ажиглах, тандах зорилгоор хууль бусаар ашигласан. Франц, Итали, Серби, Турк зэрэг улсад хууль сахиулах байгууллагууд хүч албадлагыг хууль бусаар хэрэглэхээс гадна ялгаварлан гадуурхаж байна.

Палестинчуудтай эв санааны нэгдэлтэй байгаагаа илэрхийлсэн эсэргүүцлийн жагсаалд улс орнуудын засгийн газар хууль бус хязгаарлалт тавьсан. Австри, Франц, Герман, Унгар, Польш, Швейцар болон бусад улсууд нийтийн хэв журам, үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулна гэсэн хэт ерөнхий үндэслэлээр энэ төрлийн жагсаал цуглаан хийхийг урьдчилан хоригложээ. Хэвлэл мэдээлэл болон улс төрчид Палестинчуудыг хүнлэг бусаар илэрхийлэх үг хэллэгийг ашиглаж, арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзлийг түгээн дэлгэрүүлж, лалын шашинтнуудыг террористуудтай холбосоор байна.

Франц улс тайван жагсаалыг хориглохын тулд терроризмын эсрэг хууль тогтоомжийг ашиглаж, жагсагчдыг дур зоргоор баривчилжээ. Бахархлын жагсаалын үеэр Туркийн цагдаа нар жагсаал, цуглаанд бүрэн хориг тавьж, шаардлагагүй хүч, албадлага хэрэглэж, 224 хүнийг баривчилжээ. Их Британи улс цагдаагийн эрх мэдлийг өргөжүүлэх, тэр дундаа эсэргүүцлийн жагсаалыг хориглох тушаал гаргах, иргэний үйл ажиллагааг зогсоох шийдвэр гаргах бүрэн эрхийг цагдаа нарт олгосон хуулийн төслийг баталлаа.

ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Франц улс хэд хэдэн төрийн бус байгууллагыг хуульд заасан шударга журмыг баримтлахгүйгээр татан буулгах ажиллагааг үргэлжлүүлсээр байна. Турк улс төрийн бус байгууллагуудын хөндлөнгийн аудитыг улам эрчимжүүлсээр байна. Босни Герцеговина улсын Бүгд Найрамдах Сербскаяд гадаадын санхүүжилттэй төрийн бус байгууллагуудын бүртгэлийг бий болгох хуулийг баталлаа. Унгар улсад засгийн газар төрийн бус байгууллагуудын гаднаас авах санхүүжилтийг хязгаарлах шинэ хуулийг нэвтрүүлсэн.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван хуран цуглах эрх чөлөөг хэрэгжүүлэх орон зай нь төрийн халдлагаас хамгаалагдсан байх ёстой.

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИД

Эмэгтэйчүүд болон цагаачдын эрхийн чиглэлээр ажилладаг хүний эрхийг хамгаалагчид дарамтын бай болсоор байна. Андорра улсад нэгэн хүний эрхийн идэвхтнийг үр хөндөлтийн хоригийн эсрэг үг хэлснийхээ төлөө их хэмжээний торгууль ногдуулжээ. Польш улсад нэгэн эмэгтэйд үр хөндөлтийн эм авахад тусалсны төлөө Жастина Выдржинскад найман сар нийтэд тустай ажил хийх шийтгэл ногдуулжээ. Грек улсад цагаачдын эрхийг хамгаалагч Сара Мардини, Сеан Биндер нарыг дөрвөн гэмт хэрэг үйлдсэн хэрэгт буруутгаж байгаа юм. Латви улсын эрх баригчид Беларусийн хил дээр хүмүүнлэгийн ажил хийсэн хоёр хүний эрх

хамгаалагчийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгэв. Турк улс Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрийг үл харгалзан Осман Кавалад оноосон ялыг хэвээр үлдээв.

Засгийн газар хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалж, тэдний үйл ажиллагааг гутаан доромжилж, гэмт хэрэг хэмээн үзэхийн оронд тэдний чухал үүргийг хүлээн зөвшөөрөх ёстой.

АРЬС ҮНДСЭЭР ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ

Хууль сахиулах байгууллагууд арьс үндсээр ялгаварлан гадуурхах нь түгээмэл хэвээр байв. Цагдаагийнхан шалгалт явуулахдаа ялгаварлан гадуурхдаг болохыг Францын Төрийн зөвлөлөөс хүлээн зөвшөөрсөн ч, үүний эсрэг арга хэмжээ авсангүй. Нидерландын хилийн цагдаа нар арьс үндсээр ялгаварлан гадуурхсан хэрэгт буруутай болох нь тогтоогджээ. Лондон хотын цагдаагийн газарт институцийн шинжтэй ялгаварлан гадуурхалт нүүрлэсэн байгааг тайланд дурджээ.

Герман улсад үзэн ядалтын гэмт хэргийн гаралт өндөр түвшинд хүрчээ. Европын хүний эрхийн шүүхээс Босни Герцеговиныг сонгуулийн ялгаварлан гадуурхсан дүрэмд дахин буруутгав. Латви, Литва улсуудад Оросын зарим иргэд оршин суух зөвшөөрөлгүй болжээ.

Цыганууд ялгаварлан гадуурхах, ялгаварлан тусгаарлах, нийгмээс гадуурхагдсан хэвээр байна. Европын Нийгмийн эрхийн хороо Итали улсыг цыгануудын орон байртай байх эрхийг зөрчсөн хэмээн үзсэн бол Словакийн шүүх цыган сурагчдыг ялгаварлан тусгаарласан анги нь ялгаварлан гадуурхалт хэмээн шийдвэрлэжээ. Болгарын эрх тэгш байдлын байгууллага цыгануудыг усан сан руу оруулахыг хориглосон хэргийг шалгажээ. Хойд Македон улсад нэгэн цыган эр иргэний үнэмлэхгүйн улмаас эмнэлгийн тусламж, эмчилгээ авч чадалгүй нас барсан бол Румынд жирэмсэн дүлий цыган эмэгтэйд эмнэлгийн тусламж үзүүлэхээс татгалзсаны улмаас тэрээр зам дээр амаржжээ.

Францад лалын шашинт эмэгтэйчүүдийн спорт, боловсролын үйлчилгээнд хязгаарлалт тогтоосон хэвээр байна. Израйл болон Палестины эзлэгдсэн нутаг дэвсгэрт аймшигт үйл явдлууд өрнөсний дараа еврей болон лалын шашинтнуудын эсрэг ялгаварлан гадуурхсан үг хэллэг, үзэн ядалтын гэмт хэрэг бүс нутаг даяар нэмэгджээ.

Турк улсад 2 дугаар сард болсон газар хөдлөлтийн дараа энгийн иргэд болон төрийн байгууллагууд эрэн хайх, аврах ажиллагаанд арьс үндсээр алагчлах хүчирхийлэл үйлдэж, цагаачид болон дүрвэгсдийг онилох болов.

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

Латви ижил хүйстнүүдийн хамтын амьдралыг хүлээн зөвшөөрсөн бол Литва үүнийг хүлээн зөвшөөрөөгүй хэвээр байна. Европын шүүх Болгар, Румын улсыг ижил хүйстэн хосуудыг хүлээн зөвшөөрөхгүй байгааг буруутгав.

ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхах явдал үргэлжилсээр байна. Хорват, Хойд Македон зэрэг улсад бахархлыг жагсаалд оролцогчдод төрийн албан хаагчид болон хувь хүмүүсийн заналхийлж, гадуурхсан үг хэллэгтэй тулгарчээ. Норвегийн цагдаа нар ЛГБТИ хүмүүсийн цуглардаг газрууд хүчирхийллийн халдлагад өртөх эрсдэлтэй байгааг тогтоожээ. Турк улсад улс төрчид ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхсан үг хэллэг ашигласан.

Унгар улсын суртал ухуулгын хууль нь ЕХ-ны шүүхэд маргаантай байгаа хэдий ч тус улсын эрх баригчид энэхүү хууль тогтоомжийг зөрчсөн номын дэлгүүрийг торгож, Хэвлэл мэдээллийн зөвлөл Бахархалын жагсаалын талаар телевизээр сурталчилгаа

явуулахыг хоригложээ. Европын хүний эрхийн шүүхээс Литви улсыг ижил хүйсийн харилцааг харуулсан номд цензур тавьсан хэмээн буруутгав.

Трансжендэр хүмүүсийн эрхэд ахиц дэвшил, бас ухралт ч гарлаа. Герман улс трансжендэр, гей, бисексуал эрчүүдийг цусаа хандивлахад нь ялгаварлан гадуурхдаг явдлыг цуцалсан. Түүнчлэн, бүртгэлийн байгууллагын мэдүүлгийн маягтад трансжендэр, нонбайнари, интерсекс хүмүүсийг бие даан тодорхойлох боломжийг олгосон Өөрийгөө тодорхойлох тухай шинэ хууль Парламентаар хэлэлцэгджээ. Финландад өөрийгөө тодорхойлох эрхийг насанд хүрэгчид өргөдөл гаргах журмаар шийдвэрлүүлэх боломжтой. Испани улсын шинэ хуулиар эрүүл мэндийн үйлчилгээ авах, өөрийн жендэрийг тодорхойлох эрхийг баталгаажуулсан. Гэвч Болгар улс трансжендэр хүмүүсийн жендэрийг хүлээн зөвшөөрөх явдлыг зогсоож, Их Британийн засгийн газар Шотландын Жендэрийг хүлээн зөвшөөрөх талаарх шинэчлэгдсэн хуулийг гацаав.

Засгийн газрууд еврей, мусульман, хар арьстан, цыган, ЛГБТИ хүмүүсийн эсрэг тогтолцооны ялгаварлан гадуурхалтыг бодитоор шийдвэрлэх ёстой.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ

Финланд улсын засгийн газар нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бууруулж, эмийн хэрэглэгчийн төлбөр, татварыг нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаагаа зарласан бөгөөд үүний үр дагавар нийгмийн хамгийн эмзэг бүлгийнхэнд илүү хүндээр тусав. Европын Нийгмийн хорооноос Грекийн эсрэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэмнэлтийн горимыг танах тухай гомдлыг хүлээн авч цаашид шалгах боломжтой гэж үзжээ. Словени улс Урт хугацааны тусламж үйлчилгээний тухай хуулийг баталсан ч эмч нарын хомсдолд орсон.

Дани, Финлянд улсууд нийгмийн халамжийг танаж байгаагаа зарлав. Франц, Ирланд, Португалид орон гэргүй хүмүүсийн тоо дээд хэмжээнд хүрчээ. Испани улс орон сууцны эрхийн тухай хуулийг баталсан ч эдийн засгийн хувьд эмзэг бүлгийн иргэдийг нүүлгэн шилжүүлэлтээс хамгаалж чадсангүй. Сербид нэвтрүүлсэн нийгмийн халамжийн хагас автоматжуулсан шинэ систем нь олон мянган хүн нийгмийн халамжийн чухал тусламж авах боломжоо алдаж байгаа бөгөөд цыган болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст илүү хүндээр нөлөөлсөн.

Хоёрдугаар сард болсон газар хөдлөлтийн дараа Туркийн засгийн газрын авсан арга хэмжээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалахад хангалтгүй байв.

Засгийн газрууд хүмүүсийн эдийн засаг, нийгмийн эрхийг ялгаварлан гадуурхалтаас ангид байх баталгааг хангаж, зохих нөөцийг хуваарилах, бүх нийтийн, цогц нийгмийн хамгааллын арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх ёстой.

ЭРҮҮЛ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Кипр улсын шүүхээс байгаль орчны ТББ-ын нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэл гаргах эрхийг хүлээн зөвшөөрсөн бол Ирландын ТББ-ууд хүлэмжийн хийн ялгаруулалтыг хангалттай бууруулж чадаагүйн эсрэг зарга мэдүүлж, Португалийн залуучууд уур амьсгалын эсрэг хангалттай арга хэмжээ аваагүй хэмээн үзэж 33 орны эсрэг ЕХ-ны шүүхэд гомдол ханджээ. Европын зөвлөл эрүүл орчинд амьдрах эрхийг улс төрийн хувьд хүлээн зөвшөөрсөн боловч энэ эрхийн талаар заавал дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгийг баталсангүй.

Гэвч олон тооны улс орон чулуужсан түлшний хэрэглээгээ үргэлжлүүлсээр байна. Болгар, Румын улсууд Хар тэнгист байгалийн хийн хайгуул хийхээр төлөвлөж байгаа бол Грек, Словак улсууд шингэрүүлсэн байгалийн хий дамжуулах терминал барихаар

төлөвлөж байна. Мальта улс томоохон хийн хоолой барихыг дэмжиж, Норвег улс газрын тос, байгалийн хийн ордуудад татварын хөнгөлөлт үзүүлж, Герман улс чулуужсан түлшний төслүүдийг санхүүжүүлжээ. Францын банкнууд чулуужсан түлш олборлох хамгийн том санхүүжүүлэгчдийн нэг байв.

Засгийн газрууд шударга шилжилтийн дагуу чулуужсан түлшний хэрэглээ, үйлдвэрлэлийг үе шаттайгаар зогсоох ёстой. Тэд мөн бага орлоготой орнуудад зориулсан уур амьсгалын санхүүжилтийг яаралтай өргөжүүлж , алдагдал, хохирлыг арилгах тусгай зориулалтын санхүүжилт олгох үүрэгтэй.

ОЙРХ ДОРНОД, ХОЙД АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Израйл-Палестины мөргөлдөөн дэх хүчирхийллийн хурцадмал байдал нь бүс нутаг болон дэлхий даяар ноцтой үр дагаварт хүргэж байна. 10 дугаар сараас хойш Израйлын цэргийн хүчин Газын энгийн иргэд голдуу 21000 хүнийг хууль бусаар хөнөөсөн бол ХАМАС Израйлын энгийн иргэдийг санаатайгаар хөнөөж, барьцаалж, олзолсон. Мөргөлдөөний гол үндэс нь Израйл улс 1948 онд Палестинчуудыг албадан нүүлгэн шилжүүлж, эд хөрөнгийг нь хурааж, 1967 онд Газа болон Баруун эргийг цэргийн хүчээр эзлэн авч, өнөөг хүртэл үргэлжилж байгаа Палестинчуудын эсрэг Израйлын апартеидын тогтолцоо, эзлэгдсэн Газын зурвасыг 16 жилийн турш хууль бусаар бүсэлсэн явдал юм.

Ирак, Ливи, Сири, Йемен зэрэг улсуудад удаан хугацаанд үргэлжилсэн мөргөлдөөний үр дагавар нь олон сая хүний, тэр дундаа дотооддоо дүрвэгсэд, цагаачид, үндэстний цөөнх гэх мэт ялгаварлан гадуурхагдсан хүмүүсийн амьдралыг улам сүйрэлд хүргэж байна. Тэдний олонх нь хоол хүнс, ундны ус, шаардлагад нийцсэн орон сууц, эрүүл мэнд, аюулгүй байдал зэрэг үндсэн эрхээ эдэлж чадахгүй байна. Аюулгүй байдлын хүчин, цэргүүд болон зэвсэгт бүлэглэлүүд энгийн иргэдийг үл ялгаварлан халдлага үйлдэх, иргэний дэд бүтцийг сүйтгэх, албадан нүүлгэн шилжүүлэх болон бусад хүчирхийлэх дэглэм үргэлжилсээр байна.

Бүс нутгийн засгийн газрууд амьжиргааны үнийн огцом өсөлт, эдийн засгийн хямрал, байгалийн болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гамшиг гэх зэрэг олон зуун сая хүний үндсэн эрхийг хөндөж байгаа асуудалд хангалттай хариу арга хэмжээ авч чадсангүй. Улс төр, нийгэм, эдийн засгийн асуудлаар гомдол саналаа илэрхийлсэн хүмүүс шүүмжлэл, өөр дуу хоолойг нухчин дарах зорилготой шийтгэлийн арга хэмжээнүүдтэй нүүр тулгарлаа. Эрх баригчид өөр үзэл санааг баримтлагч болон шүүмжлэгчдийг цагдан хорих, эрүүдэн шүүх, үндэслэлгүйгээр мөрдөх, түүнчлэн цаазаар авах, гадаадад зорчихыг хориглох гэх зэрэг хүнд ял шийтгэл ногдуулах, заналхийлэх болон бусад төрлийн дарамт шахалт үзүүлж байна. Сэтгүүлчид, онлайн тоймчид, хүний эрх хамгаалагчид, тэр дундаа эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгчид, ЛГБТИ хүмүүс, гадуурхагдсан бүлгүүд, улс төр, үйлдвэрчний эвлэлийн идэвхтнүүдийг онилсоор байна. Египет, Иран, Йордан зэрэг улсад аюулгүй байдлын хүчнийхэн эсэргүүцлийн жагсаалыг дарахын тулд хууль бус, зарим тохиолдолд үхэлд хүргэх хүч хэрэглэж, хүчээр алга болгож, жагсагчдыг олноор нь дур зоргоор баривчилж байна. Энэ мэт хүний эрхийг зөрчсөн гэмт хэрэгтнүүдийн дийлэнх нь уг гэмт үйлдэлдээ ял шийтгэл хүлээдэггүй.

Жендэр, арьс үндэс, үндэс угсаа, гарал үүсэл, эрх зүйн байдал, бэлгийн чиг баримтжаа, хүйсийн илэрхийлэл, үзэл бодол, шашин шүтлэг, эдийн засгийн ангиллаар нь ялгаварлан гадуурхах явдал бүс нутаг даяар байсаар байна. Зарим улсад дээрх ялгаварлан гадуурхалтыг хуулиар баталгаажуулсан байдаг.

Ган гачиг, хэт халалт зэрэг цаг агаарын эрс тэс үзэгдэл бүс нутгийн зарим хэсэгт үхэл, сүйрэл авчирсан боловч засгийн газрууд уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтолтой тэмцэхэд шаардлагатай арга хэмжээг авч чадсангүй. COP28-ыг зохион байгуулсан Катар, Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират зэрэг хэд хэдэн улс чулуужсан түлшний үйлдвэрлэлээ өргөжүүлэх төлөвлөгөөгөө зарлав.

ИЗРАЙЛ - ПАЛЕСТИНЫ МӨРГӨЛДӨӨН

Олон жил үргэлжилсэн Израйл-Палестины мөргөлдөөн аравдугаар сард улам хурцадмал болж, бүс нутгийн улс төр, олон улсын хүний эрхийн хууль тогтоомжид нөлөөлсөн цочрол нь бүс нутаг, дэлхий даяар нөлөөлөв.

10 дугаар сарын 7-нд Хамас болон Палестины бусад зэвсэгт бүлэглэлүүд Израйл руу энгийн иргэдийг ялгахгүйгээр пуужингаар харваж, олон зуун энгийн иргэдийг санаатайгаар хөнөөж, барьцаалж дайны гэмт хэрэг үйлдсэн. Үүний дараа Израйлын цэргийн хүчин хүн ам шигүү суурьшсан Газын зурвасыг агаараас хүчтэй бөмбөгдөж, энгийн иргэдийг хөнөөх, гэмтээх, гэр орон болон бусад иргэний дэд бүтэц, объектуудыг эвдлэн сүйтгэх болон бусад хууль бусаар хүчирхийлэх зэргээр дайны гэмт хэрэг үйлдэв. Мөн ядууралд нэрвэгдсэн энгийн иргэдийг хууль бусаар бүхэлд нь бүслэж, 1.9 сая орчим Палестинчуудыг гэр орноос нь албадан шилжүүлэв.

Дараагийн 12 долоо хоногт Израйлын арми тасралтгүй бөмбөгдөлт, газрын довтолгооны улмаас 21,600 палестин хүн амь үрэгдсэний гуравны нэг нь хүүхдүүд байсан бөгөөд бусад олон хүн шархдаж, Газын суурингийн ихэнх хэсгийг газартай нь тэгшилсэн. Эмнести Интернэшнл болон бусад байгууллагын цуглуулсан баримт материал, хиймэл дагуулын зураг, видео бичлэг, гэрэл зургаар баталгуулсан нотлох баримтууд нь Израйлын цэргүүд хэрхэн хүн ам ихтэй дүрвэгсдийн хуаран, орон сууцны барилгуудыг бөмбөгдөж, бүхэл бүтэн гэр бүлээр нь хүйс тэмтэрч, эмнэлэг, сүм хийд, НҮБ-ын эрхлэн удирддаг сургууль, нарийн боовны газар, зам болон бусад чухал дэд бүтцийг эвдлэн сүйтгэж байгааг харж болно. Израйлын зүгээс Газын хойд хэсгийг “нүүлгэн шилжүүлэх” тухай тодорхой бус анхааруулга өгсөн хэдий ч өмнөд хэсгийн аюулгүй гэгддэг бүс нутгуудыг бөмбөгдөж, энгийн иргэдийг албадан нүүлгэн шилжүүлж, олон улсын хүмүүнлэгийн хуулийг ноцтой зөрчсөн.

Израйлын бүслэлт болон эмнэлгүүд рүү дайрсан халдлагын улмаас Газын 2.2 сая хүн ундны ус, хоол хүнс, эмнэлгийн хэрэгсэл, түлшний хангамжгүй болж, эрүүл мэндийн систем бараг бүрэн сүйдсэний улмаас бусад олон мянган Палестинчууд нас баржээ.

Газын зурваст олон улсын анхаарал төвлөрч байхад Палестины эзлэгдсэн Баруун эрэг, ялангуяа Зүүн Иерусалим дахь Палестинчууд хүчирхийллийн халдлагад өртсөөр байна. Тус бүс нутагт Израйлын зэвсэгт хүчин болон төрийн дэмжлэгтэй зэвсэгт еврей суурьшигчид Палестинчуудын эсрэг хүчирхийллийн халдлага үйлдсэний улмаас 511 хүн амиа алдаж, олон мянган хүн гэр орноо орхин дүрвэжээ. Эдгээр халдлага үйлдэгчдэд хариуцлага ногдуулсангүй. Түүнчлэн Израйлын эрх баригчид цэргийн үндэслэлгүйгээр Палестины олон зуун барилгыг нурааж, 2249 хүнийг нүүлгэн шилжүүлж, захиргааны журмаар баривчлах ажиллагааг ихээхэн нэмэгдүүлсэн.

ОЛОН УЛСЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Газын зурвас болон Израйлд энгийн иргэдийн цус урсгасан, асар их сүйрэл, зовлон зүдгүүр учирч байгаа хэдий ч олон улсын хамтын нийгэмлэгээс мөргөлдөөнд оролцогч талуудыг хүний эрхийг илт зөрчих зэвсэглэлээр хангаж байгаа улс орнууд, тухайлбал АНУ-ын эсрэг дорвитой арга хэмжээ авч чадахгүй байна. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийг үр дүнтэй арга хэмжээ авах, галаа зогсоохыг уриалах арга хэмжээнд АНУ хориг тавих эрхээ ашигласан.

Хүчирхэг улс орнууд, тухайлбал АНУ болон баруун Европын улс орнууд Израйлын үйл ажиллагааг илэрхий дэмжиж, олон улсын хүмүүнлэгийн хуулийг хүндэтгэх, энгийн иргэдийг хамгаалах явдлыг алдагдуулж байна. Олон улсын хамтын нийгэмлэг хүний эрх, олон улсын хүмүүнлэгийн хуулийг сахин хамгаалах хүсэлгүй байгаа нь Израйлыг Газын зурваст энгийн номхон иргэдийг хохироож буйг үл харгалзан цэргийн довтолгоогоо үргэлжлүүлэхийг зөвшөөрч байгаагаар илэрч байна.

Арван нэгдүгээр сарын 16-нд НҮБ-ын шинжээчид дэлхий нийтээрээ Газын зурваст үйлдэгдэж байгаа “төрлөөр устгах гэмт хэргийн” гэрч болж байгааг цохон тэмдэглэсэн.

Олон улсын хамтын нийгэмлэг дорвитой хариу арга хэмжээ аваагүй боловч дэлхий даяар хэдэн зуун сая хүн Газын Палестинчуудтай эв санааны нэгдэлтэй байгаагаа илэрхийлж, гал зогсоож, бүслэлтээ буулгахыг шаардан долоо хоног бүр олон нийтийн жагсаал зохион байгуулав. Ийм жагсаал, цуглаан бүс нутагт, тэр дундаа Израйл улстай харилцаагаа хэвийн болгосон, олон нийтийг хамарсан эсэргүүцлийн жагсаал зохион байгуулахыг хориглосон улс орнуудыг хамарчээ.

Египет улсад орон даяар олон арван мянган хүн гудамж, талбайд гарч жагссан бөгөөд эрх баригчид олон арван хүнийг дур зоргоор баривчилжээ. Бахрейн 1000 орчим хүн жагсаал хийжээ. Мөн Алжир, Иран, Ирак, Иордан, Ливан, Ливи, Марокко, Сири, Тунис, Йемен, Баруун эрэгт томоохон жагсаал зохион байгуулжээ.

Арваннэгдүгээр сарын 11-нд Арабын Лиг болон Исламын Хурлын Байгууллагын урьд болж байгаагүй дээд хэмжээний уулзалтын үеэр удирдагчид “Израйлын Газын зурвасын эсрэг түрэмгийлэл, дайны гэмт хэрэг, эзлэн түрэмгийлэгч засгийн газрын үйлдсэн зэрлэг, хүнлэг бус аллага үйлдлийг” буруутгав. Өнгөрсөн арван хоёрдугаар сард Өмнөд Африк улс төрлөөр устгах тухай 1948 оны конвенцийг зөрчсөнтэй холбогдуулан Израйлын эсрэг хэрэг үүсгэхээр Олон улсын шүүхэд хандсан.

Үүний зэрэгцээ, мөргөлдөөн өргөн тархах болгоомжлол нэмэгдэв. Аравдугаар сарын 7-ны өдрөөс эхлэн Израйл, Хизбулла болон Ливаны өмнөд хэсгийн бусад зэвсэгт бүлэглэлийн хоорондох хил дамнасан дайсгалыг улмаас Израйлын дөрвөн энгийн иргэн, Ливанд наад зах нь 20 энгийн иргэн амиа алджээ. Аравдугаар сарын 10-16-ны хооронд Израйлын цэргүүд Ливаны өмнөд хилийн дагуух цэргийн ажиллагаа хийхдээ цагаан фосфор агуулсан их буугаар харважээ. Дхярад хийсэн халдлагыг Эмнести Интернэшнл дайны гэмт хэрэг байж болзошгүйг анхааруулж мөрдөн шалгахыг шаардав. Аравдугаар сарын 13-нд Израйлын цэргийн хүчин Ливаны өмнөд хэсэгт их буугаар галласны улмаас нэг сэтгүүлч амиа алдаж, зургаан хүн шархадсан. Мөн сард Израйлаас Сири улсруу довтолсны улмаас найман цэрэг амь үрэгдсэн бөгөөд Алеппо нисэх онгоцны буудалд дөрвөн удаа цохилт өгчээ. Аравдугаар сарын 9-нөөс хойш Израйлын цэргийнхэн Египеттэй хиллэдэг Рафах боомт руу олон удаа дайралт хийсэн бөгөөд нэг удаагийн цохилтод Египетийн хилчид шархаджээ.

Дэлхий даяар Палестин болон Еврейчүүдийн эсрэг цахим орчинд үзэн ядах, арьс үндсээр ялгаварлан гадуурхах, хүчирхийлэл, дайсгал, ялгаварлан гадуурхалтыг өөгшүүлэх хандлага эрс нэмэгдсэн бөгөөд зарим засгийн газар Палестиныг дэмжсэн жагсаал, уриа лоозонг дарахын тулд үзэл бодлоо илэрхийлэх, хуран цуглах эрх чөлөөг дарангуйлж байна.

Олон улсын хүмүүнлэгийн хуулийн дагуу мөргөлдөөнд оролцогч бүх талууд энгийн иргэд болон иргэний объектуудыг хамгаалах ёстой. Эмнести Интернэшнл энгийн иргэдийн амь насыг цаашид хохироохгүйн тулд нэн даруй галаа зогсоохыг уриалж, хүмүүсийн амь насыг аврах хүмүүнлэгийн тусламжийг Газын зурваст нэн шаардлагатай байгаа хүмүүст хүргэхийг зөвшөөрөх, олон улсын эрх зүйн дагуу бүх талуудын үйлдсэн гэмт хэргийг олон улсын бие даасан мөрдөн шалгалт явуулахыг уриалж байна. Хамас бүлэглэлийн барьцаанд байсан энгийн иргэд болон Израйлын дур зоргоороо баривчилсан бүх Палестинчуудыг нэн даруй суллахыг уриалж байна. Олон улсын хамтын нийгэмлэг мөргөлдөөнд оролцогч талуудад зэвсгийн цогц хориг тавих ёстой.

ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН БУСАД ЗӨРЧИЛ

Удаан үргэлжилсэн бүс нутгийн зэвсэгт мөргөлдөөн болон тэдгээрийн үр дагавар нь олон сая хүний амьдралыг сүйрүүлж, мөргөлдөөнд оролцогч талууд (зарим нь гадаадын засгийн газруудын дэмжлэгтэйгээр) дайны гэмт хэрэг үйлдэж, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг ноцтой зөрчсөн.

12 жил үргэлжилж байгаа Сирийн мөргөлдөөнд оролцогч бүх тал, тэдний холбоотнууд хууль бус халдлага үйлдэж, энгийн иргэдийг хөнөөж, нэн шаардлагатай дэд бүтцийг сүйтгэсэн. Сирийн засгийн газар Оросын засгийн газрын цэргийн дэмжлэгтэйгээр газраар олон удаагийн хууль бус халдлага үйлдэж, аравдугаар сараас эхлэн Сирийн баруун хойд хэсэгт энгийн иргэд болон энгийн объект руу агаараас довтолсны улмаас олон арван энгийн иргэд амь үрэгдэж, хэдэн арван мянган хүн дүрвэжээ.

Ливид цэргийн хүчин болон зэвсэгт бүлэглэлүүд хууль бус халдлага үйлдэж, орон сууцны хороололд өргөн хүрээнд нөлөөлөл үзүүлэх зэвсэг хэрэглэж, зэвсэгт мөргөлдөөний үеэр энгийн иргэдийг хөнөөж, шархдуулж, иргэний дэд бүтцийг сүйтгэсэн. Олон мянган хүнийг мөргөлдөөнтэй холбоотой, эсхүл овог аймаг, улс төрийн үзлээс нь хамааран дур зоргоор цагдан хорьсон хэвээр байв. Йеменд зэвсэгт мөргөлдөөн, хил дамнасан халдлагууд буурч байгаа хэдий ч мөргөлдөөнд оролцогч бүх талууд хууль бус халдлага, аллага үйлдэж, түүнийхээ төлөө ямар ч шийтгэл хүлээсэнгүй.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч бүх талууд олон улсын хүмүүнлэгийн хуулийг хүндэтгэх, ялангуяа энгийн иргэд болон иргэний дэд бүтэц рүү шууд, эсхүл ялгахгүйгээр халдах явдлыг зогсоох ёстой. Гадаад улсын засгийн газрууд хүний эрх болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг ноцтой зөрчихөд ашиглах, эсхүл түүнд дэмжлэг болох өндөр эрсдэл бүхий зэвсгийн шилжүүлгийг зогсоох шаардлагатай.

ШҮҮМЖЛЭЛТ ҮЗЛИЙГ ДАРАНГУЙЛСАН НЬ

Бүс нутаг даяар эрх баригчид засгийн газар болон аюулгүй байдлын алба, хүний эрх, эдийн засгийн бодлого, олон улсын болон ёс суртахуунгүй хэмээн үздэг бусад нийгмийн асуудлаар шүүмжлэлт, эсрэг байр суурь илэрхийлсэн хүмүүсийн эрхийг зөрчсөөр байна.

2022 онд Иранд болсон “Эмэгтэйчүүдийн амьдралын эрх чөлөө” бослогын дараа эрх баригчид охид, эмэгтэйчүүдийг нухчин дарах, хууль бусаар алагдсан жагсагчдын гэр бүл ойр дотны хүмүүсийг хүчирхийлэх, шударга ёс, үнэний төлөө тэмцэн зогссон хүмүүсийн эсрэг дарамт шахалтаа нэмэгдүүлсээр байна. Тэд мөн олон тооны сэтгүүлч, хуульч, хүний эрх хамгаалагчдыг баривчилсан. Эрх баригчид эсэргүүцлийн жагсаалын үеэр интернэтийн болон гар утасны сүлжээг тасалдуулж, 2022 оны есдүгээр сард болсон бослогын ойг тохиолдуулан улс орон даяар зохион байгуулагдах олон нийтийн жагсаалыг зогсоохын тулд баривчилгаа явуулж, орон нутгийн цөөн хүн оролцсон эсэргүүцлийн жагсаалыг хууль бус хүч хэрэглэн тарааж, хүмүүсийг олноор нь баривчилжээ.

12 дугаар сард болсон Египетийн ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө жинхэнэ сөрөг хүчний нэр дэвшигчдийг сонгуульд оролцохыг хориглосон бөгөөд эрх баригчид сөрөг хүчний улс төрчид болон тэднийг дэмжигчид, хилийн чанад дахь шүүмжлэгчдийн хамаатан садан, үйлдвэрчний эвлэлийн гишүүд, хуульч, сэтгүүлчид гэх зэрэг хүний эрхийн нөхцөл байдал, эдийн засгийн хямралыг хэрхэн даван туулах, цэргийн үүрэг оролцоо зэргийг шүүмжилдэг бусад хүмүүсийг онилох ажиллагааг улам эрчимжүүлсэн. Аюулгүйн хүчнийхэн шүүмжлэгчдийг хүчээр алга болгож, тамлан

зовоож, үндэслэлгүй яллаж, дур зоргоор цагдан хорьсоор байв.

Зарим улсад сөрөг хүчнийхнийг дуугүй байлгах, шүүмжлэгчдэд хатуу шийтгэл оногдуулахын тулд терроризмын эсрэг хууль тогтоомж, эсхүл хилс хэрэгт буруутгасаар байна.

Алжир улсын эрх баригчид хүний эрхийн идэвхтнүүд болон сэтгүүлчдийг шүүмжлэлт үзэл бодлоо ихэвчлэн цахим орчинд илэрхийлснийх нь төлөө мэдээллийн хэрэгслийг нь хаажээ. Иракийн эрх баригчид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд халдаж, уг эрхийг хязгаарлахад чиглэсэн хууль, журам батлахыг оролдсон.

Тунисын эрх баригчид шүүмжлэгчдийн эсрэг тэмцлээ эрчимжүүлж, сөрөг хүчнийхэн болон бусад шүүмжлэгчдийн эсрэг үндэслэлгүй хуйвалдаан, терроризмын хэрэгт буруутгах, цахим гэмт хэргийн шинээр баталсан хатуу хуулийг хэрэглэх нь нэмэгдсээр байна. Сөрөг хүчний “Эннахда” намын гишүүдийг тухайлан онилж, олон тооны удирдагчдыг удаан хугацаагаар цагдан хорьжээ. Улс төрийн 50 гаруй идэвхтэнг «хуйвалдаан зохион байгуулсан» гэх хилс хэрэгт буруутган, нийгэм болон байгаль орчны төлөө тэмцэгч олон арван жагсагчдыг үндэслэлгүй ялласан.

Саудын Арабын эрх баригчид шүүмжлэгчдийг тасралтгүй онилсоор байна. Терроризмтой холбоотой гэмт хэргийн шийдвэрлэх зорилгоор байгуулсан Эрүүгийн хэргийн дагнасан шүүх үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, тэр дундаа цахим орчинд тайван замаар үг хэлэх эрхээ хэрэгжүүлсэн иргэдийг шударга бусаар шүүж, урт хугацаагаар хорих ялаар шийтгэжээ.

Дээрх дагнасан хэргийн шүүхийн давж заалдах шатны шүүхээс Салма аль-Шехаб гэх эмэгтэйг нийгмийн сүлжээнд эмэгтэйчүүдийн эрхийг дэмжиж жиргэснийх нь төлөө “олон нийтийн хэв журам зөрчиж, нийгмийн болон төрийн аюулгүй байдлыг алдагдуулсан” гэсэн үндэслэлээр терроризмтой холбоотой гэмт хэрэг үйлдсэн хэмээн ял шийтгэжээ. Түүнд шүүхээс 27 жилийн хорих ял оноосныг хожим нь 27 жилийн хугацаагаар зорчих эрхийг хасах ял болгон өөрчилжээ.

Арабын Нэгдсэн Эмират Улс (АНЭУ)-д зохион байгуулсан Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг суурь конвенцын оролцогч талуудын бага хурлын үеэр (COP28) терроризмын хилс хэрэгт буруутгагдан хэдийн арван жилийн турш хоригдсон хүний эрх хамгаалагчид, үзэл санааны хоригдлууд гэх зэрэг 80 гаруй Эмиратын иргэдийг бөөнөөр нь шүүх хурал эхэлсэн. Хамгийн багадаа 26 үзэл санааны хоригдол АНЭУ-д итгэл үнэмшлээ тайван замаар илэрхийлснийхээ төлөө хоригдсон хэвээр байна.

Палестиныг дэмжсэн жагсаал, цуглаанаас гадна, бусад нийтийг хамарсан эсэргүүцлийн жагсаал, цуглааныг дарангуйлах ажиллагаа бүс нутгийн ихэнх хэсэгт үргэлжилсэн, эрчимжсэн хэвээр байгаа бөгөөд жагсагчдын эсрэг хууль бусаар хүч хэрэглэж, баривчилж байна.

Шүүхийн шинэчлэлийг эсэргүүцэж жагссан хэдэн зуун мянган Израйльчуудын заримыг цагдаа нар дур зоргоороо баривчилж, хүч хэтрүүлэн хэрэглэж байв. Түүнчлэн Израйлын 101 тоот цэргийн тушаалаар Палестинчуудын Баруун эрэгт тайван замаар жагсаал, цуглаан хийх эрхийг хаан боогдуулсаар байна.

Иорданы эрх баригчид улс төрийн идэвхтэн, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан, улс төрийн намын гишүүн, ЛГБТИ болон бусад хүмүүсийн тайван журмаар зохион байгуулсан үйл ажиллагааг тодорхой бус агуулга бүхий хуулиудыг ашиглан улам бүр боомилсоор байна. Цахим гэмт хэргийн талаарх шинэ хууль нь хувь хүмүүсийн онлайнаар үзэл бодлоо илэрхийлэх эрхийг улам бүр дарангуйлж байна. Онлайнаар үзэл бодлоо илэрхийлсэн хамгийн багадаа 43 хүнийг хэрэг үүсгэн шалгаж, яллажээ. Тэдний 9 хүнд холбогдох хэргийг Цэргийн улсын аюулгүй байдлын шүүх шийдвэрлэжээ.

Засгийн газар үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хүндэтгэх, тэр дундаа сэтгүүлч, хүний эрх хамгаалагч, идэвхтнүүдийг дарамт шахалт, хүчирхийлэл, ял шийтгэлээс ангид байдлаар эрхээ эдлэх, эрхээ эдэлснийхээ төлөө баривчлагдсан хүмүүсийг суллах шаардлагатай.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЭРХИЙГ ҮГҮЙСГЭХ

Өсөн нэмэгдэж буй инфляц, засгийн газрын алдаатай бодлого, шийдвэр, үйл ажиллагаа болон орон нутаг, бүс нутаг, олон улсын хэмжээний бусад хүчин зүйл нь бүс нутгийн эрчим хүч, хүнсний үнийн өсөлтөд ноцтой дарамт учруулж байна. Энэ нь байгалийн нөөцөөр хамгийн бага, хүн ам ихтэй орнууд болон Ковид-19 цар тахлын эдийн засгийн болон бусад нөлөөллийг даван туулах гэж оролдож байгаа улс орнуудад хүнд цохилт болж байна. Үүний улмаас сая сая хүний хүнсний аюулгүй байдал алдагдаж, ус, эрүүл мэнд, амьжиргааны зохистой түвшинд амьдрах эрх зөрчигдсөн. Үүний үр дагаврыг эмэгтэйчүүд, бага цалинтай ажилчид, дүрвэгсэд, цагаачид, дотоод дүрвэгсэд зэрэг олон төрлийн ялгаварлан гадуурхалтад өртсөн хүмүүс илүү хүндээр амсаж байна.

Ливанд эдийн засгийн хямрал гүнзгийрч, инфляц гурван оронтой тоонд хүрч, хүнсний үнийн өсөлт 300 гаруй хувьд хүрсэн. Олон тооны хүн, тэр дундаа нийгмийн гадуурхагдсан бүлгийн хүмүүс эм тариа, ундны ус, хүрэлцэхүйц хоол хүнс, эрчим хүч болон бусад үндсэн бараа, амин чухал үйлчилгээ зэрэг бусад хэрэгцээт зүйлийг хүртэж, авч чадахгүй байна.

Египетийн эдийн засгийн хямрал нийгэм-эдийн засгийн эрхэд ноцтой нөлөөлөв. Засгийн газар эрүүл мэнд, боловсролын салбарт зарцуулах төсвийн үүргээ биелүүлээгүй, түүнчлэн нийгмийн хамгааллын хөтөлбөртөө зохих тохируулга хийж чадаагүй боловч төсвийн тал орчим хувийг улсын гадаад өрийг барагдуулахад зарцуулсан. Үүний үр дагавар нь инфляцын өсөлттэй хавсарч олон сая хүнийг ядууралд хөтлөв.

Газрын тос, байгалийн хийгээр баялаг эдийн засагтай улс орнууд бага цалинтай ажилчдыг хөдөлмөрийн хүчирхийллээс хамгаалж чадаагүй бөгөөд ажилчдыг бие даасан үйлдвэрчний эвлэлд нэгдэх, ажил хаях эрхийг нь хаан боогдуулав. Персийн булангийн улс орнуудад бага цалинтай цагаач ажилчид хөдөлмөрийн мөлжлөг, ялгаварлан гадуурхалт, зохисгүй орон байр, бие махбодын болон оюун санааны хүчирхийлэл, ажил олгогчид цалинг өгөхгүй байх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжгүй байдалтай тулгарсаар байна.

Катар улсад 2022 оны хөл бөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнтэй холбогдуулан цагаач ажилчдын эрхийн талаар өндөр түвшний кампанит ажил өрнөж байсан ч цагаач ажилчдын цалинг өгөхгүй байх, албадан хөдөлмөр эрхлэх, ажил солихыг хязгаарлах зэрэг хүчирхийлэлд өртсөн хэвээр байгаа бөгөөд гомдол барагдуулах механизмыг хүртээмж хангалтгүй байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ бага, түүнчлэн ажилд оруулсны төлөө авах хууль бус хураамж нь ажилчдын амьжиргааны түвшинг алагдуулж, өрийн дарамтаас ангижрахад нь саад болж байна. Катар болон бусад зарим улсад гэрийн үйлчлэгч голдуу эмэгтэйчүүд хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж, бие махбод болон оюуны санааны хүчирхийлэл, тэр дундаа бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөр байна.

Саудын Араб дахь Амазоны агуулахад ажиллахаар гэрээ байгуулсан Балбын олон арван цагаач иргэд хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалахтай адилгаж болохуйц хүний эрхийн хүчирхийлэлд байна. Тэднийг ажлын байрны талаар хууран мэхэлж, цалинг нь хассан бөгөөд орон сууц нь хүн амьдрах шаардлагад огт нийцэхгүй байв. Эдгээр нөхцөл байдлын талаар гомдол гаргасан болон бусад үед ажилтнуудын зарим нь хэл ам болон бие махбодын хүчирхийлэлд өртжээ.

Засгийн газрууд хямралын сөрөг нөлөөллөөс хүн бүрийг, тэр дундаа гадуурхагдсан бүлгийг хамгаалах нийгмийн хамгааллын арга хэмжээг яаралтай авч, эрүүл мэнд, хоол хүнс, амьжиргааны зохих түвшний эрхийг баталгаажуулахын тулд олон улсын хамтын хүчин чармайлтыг уриалах ёстой. Засгийн газар ажилчдын бие даасан үйлдвэрчний эвлэл байгуулах, жагсаал, цуглаан хийх эрхийг хамгаалж, цагаач ажилчдын хөдөлмөрийн хуулийн хамгаалалтыг өргөжүүлэх ёстой.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

Бүс нутаг даяар охид, эмэгтэйчүүдийг чөлөөтэй зорчих болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, бие махбодын бие даасан байдал, өв залгамжлал, гэр бүл салалт, улс төрийн албан тушаал, хөдөлмөр эрхлэх боломж зэрэгтэй холбоотой хуулиар болон практикт ялгаварлан гадуурхсаар байна. Жендэрт суурилсан хүчирхийлэл нийтлэг хэвээр байгаа бөгөөд хүчирхийлэгчид ял шийтгэлгүй үлддэг. Зарим улсад энэ төрлийн хүчирхийлэл нэмэгдэж, эрх зүйн хамгаалалт суларсан. Алжир, Ирак улсад хүчингийн гэмт хэрэг үйлдэгсэд хохирогчтойгоо гэрлэх замаар ялаас мултрах боломжийг хуулиар зөвшөөрдөг. Марокко улс гэр бүлийн хүчинг гэмт хэрэгт тооцох тухай НҮБ-ын Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлгийн тайлангийн зөвлөмжийг хүлээн авахаас татгалзав. Алжир, Тунис зэрэг улс орнуудад эмэгтэйчүүд эсрэг “нэр төрийн аллага” болон жендэрт үндэслэн эмэгтэйчүүдийн амь насыг хохироох явдал үргэлжилсэн хэвээр байна.

Иракийн Курдистан бүс нутгийн орон нутгийн захиргааны байгууллагаас гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдэд ялаас мултрах боломжийг олгож, амьд үлдсэн хохирогчдыг зохих ёсоор хамгаалж чадсангүй.

Иран улсын эрх баригчид нийгэм, эдийн засаг, соёл, иргэний болон улс төрийн эрхийг ноцтой зөрчсөн шинэ бодлого нэвтрүүлэх замаар нүүрээ заавал халхлахын эсрэг охид, эмэгтэйчүүдийн эсэргүүцлийг дарах арга хэмжээг улам бүр эрчимжүүлэв. Эмэгтэйчүүдэд хандан машиныг нь хураана хэмээн заналхийлж илгээсэн 1 сая мессеж анхааруулга илгээж, олон мянган хэргийг шүүхэд шилжүүлэх зэргээр шийтгэлийн арга хэрэглэв.

Йеменд Хути де-факто эрх баригчид болон зэвсэгт бүлэглэлүүд эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг хязгаарлаж, эрэгтэй асран хамгаалагч эсвэл асран хамгаалагчийн бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр зорчихыг хориглов. Египет улсад гэр бүлийн гишүүдийн гарт амиа алдсан эмэгтэйчүүд болон гаргасан гомдлоо татгалзах тохиолдолд нэмэгдэж байгаа хэдий ч төрийн болон бусад байгууллага, иргэний үйлдсэн бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч чадсангүй. Харин ч бэлгийн хүчирхийллийн талаар үгээ хэлсэн эмэгтэйчүүдэд ял шийтгэл оногдуулав

ЛГБТИ ХҮМҮҮС

Бүс нутаг даяар хүмүүсийг бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаанаас хамааран баривчилж, яллаж байгаа бөгөөд ихэнх улсад ижил хүйстнүүдийн зөвшилцлийн бэлгийн харьцаанд хатуу шийтгэл оногдуулж байна. Ирак, Йордан, Ливан, Ливи, Тунис зэрэг улсад ЛГБТИ хүмүүсийн эрхэнд халдах ажиллагаа эрчимжсээр байна. Ливан улсын эрх баригчид гей, лесбиян хүмүүсийн эсрэг хүчирхийллийг улам бүр өдөөн турхирсан. Ийнхүү эрх чөлөөг нухчин дарангуйлж байгааг эсэргүүцэн хэвлэл мэдээллийн 18 байгууллага хамтарсан мэдэгдэл гаргасан бол Ливан болон олон улсын 15 байгууллагын эвсэл тус улсыг ЛГБТИ хүмүүийн эсрэг хуулиа цуцлахыг шаардав.

Ливи улсын нийслэл Триполи дахь Дотоодын аюулгүй байдлын агентлаг, бусад цэргүүд болон зэвсэгт бүлгүүд хүмүүсийг гадаад байдал, үйлдлээр нь бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжааг тодорхойлон дур зоргоор баривчилж, эрүүдэн шүүж олж авсан мэдээллийг үнэнээ хэлсэн хэмээн мэдээлдэг. Иракийн эрх баригчид “ижил хүйстэн” гэсэн нэр томъёог «бэлгийн гажуудлаар» солихыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд үүрэг болгожээ. Тунисын шүүхүүд ижил хүйстнүүдийн зөвшилцлийн бэлгийн харилцааг гэмт хэрэгт тооцох хуулийн заалтын дагуу хоёр жилийн хорих

ял оноожээ. Йорданд зарим парламентын гишүүд ЛГБТИ хүмүүсийн эсрэг кампанит ажлыг удирдаж, ижил хүйстнүүдийн бэлгийн харилцааг гэмт хэрэгт тооцохыг уриалж, ЛГБТИ хүмүүс болон дэмжигчдийн эсрэг үзэн ядсан үг хэллэг, заналхийллийг улам бүр өдөөсөөр байна.

АРЬС ҮНДЭС, ҮНДЭС УГСАА, ҮНДЭСТЭН БОЛОН ШАШНЫ БҮЛГИЙНХЭН

Бүс нутаг даяар арьс үндэс, үндэс угсаа, үндэсний болон шашны бүлэг, цөөнхийн гишүүдийг хуулиар болон практикт ялгаварлан гадуурхсаар байна. Үүний улмаас тэдний шашин шүтэх эрх, хөдөлмөр эрхлэлт болон эрүүл мэндийн үйлчилгээнд тэгш хамрагдах, ял тулгах болон бусад хүний эрхийн хүчирхийллээс ангид амьдрах эрх зөрчигдөж байна.

Израйл улс Палестины нутаг дэвсгэрийг хэсэгчлэн хуваах, ялгаварлан тусгаарлах, хараа хяналтаа хэрэгжүүлэх, газар нутаг, өмч хөрөнгийг нь булаан авах, эдийн засаг, нийгмийн эрхийг үгүйсгэх гэх зэргээр Палестинчуудыг дарангуйлах, ноёрхлоо тогтоохын тулд ялгаварлан гадуурхах үзлийн туйлын хэлбэр болох апартейдын тогтолцоог бэхжүүлсээр байна. Энэ үр дүнд хүрэхийн тулд албадан шилжүүлэх, захиргааны журмаар баривчлах, эрүүдэн шүүх, хууль бусаар алах, үндсэн эрх, эрх чөлөөг үгүйсгэх, мөрдлөг хавчлага зэрэг олон төрлийн хүний эрхийг зөрчих үйлдлийг системтэйгээр зохион байгуулжээ.

Иран улсад угсаатны цөөнх болох Ахвази Араб, Азербайжаны Турк, Балучи, Курд, Туркмен зэрэг үндэстнүүд ялгаварлан гадуурхалтад өртөж, боловсрол, ажил эрхлэлт, зохистой орон сууц, улс төрийн албан тушаалд хүрэх боломж нь хязгаарлагджээ. Христэд итгэгчид, Гонабади дервишүүд, Еврейчүүд, Яресан, Суннит шашинтнуудыг ч мөн адил хуулиар болон практикт ялгаварлан гадуурхсаар байна. Тэр дундаа Бахай үндэсний цөөнх өргөн хүрээний, системт хүчирхийлэлд өртжээ.

Кувейт улсын ялгаварлан гадуурхсан хуулиар Бидун (харьяалалгүй хүн ам) хүмүүст төрийн үнэ төлбөргүй үйлчилгээ, тэр дундаа боловсрол олгохыг хоригложээ. Египет улсын эрх баригчид шашны цөөнхийн гишүүд болон төрөөс хүлээн зөвшөөрөөгүй итгэл үнэмшлийг баримталдаг хүмүүсийг баривчилж, яллажээ. Ливи улсад Табу, Туарег зэрэг иргэдийг арьс үндсээр ялгаварлан гадуурхан иргэний үнэмлэх олгохоос татгалзсаны улмаас үндсэн үйлчилгээ авч чадахгүй байна.

Засгийн газрууд охид, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийн эсрэг жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг таслан зогсоохын тулд яаралтай арга хэмжээ авч, энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүмүүст хариуцлага тооцох ёстой. Түүнчлэн ижил хүйстнүүдийн зөвшилцсон бэлгийн харьцааг гэмт хэрэгт тооцох ёсгүй. Засгийн газар арьс үндэс, үндэс угсаа, шашин шүтлэг, жендэр, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэлд суурилсан ялгаварлан гадуурхалтыг зогсоож, хүн бүрд ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш эрхийг олгох, хамгаалах, дэмжих, үзэл бодолтой байх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх эрх чөлөөг баталгаажуулах хууль эрх зүйн болон бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлэх ёстой.

ДОТООДДОО ШИЛЖИН СУУРЬШИГЧИД, ЦАГААЧ, ДҮРВЭГСДИЙН ЭРХ

Ирак, Ливи, Сири, Йемен улсад удаан үргэлжилсэн мөргөлдөөний улмаас олон тооны дотоод дүрвэгсэд амьд үлдэхийн төлөө тэмцэж байна. Тэдний ихэнх нь төрийн үйлчилгээ авч чадахгүй байх, ялгаварлан гадуурхагдах, гэртээ буцах эрхээ хязгаарлуулах, зөвшөөрөлгүйгээр буцахыг оролдсон тохиолдолд хүчирхийлэлд өртөх, чухал шаардлагатай хүмүүнлэгийн тусламжийг хүртэж чадахгүй байх, эсхүл

тасалдуулах зэрэг бэрхшээлтэй тулгарч байна.

Ирак улсад өрнөж буй Исламын улс зэвсэгт бүлэглэлийн мөргөлдөөний улмаас хамгийн багадаа 1,1 сая хүн дотооддоо дүрвэсэн бөгөөд тэдний ихэнх нь мөргөлдөөнөөс хойш бараг зургаан жилийн хугацаанд хүнд нөхцөлд аж төрж байна. Дөрөвдүгээр сард Иракийн эрх баригчид хүмүүнлэгийн байгууллагуудад урьдчилан мэдэгдэж, хамтран ажиллахгүйгээр дотооддоо дүрвэгсдийн хамгийн сүүлийн хуаранг хаажээ.

Сирийн баруун хойд нутгийн дотооддоо дүрвэн 2.9 сая орчим хүн НҮБ-ын хүмүүнлэгийн тусламжаас хамааралтай байсан хэдий ч 2023 онд зэвсэгт мөргөлдөөний улмаас дор хаяж 118,000 хүн дүрвэжээ. Сирийн засгийн газар энгийн иргэд, тэр дундаа Алеппогийн хойд хэсгийн ихэвчлэн Курдууд суурьшсан, түлш, тусламжийн хомсдолд аль хэдийн өртсөн дотооддоо дүрвэгсдэд хүргэх чухал шаардлагатай нийлүүлэлтийг хязгаарлав.

Засгийн газрын алдаатай менежмент, шийтгэл хүлээдэггүй байдал, цэргийн засаглалаас үүдэн үр дагавар нь улам нэмэгдэж байгаа байгалийн гамшигт үзэгдлийн улмаас дүрвэгсдийн асуудал улам бүр хүндэрч, тэдний хүрээ улам тэлсээр байна. 2 дугаар сарын 6-нд Туркийн зүүн өмнөд болон Сирийн хойд хэсэгт болсон газар хөдлөлтийн улмаас Сири дэх 400,000 орчим гэр бүл орон гэргүй бол, 9 сая орчим хүн хүмүүнлэгийн яаралтай тусламж авах шаардлагатай болжээ. Олон гэр бүл орон гэргүй болж, түр хоргодох газар, хуаранд амьдрахаас өөр аргагүйд хүрэв. Газар хөдлөлт нь Сирийн баруун хойд хэсэгт дүрвэсэн иргэдэд шаардлагатай хүмүүнлэгийн хэрэгцээг улам нэмэгдүүлсэн бөгөөд ус, ариун цэврийн байгууламж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжгүй майханд амьдарч буй хүмүүсийн тоо нэмэгдсээр байна.

Бүс нутгийн хэмжээнд цагаачид болон дүрвэгсдийн эрх улам бүр дордов. Ойролцоогоор 1.5 сая Сири, 200,000 гаруй бусад дүрвэгсдийг хүлээн авсан Ливаны засгийн газар тус улсын эдийн засгийн хямралын нөлөөг бууруулж чадаагүйн улмаас Сирийн дүрвэгсдийн 90 орчим хувь нь нэн ядууралд нэрвэгдэж, хангалттай хоол хүнс, үндсэн үйлчилгээ авах боломжгүй болов. Орон нутгийн эрх баригчид болон улс төрчдийн зүгээс дүрвэгсдийн эсрэг үг хэллэг нэмэгдэх болсон нь дүрвэгсдийн эсрэг дайсагналыг улам хурцатгав. Дөрөв, тавдугаар сард Ливаны зэвсэгт хүчин Сирийн дүрвэгсдийн гэрт дайран орж, тэдний ихэнхийг нь албадан гаргасан бол есдүгээр сард Ливаны зэвсэгт хүчин Бекаа бүс нутаг болон Арсал хот дахь дүрвэгсдийн хуаранд дайрч, эд хөрөнгийг хураан авчээ. Иордан улсад 2 сая палестин дүрвэгсэд болон 750,000 орчим бусад улсын дүрвэгсэд олон улсын тусламж буурсны улмаас ядууралд нэрвэгдэн, хүнд нөхцөлд амьдарч байна.

Долдугаар сараас эхлэн Тунисын эрх баригчид олон мянган хар арьст цагаач, орогнол хүсэгч, дүрвэгсдийг, тэр дундаа хүүхдүүдийг Ливи, Алжирын хилийн дагуух цөл рүү албадан явуулсан бөгөөд хоол хүнсгүй үлдээсний улмаас 28 хүн амиа алджээ. Ерөнхийлөгч Саиед болон бусад эрх баригчдын зүгээс хар арьст цагаачдын эсрэг урьд өмнө хэзээ ч байгаагүй арьс үндсээр ялгаварлан гадуурхах хүчирхийллийг үйлдсэн. Тунис дахь НҮБ-ын байрны гадаа суулт хийж байсан цагаачид, орогнол хүсэгчид болон дүрвэгсдийн эсрэг цагдаа нар нулимс асгаруулагч хий хэрэглэж, баривчлагдсан жагсагчдыг саатуулах байранд эрүүдэн шүүжээ. Ливи улсад дүрвэгсэд болон цагаачдыг Европын холбооны дэмжлэгтэй эргийн хамгаалалтынхан болон зэвсэгт бүлэглэлүүд далайд саатуулж, Ливид буцаж ирсэн дүрвэгсдийг тодорхой бус хугацаагаар дур мэдэн цагдан хорих эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцах, мөнгө авахаар сүрдүүлэх, албадан ажил хийлгэх зэрэг хүчирхийлэлд өртжээ. Тус улс 22,000 гаруй дүрвэгсдийг Чад, Египет, Нигер, Судан руу хүчээр болон бөөнөөр нь албадан гаргасан.

Саудын Араб улс бичиг баримтгүй цагаачидтай хийх тэмцлийн хүрээнд олон мянган хүнийг албадан нутаг буцаасан. Иран улсад амьдарч буй 5 сая орчим Афган

иргэд үндсэн үйлчилгээ авч чадахгүй байх гэх зэрэг суурь ялгаварлан гадуурхалтад өртжээ. Эрх баригчид Иран руу хууль бусаар нэвтэрсэн Афганчуудыг албадан гаргана гэж сүрдүүлж, зарим мужид Афганчуудыг амьдарч, ажиллахыг хориглов.

Засгийн газрууд дотооддоо дүрвэгсдийг төрөлх нутагтаа сайн дураараа, аюулгүй, нэр төртэй буцаах баталгааг хангах тодорхой арга хэмжээ авах ёстой. Мөн дүрвэгсэд болон цагаачдыг цагаачлалын статусаар нь дур зоргоор баривчлах явдлыг зогсоож, тэднийг цагдан хорих, нутаг буцаах, бөөнөөр нь албадан гаргахдаа эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцахаас хамгаалах ёстой.

ЦААЗААР АВАХ ЯЛ

Бүс нутгийн ихэнх улс цаазаар авах ялыг хэвээр үлдээсэн бөгөөд зарим улсад ижил хүйстнүүдийн зөвшилцсөн бэлгийн харилцаа, улс төр болон шашны үзлээс татгалзах зэрэг олон улсын хуулиар хамгаалагдсан үйлдэл, түүнчлэн хилс хэрэг болон шүүмжлэгчдийг дарангуйлах зорилгоор шүүхээс цаазаар авах ялаар шийтгэсээр байна.. Египет, Иран, Ирак, Саудын Араб зэрэг улсад цаазаар авах ялыг гүйцэтгэсэн. Египетэд цаазаар авах ялыг гүйцэтгэсэн тоо буурсан бол Иранд энэ тоо нэмэгджээ. Ливи улс 2011 оноос хойш зогсоосон цаазын ялын гүйцэтгэлийг дахин сэргээх эрсдэлтэй байв. Саудын Арабын шүүх анх удаа олон нийтийн сүлжээг ашигласан хэргээр цаазаар авах ял оноолоо.

Засгийн газрууд цаазаар авах ялыг халахын тулд цаазаар авах ялын гүйцэтгэлийг нэн даруй түдгэлзүүлэх шаардлагатай.

УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛ

2023 онд уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн өртөмтгий газар нутаг, хүн амд нүүрлэсэн бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлтийн аймшигт үр дагавар болох усны хомсдол, цаг агаарын эрс тэрс нөхцөл байдал зэрэг нь энэ төрлийн эрсдэлд улс орнууд бэлэн бус байгааг харууллаа.

Даниел шуурганы улмаас Ливийн Дерна хотод засвар, тордлогоо муутай хоёр дажан нурсан. Шуурганы улмаас 4540 хүн амиа алдаж, 8500 хүн сураггүй болж, 44000 гаруй хүн дүрвэжээ. Алжирт урьд өмнө тохиолдож байгаагүй хэт халалтын улмаас 140 гаруй түймэр гарч, 34 орчим хүн амиа алдаж, 1500 гаруй хүн дүрвэжээ. Мароккод агаарын температур түүхэн дээд цэгтээ хүрсэн бөгөөд Агадирт 50 хэмээс дээш гарсан байна. Ирак, Сири улс ган гачигт нэрвэгдсэн.

Түүнчлэн бүс нутгийн улс орнууд чулуужсан түлшний үйлдвэрлэлд уламжлалт бизнесийн хандлага баримталсан хэвээр байгаа нь дэлхийн дулаарлыг 1.5 хэмээс доош барих зорилтыг хэрэгжихгүйд хүргэхийн зэрэгцээ байгаль орчны доройтолд зохих хариу арга хэмжээ авч чадсангүй. Ирак улс нефтийн борлуулалтын орлогоороо түүхэн дээд амжилт тогтоож, шинэ цооног өрөмдөн газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаагаа зарлав. Саудын Араб 2027 он гэхэд олборлолтоо өдөрт ойролцоогоор 1 сая баррелиар, 2030 он гэхэд байгалийн хийн олборлолтоо 50%-иар нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаагаа зарласан нь чулуужсан түлшийг үе шаттайгаар зогсоох тухай олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтэд асуудал үүсгэж, чулуужсан түлшний хэрэглээг бууруулах G20 санаачилгыг гацаахад хүргэж байна. Саудын Араб улс нь COP28-ийн чулуужсан түлшийг үе шаттайгаар зогсоох талаарх шийдвэрийг хамгийн хүчтэй эсэргүүцэгчдийн нэг байсан. Кувейт улс чулуужсан түлшний үйлдвэрлэлээ 2035 он хүртэл нэмэгдүүлэх төлөвлөгөөгөө хэвээр үлдээсэн бөгөөд төрийн өмчит Кувейт газрын тосны компани 2028 он гэхэд газрын тосны үйлдвэрлэлээ өргөжүүлэхэд 40 гаруй тэрбум ам.доллар зарцуулна гэдгээ

зургаадугаар сард зарласан. Катар улс шингэрүүлсэн газрын хийн үйлдвэрлэлээ өргөжүүлэв. Оман улс хэдийгээр сэргээгдэхгүй эрчим хүчний эх үүсвэрийн үйлдвэрлэлээс хамааралтай хэвээр байгаа боловч нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах хөтөлбөрийг эхлүүлж, 2030, 2040, 2050 онуудад нүүрсхүчлийн хийг саармагжуулах зорилтод анхаарлаа хандуулахаар зарлав.

COP28-ын ерөнхийлөгч Султан Аль Жабер тэргүүтэй дэлхийн хамгийн том нүүрс төрөгчийн үйлдвэрлэгчдийн нэг болох төрийн өмчит Абу Даби үндэсний газрын тосны компани чулуужсан түлшээ эрчимтэй өргөжүүлэхээр төлөвлөж байгаагаа мэдэгдсэнтэй холбоотойгоор АНЭУ-ыг COP28-ын зохион байгуулагчаар сонгосон нь маргаан дагуулав.

Арванхоёрдугаар сард болсон COP28-аар улс орнууд анх удаа чулуужсан түлшний талаарх шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн боловч чулуужсан түлш үйлдвэрлэгчид болон улс орнуудад одоогийн арга барил, хандлагаа үргэлжлүүлэх боломжийг олгох цоорхойг хэвээр үлдээх зэргээр шаардлагатай хүлээлтийг шийдвэрлэж чадсангүй. Улс орнууд, тэр дундаа уур амьсгалын хямралын эсрэг томоохон үүрэг хүлээсэн улс орнууд бусад улс орнууд цэвэр эрчим хүч рүү шилжих, эсхүл уур амьсгалын хямралын сөрөг нөлөөнд дасан зохицоход нь туслах уур амьсгалын санхүүжилтийн талаар хангалттай амлалт өгөөгүй бөгөөд алдагдал, хохирлын сангийн үйл ажиллагаагаа явуулах талаар хангалттай арга хэмжээ авсангүй.

Засгийн газрууд уур амьсгалын хямралыг бууруулах арга хэмжээг яаралтай авч, дэлхийн дулаарлыг аж үйлдвэржилтийн өмнөх үеийнхээс 1.5 хэмээс хэтрүүлэхгүй байх, тэр дундаа нүүрсхүчлийн ялгаруулалтыг (ялангуяа түхэн ялгаруулалтад хамгийн их үүрэг хүлээсэн) хязгаарлаж, чулуужсан түлш үйлдвэрлэлийн санхүүжилтийг зогсоох яаралтай арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай. Шаардлагатай нөөц бүхий улс орнууд тусламж, дэмжлэг шаардлагатай байгаа улс орнуудад уур амьсгалын хямралын үр дагаврыг бууруулах, дасан зохицох арга хэмжээг хүний эрхэд нийцсэн байдлаар хэрэгжүүлэхэд нь олгох санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагатай.

ЭРҮҮДЭН ШҮҮХ, БУСАД ЗҮЙ БУС ХАРЬЦАА

Египет, Иран, Ливи, Саудын Араб, Сири зэрэг улс орнуудын албан болон албан бус цагдан хорих газруудад эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцах явдал гарсаар байгаа бөгөөд зарим тохиолдолд үхэлд хүргэж байна. Мөн Алжир, Ирак, Израйль болон Палестины эзлэгдсэн нутаг дэвсгэр, Ливан, Марокко, Палестин болон АНЭУ-д эрүүдэн шүүх, бусад зүй бусаар харьцсан талаарх мэдээлэл үргэлжилсээр байна. Эрүү шүүлтийг ихэвчлэн “хэрэг хүлээлгэх” зорилгоор ашигладаг бөгөөд зодох, цахилгаанд цохиулах, хуурамчаар цаазлах, биеийг нь таагүй байршилд хүлэх, эсхүл гавлах, хүчиндэх болон бусад бэлгийн хүчирхийлэл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, удаан хугацаагаар ганцаарчлан хорих зэрэг аргыг хэрэглэдэг.

Египетэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхээс санаатайгаар татгалзах, ганцаарчлан удаан хугацаагаар хорих, хурц гэрлээр шарах, хяналтын камераар тогтмол ажиглах, гэр бүлийнхэнтэйгээ уулзахыг хориглох зэргээр эрүү шүүлт болон бусад зүй бусаар харьцах явдал хорих анги, цагдаагийн газар, Үндэсний аюулгүй байдлын агентлагийн харьяа газруудад хэвийн мэт үзэгдэл болсон. Ливи, Иран улсад эрүүдэн шүүх, бусад зүй бусаар харьцах явдал өргөн хүрээнд, системтэй байдалтай байсан бөгөөд эрүүдэн шүүх журмаар “хэрэг хүлээсэн мэдүүлгүүдийг” олон нийтэд

цацдаг. Бүс нутаг даяар баримтжуулсан эрүүдэн шүүлт болон цагдан хорих газар нас барсан сэжигтэй бараг бүх тохиолдолд эрх баригчид мөрдөн шалгах ажиллагаанд зохистой байдлаар хэрэгжүүлж чадсангүй. Шүгэл үлээгч Мохамед Бенхлима өнгөрсөн долдугаар сард Алжирын шүүхэд хууль сахиулагчид түүнийг нүцгэлж, хөл, гарыг нь боож, хүйтэн ус асгаж эрүүдэн шүүсэн, мөн бэлгийн дарамт үзүүлж, зодож, заналхийлсэн хэмээн мэдэгдсэн. Шүүгч түүний гомдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулаагүй бөгөөд түүнд долоон жилийн хорих ял оноожээ.

Засгийн газрууд эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцсан гэмт хэргийг хараат бус, шударга, үр дүнтэй мөрдөн шалгах баталгааг хангаж, эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

ЯЛ ЗАВШИХ

Бүс нутгийн улс орнууд хүний эрхийг ноцтой зөрчсөн гэмт хэрэгтнүүд зохих шийтгэл хүлээхгүй байх явдлыг өөгшүүлсээр байгаа нь дотоодын шударга ёсны тогтолцоонд нүүрлэсэн гүнзгий хямралыг онцлоход хүргэж байна.

Египетэд 2023 он болон сүүлийн 10 жилийн хугацаанд үйлдэгдсэн олон улсын эрх зүйг зөрчсөн гэмт хэрэг болон хүний эрхийг ноцтой зөрчсөн бусад гэмт хэрэг, тэр дундаа 2013 оны 8 дугаар сард огцорсон ерөнхийлөгч Мохамед Морсийг дэмжигчдийн суултыг хүч хэрэглэн тараах үеэр дор хаяж 900 хүнийг хууль бусаар хөнөөсөн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд ял шийтгэл хүлээлгэсэнгүй. Мөн 2020 онд Ливан улсад 236 хүнийг үхэлд хүргэсэн Бейрут боомтын дэлбэрэлтийг мөрдөн шалгах ажиллагаа тухайн хэрэгт холбогдогч улс төрчдийн зүгээс шүүхийн эсрэг гаргасан гомдлын улмаас 2021 оны арванхоёрдугаар сараас хойш түдгэлзсэн хэвээр байна. Иран улсад 2023 он болон өнгөрсөн жилүүдэд үйлдэгдсэн хууль бус аллага, хүчээр алга болгох, эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах, тэр дундаа хүчингийн болон бэлгийн хүчирхийллийн бусад хэлбэр, олон улсын эрх зүйн гэмт хэрэг, хүний эрхийн ноцтой зөрчилд төрийн нэг ч албан тушаалтанд хариуцлага хүлээгээгүй.

Олон улсын хамтын нийгэмлэг хүний эрхийн зөрчилд хариуцлага хүлээдэг байх баталгааг хангаж чадсангүй. Гуравдугаар сард НҮБ-ын Ливийн асуудлаарх бие даасан баримт судлах хороо эцсийн тайландаа “Улсын аюулгүй байдлын хүчин болон зэвсэгт цэргийн бүлэглэлүүд олон төрлийн дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн байх үндэслэлтэй” хэмээн дүгнэсэн. Гэвч НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл дээрх хорооны бүрэн эрхийг сунгасангүй. Триполид төвтэй Прокурорын газраас Даниел шуурганы дараах үхэл, сүйрэл дагуулсан хэргийг шалгах хараат бус, бие даасан, нээлттэй, үр дүнтэй мөрдөн шалгах ажиллагаа, түүний дотор Ливийн эрх баригчид болон бодитоор хяналт хэрэгжүүлж байгаа хүмүүс хүн амынхаа амьд явах эрхийг хамгаалж чадаагүй талаарх хэргийг шалгах зэрэг асуудалд санаа зовниж байгаагаа илэрхийлсэн.

Засгийн газрууд хүний эрхийн зөрчил, олон улсын гэмт хэргийг нарийн нягт, хараат бус, шударга, үр дүнтэй, ил тод байдлаар мөрдөн шалгах, гэмт хэрэг үйлдсэн сэжигтнүүдийг иргэний шүүхээр шударгаар шүүх замаар ял шийтгэлгүй үлдэх явдлын эсрэг тэмцэх ёстой.

ДЭЛХИЙ ДАХИНЫ ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2024 ОНЫ 4 ДҮГЭЭР САР

Эмнести Интернэшнл нь жил бүр дэлхийн хүний эрхийн төлөв байдлыг баримтжуулдаг. Бидний судалгаа дэлхий дахинд эрх баригчид хүний түгээмэл эрх чөлөөнд халдсаар байгааг харууллаа. Улс орнууд болон зэвсэгт бүлэглэлүүд дайны дүрмийг зөрчиж байгаа бөгөөд зарим зэвсэгт мөргөлдөөн, түүнд үзүүлэх хариу арга хэмжээний үндэс нь арьс үндсээр ялгаварлан гадуурхах явдал байлаа. Эдийн засгийн хямрал, үүр амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтолд нийгмийн эмзэг бүлгийнхэн илүүтэй өртөж байна. Эдгээр гадуурхагдсан бүлгийн эрхийн төлөө кампанит ажил өрнүүлж байгаа хүний эрх хамгаалагчид нь өөрөөр сэтгэгчдийг өргөн хүрээнд нухчин дарах кампанит ажлын бай болж байна. Охид, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийн эрхийн эсрэг тэмцэл хурцадлаа. Арьс үндсээр ялгаварлан гадуурхагдсан зарим бүлгийн эсрэг үзэн ядалтыг өдөөн түрхирсан, бусад хор хөнөөлтэй контентыг цахим орчинд нийтлэх нь нэмэгджээ. Үүний зэрэгцээ хиймэл оюун ухааны дэвшлийг эрх чөлөөг хязгаарлах, хүний эрхийг зөрчихөд хэрэглэлээ.

Энэхүү тайланд 2023 онд дэлхийн 155 улс оронд гарсан хүний эрхийн асуудлыг баримтжуулж, дэлхий дахин, бүс нутгийн түвшинд холбож, ирээдүйд гарах үр дагаврыг тодорхойллоо. Түүнчлэн засгийн газрууд, бусад талууд дээрх сорил бэрхшээлийг даван туулж, дэлхий даяарх хүмүүсийн амьдралыг сайжруулахын тулд хийж, хэрэгжүүлэх ёстой арга хэмжээг дурдлаа. Энэхүү тайлан нь бодлого боловсруулагч, удирдагч, нөлөөлөгч, идэвхтнүүд болон хүний эрхийг сонирхож буй хүн бүхэнд зайлшгүй унших материал байх болно.

www.amnesty.org
www.amnesty.mn

